

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-9
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	10-84

1. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	11-12
2. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин нарын 2 гишүүн 2025.12.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	12-48
3. БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн 2025.12.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	49-61
4. Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал	61-62
5. Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны үйл ажиллагааны тайлан сонсох	62-73
6. Үндэсний статистикийн хорооны 2025 оны үйл ажиллагааны тайлан сонсох	73-84

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
4 дүгээр сарын 21-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 15 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Н.Батсүмбэрэл, Ш.Бямбасүрэн, Ж.Золжаргал,
Ч.Лодойсамбуу, О.Цогтгэрэл;
Чөлөөтэй: П.Батчимэг, З.Мэндсайхан, Р.Сэддорж, Д.Үүрийнтуяа;
Тасалсан: Ч.Анар, Ц.Баатархүү.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд хэлэлцэх асуудлын 7 дугаарт байгаа бусад асуудлын хүрээнд тодорхой чиглэл, мэдээлэл ирээгүй тул хойшлуулав.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал хэлэлцэх асуудлын 6 дугаарт байгаа “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын 1 дүгээрт хэлэлцэх горимын санал гаргав.

Л.Соронзонболд: Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 6
Бүгд: 19
68.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын 1 дүгээрт хэлэлцэхээр тогтов.

Нэг. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Х.Шижирмөнх нар байлцав.

Тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа, Г.Очирбат нар үг хэлэв.

Л.Соронзонболд: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 6
Бүгд: 19
68.4 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин нарын 2 гишүүн 2025.12.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын гүйцэтгэх захирал Ц.Магнайбаатар, мөн танхимын Гадаад худалдааны баримт бичиг баталгаажуулалтын газрын дарга Э.Бадамхорол, мөн газрын хуульч Ц.Золбаяр, Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгчийн зөвлөх М.Сарандаваа, Монголын олон улсын арбитрын Ерөнхий нарийн бичгийн дарга М.Шинэбаяр, Өмгөөллийн “Хэруга партнерс” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гүйцэтгэх захирал Л.Загдаа, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Б.Эрхбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Х.Шижирмөнх нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Г.Уянгахишиг, С.Эрдэнэбат, Б.Заяабал, О.Батнайрамдал, Б.Мөнхсоёл, Г.Очирбат, Б.Жаргалан, М.Мандхай нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Х.Ганхуяг, Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын гүйцэтгэх захирал Ц.Магнайбаатар, мөн танхимын Гадаад худалдааны баримт бичиг баталгаажуулалтын газрын дарга Э.Бадамхорол, Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгчийн зөвлөх М.Сарандаваа, Өмгөөллийн “Хэруга партнерс” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Л.Загдаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Г.Очирбат, Б.Жаргалан, М.Мандхай нар үг хэлэв.

Л.Соронзонболд: Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 11
Бүгд: 21
47.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хамт өргөн мэдүүлсэн:

Л.Соронзонболд: 1.Худалдаа, аж үйлдвэрийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 12
Бүгд: 21
42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 12
Бүгд: 21
42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 12
Бүгд: 21
42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 13
Бүгд: 21
38.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 13
Бүгд: 21
38.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 14
Бүгд: 21
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 14
Бүгд: 21
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

8.Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 16
Бүгд: 21
23.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

9.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 13
Бүгд: 21
38.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

10.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 13
Бүгд: 21
38.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

11.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 13
Бүгд: 21
38.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

12.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /Шинэчилсэн найруулга/-хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 14
Бүгд: 21

33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн 2025.12.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн Хууль, эрх зүйн газрын дарга Э.Уянга, Монголын Хуульчдын холбооны Удирдах зөвлөлийн гишүүн Д.Болд-Эрдэнэ, мөн холбооны гишүүн Ц.Мөнхбат, Өмгөөллийн “Грандлекс партнерс” ХХК-ийн өмгөөлөгч Ж.Дамбаасүрэн, “Бороогоулд” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Цэрэнбадам, “Төв тусгал” сургалт, судалгааны төвийн судлаач Э.Сундуй нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Т.Билэг-Өрнөх нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Б.Уянга, Б.Жаргалан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн Хууль, эрх зүйн газрын дарга Э.Уянга, “Бороогоулд” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Цэрэнбадам, Монголын Хуульчдын холбооны гишүүн Ц.Мөнхбат, Өмгөөллийн “Грандлекс партнерс” ХХК-ийн өмгөөлөгч Ж.Дамбаасүрэн, нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг үг хэлэв.

Л.Соронзонболд: БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 9
Бүгд: 21
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

Л.Соронзонболд: 1.Онц байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 11
Бүгд: 21
47.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Т.Билэг-Өрнөх нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд тогтоолын төсөл болон Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг, Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүнээс ирүүлсэн албан бичгүүдийг тус тус танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Л.Соронзонболд: Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүнийг Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 8
Бүгд: 21
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны үйл ажиллагааны тайлан сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн бөгөөд дэд дарга Н.Хүдэрчулуун, мөн хорооны Ажлын албаны даргын албан үүрийг түр орлон гүйцэтгэгч С.Цогтгэрэл, Даатгалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Батболд, Хадгаламж, зээлийн хоршооны газрын дарга Ц.Алтантуул, Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батчимэг, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил, Үнэт цаасны газрын ахлах зөвлөх А.Нинжин, Хяналт шалгалт, зохицуулалтын газрын ахлах зөвлөх А.Баянмөнх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын зөвлөх Б.Алтантуяа, референт Ч.Сарантуяа, Ц.Элбэгзаяа нар байлцав.

Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны үйл ажиллагааны тайланг Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Н.Хүдэрчулуун танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, О.Батнайрамдал, Л.Соронзонболд нарын тавьсан асуултад Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Н.Хүдэрчулуун хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, Л.Соронзонболд нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны үйл ажиллагааны тайланг сонслоо.

Уг асуудлыг 19 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Үндэсний статистикийн хорооны 2025 оны үйл ажиллагааны тайлан сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, мөн хорооны дэд дарга Д.Лхамсүрэн, Тамгын газрын дарга Б.Лхагва, Өгөгдлийн бодлого, бүртгэл статистикийн газрын дарга Ш.Ариунболд, Мэдээллийн технологи, өгөгдлийн инженерчлэлийн газрын дарга Ц.Эрдэнэмөнх, Эдийн засгийн статистикийн газрын дарга М.Оюунжаргал, мөн газрын Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэлийн статистикийн хэлтсийн дарга Э.Мягмарханд, Нийгмийн статистикийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Даваажаргал, мөн газрын Өрхөд суурилсан судалгааны хэлтсийн дарга Л.Ундрал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын зөвлөх Б.Алтантуяа, референт Ч.Сарантуяа, Ц.Элбэгзаяа нар байлцав.

Үндэсний статистикийн хорооны 2025 оны үйл ажиллагааны тайланг Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Б.Пунсалмаа, О.Батнайрамдал, Л.Соронзонболд нарын тавьсан асуултад Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Үндэсний статистикийн хорооны 2025 оны үйл ажиллагааны тайланг сонслоо.

Уг асуудлыг 19 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 4 цаг 36 минут үргэлжилж, 32 гишүүнээс 21 гишүүн хүрэлцэн ирж, 65.6 хувийн ирцтэйгээр 19 цаг 51 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

2026 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
15 цаг 15 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Л.Соронзонболд: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Ринчендоржийн Батболд, Отгоншарын Батнайрамдал, Хүрэлбаатарын Булгантуяа, Жамбалын Ганбаатар, Болдын Жавхлан, Батжаргалын Заяабал, Ганзоригийн Лувсанжамц, Баатаржавын Мөнхсоёл, Эрдэнэбилэгийн Одбаяр, Ганбатын Очирбат, Бадамдоржийн Пунсалмаа, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Агваанлуvsангийн Ундраа, Болдын Уянга, Гончигдоржийн Уянгахишиг, Саруулсайханы Цэнгүүн, Мөнхчулууны Энхцэцэг, Сүхбаатарын Эрдэнэбат гэсэн гишүүд өнөөдрийн хуралдаандаа хүрэлцэн ирсэн байна. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 56,3 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин, Ганхуяг нараас 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

2 дугаарт, БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

3 дугаарт, “Зарим дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” асуудал

4 дүгээрт Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны үйл ажиллагааны тайлан Улсын Их Хуралд 2026 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр ирүүлсэн, хэлэлцэх

5 дугаарт Үндэсний статистикийн хорооны 2025 оны үйл ажиллагааны тайлан Улсын Их Хуралд 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөр ирүүлсэн, хэлэлцэх

6 дугаарт Байнгын хорооны тогтоолын төсөл “Ажлын хэсэг байгуулах тухай”

7 Бусад гэсэн ийм 7 асуудал хэлэлцүүлэхээр энэ 7 хоногийн тов дарааллыг Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөс баталсан байна. Үүнээс бусад гэсэн асуудлын хүрээнд хэлэлцүүлэх асуудлын талаар тодорхой чиглэл, мэдээлэл ирээгүй тул өнөөдрийн хэлэлцүүлэх асуудлаас түр хойшлуулж байна.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу. Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе. Дарга аа, нөгөө хэлэлцэх асуудлын 5 дугаарт бичигдсэн байх шиг байна лээ. 6 дээр бичигдсэн байна. Мэргэжлийн нэгдсэн холбоодын эрх зүйн байдлын тухай хуульд цэцийн дүгнэлт гараад, Улсын Их Хурал түрүүчийн 7 хоногт хүлээж авсан байгаа юм. Тэгэхээр Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт хүлээж авсантай холбоотойгоор хуулийн өөрчлөлтийг бид нар хуулийн хугацаанд нь буюу 15 хоногийн дотор өргөн барьж, батлуулах ёстой байгаа юм. Тэгэхээр хугацаатай жоохон уралдаж байгаа асуудал байгаа юм. Тийм учраас гишүүдийн ирц бүрдсэн дээр энэ Цэцийн дүгнэлттэй холбоотой яг Эдийн засгийн байнгын хороон дээр байгуулагдах ажлын хэсгийг батлах асуудлыг эхэнд тавьж, баталж өгнө үү гэж санал гаргах гэсэн юм. Тэгэхээр дараалалдаа 6-аас 1 дүгээрт, эхнийх дээр оруулаад, ажлын хэсгийг яаралтай байгуулж өгнө үү гэж хүсье.

Л.Соронзонболд: Батнайрамдал гишүүний горимын саналаар санал хураалтыг явуулъя. Гишүүд санал хураалтаа бэлтгэе. Батнайрамдал гишүүний горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Батнайрамдал гишүүний горимын санал 68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Эхний асуудал Батнайрамдал гишүүний горимын саналаар шилжиж, Байнгын хорооны тогтоолын төслийг эхэнд хэлэлцэхээр боллоо.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1, 8.2, 8.3, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 2 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч О.Батнайрамдал Улсын Их Хурлын гишүүн, гишүүд Н.Батсүмбэрэл Улсын Их Хурлын гишүүн, Б.Пунсалмаа Улсын Их Хурлын гишүүн, А.Ундраа Улсын Их Хурлын гишүүн, С.Эрдэнэбат Улсын Их Хурлын гишүүн.

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр эрдэмтэн судлаач, шинжээчид, холбогдох байгууллагын албан хаагчдыг татан оролцуулахыг ажлын хэсэг О.Батнайрамдалд зөвшөөрсүгэй.

Эдийн засгийн байнгын хорооны дарга Сэддорж.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Ундраа гишүүний микрофоныг өгье.

А.Ундраа: Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Маш олон ажлын хэсэг давхцаад байгаа дарга аа. Тэгээд би энэ дээр орж ажиллах зав гарахгүй байх.

Л.Соронзонболд: Очирбат гишүүний микрофоныг нээе.

Г.Очирбат: Энэ асуудалтай холбоотой бас Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль явж байгаа. Мөн дээрээс нь Танхимын тухай хууль, мөн дээр дээрээс нь Үндсэн хуулийн цэцтэй холбоотой Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль гээд энэ 3 хоорондоо их хамаараад байгаа юм. Тэгэхээр энэ ажлын хэсэгт бас орох сонирхолтой байгаа. Тэгээд ажлын хэсэгт оруулж өгнө үү. Ундраа гишүүн ажилтай болохоор нэрээ татаж байгаа юм байна. Тэгэхээр оронд нь оруулж өгнө үү гэж хүсэж байна.

Л.Соронзонболд: Ундраа гишүүний хүсэлтээр Ундраа гишүүнийг ажлын хэсгээс чөлөөлж, Очирбат гишүүнийг оруулаад ингээд энэ ажлын хэсэг байгуулах тухай тогтоолын төслийг баталъя гэдгээр санал хураалт явуулж эхэлье. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 68,4 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

15.23 цаг.

Хэлэлцэх асуудал 2.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн талаарх хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин танилцуулна. Энхтүвшин гишүүний микрофоныг нээнэ үү.

Д.Энхтүвшин: Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Аж ахуйн нэгж, байгууллагуудын худалдаа, үйлдвэрлэлийг дэмжих, тэдгээрийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилготой Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль 1995 онд батлагдсан бөгөөд өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Зах зээлийн эдийн засгийн шилжилтийн эхэн үед батлагдсан Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль хэрэгжиж эхэлснээс

хойш 30 жилийн хугацаанд манай улсын эдийн засаг, хууль эрх зүй, бизнесийн орчин, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл, засаглал, хэлбэр, томоохон өөрчлөлтүүд гарсан байна.

1995 онд Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль батлагдах үед. Манай Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 651 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 90 их наяд хүрч, 138 дахин тэлсэн байна.

Мөн 1998 онд хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын тоо 16 мянга орчим байсан бол 2025 оны байдлаар 263 мянган аж ахуйн нэгж бүртгэгдэж үүнээс 116 мянган аж ахуйн нэгж идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Өнгөрсөн хугацаанд Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуульд бусад хуулийг дагалдуулах байдлаар зарим нэр томъёог өөрчлөх, найруулгын шинжтэй 4 удаагийн нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Тус хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг 26 жилийн дараа буюу 2021 онд хийсэн ба хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг дараах байдалтайгаар үнэлсэн байна. Үүнд:

1 дүгээрт нь танхим нь аж ахуйн нэгж, байгууллагуудын хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх, хамгаалах асуудлаар төрийн байгууллагатай харилцах эрх зүйн орчин сул.

2 дугаарт төрөөс эдийн засгийн бодлого боловсруулахад танхимын оролцох оролцоо тодорхойгүйгээс аж ахуй эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг төлөөлөн төрийн байгууллагад гаргаж буй саналыг хүлээн авах нь бага.

3 дугаарт танхимын тогтолцоог бүс нутгийн зарчимд тулгуурлан байгуулах нь практикт хэрэгждэггүйгээс гадна 21 аймгийн салбар танхимууд бие даан үйл ажиллагаа явуулах чадамжгүй зэргээр үнэлсэн байна.

Хуулийн хэрэгжилтийн үнэлгээнээс үзэхэд Худалдаа, аж үйлдвэрийн танхимын одоогийн бүтэц тогтолцоо, гишүүнчлэл, санхүүжилт, зорилт, чиг үүргийг өнөөгийн эдийн засаг бизнесийн нөхцөл байдалтай уялдуулан өөрчлөх хэрэгцээ шаардлага бий болсон байна.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 109 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 7.1-д бизнес эрхлэх орчныг сайжруулж, зах зээл дэх төрийн оролцоог багасгах, шударга өрсөлдөөнийг дэмжих, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах татварын болон гаалийн шинэчлэлийг гүнзгийрүүлж, Монгол Улсын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр тэргүүлэх 50 орны 1 болно гэж, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.3.1-д нийгмийн зөвшилцөлд үндэслэн шийдвэр гаргах түвшинд иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшилтэй зөвшилцөх, санал авах, гарсан шийдвэрүүдийн биелэлтэд хяналт тавихад оролцдог оновчтой тогтолцоог бүрдүүлнэ гэж. Мөн 4.2.2.3-д төр, хувийн хэвшил, иргэний нийгэмтэй хамтран ажиллахыг эрэлхийлдэг, тэдгээрийн оролцоог шийдвэр гаргах үйл явцдаа хангаж ил тод байдлыг бий болгосон төрийн шинэ тогтолцоог бий болгоно гэж тус тус заасан байна.

Иймд эдийн засаг, бизнесийн орчин, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид тулгамдаж байгаа нийтлэг асуудлыг шийдэх, зохион байгуулалтыг сайжруулах

хэрэгцээ шаардлагад нийцүүлэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 22.1.3-д заасан хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахад ХБНГУ, Бүгд Найрамдах Франц Улс, Унгар Улс, Япон Улс, Бүгд Найрамдах Солонгос, Бүгд Найрамдах Казакстан Улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын эрх зүйн байдлыг зохицуулсан хууль тогтоомжуудыг харилцуулан судалж олон улсын жишиг зохицуулалтыг харгалзан Монголын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн бүтэц, зохицуулах асуудлуудын цар хүрээг тодорхойлж, улсын эдийн засаг, гадаад, дотоод худалдаа, хүн ам зүйн тархалт, аж ахуй эрхлэгчдийн төвлөрөл, боловсон хүчний нөхцөл байдал Худалдаа, аж үйлдвэрийн танхимын олон улсын нийтлэг бүтцэд тулгуурлан боловсрууллаа.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах зарчмын өөрчлөлт орохоор тусгасан.

1 дүгээрт өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиар Худалдаа, аж үйлдвэрийн танхимыг бүс нутгийн зарчмаар хэрэгжүүлэхээр зорьсон боловч 25 жилийн хугацаанд ганцхан Улаанбаатар хотын танхим 2015 онд байгуулагдсан байна. Мөн 2025 онд үндэсний статистикийн мэдээгээр улсын хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 116 мянган аж ахуйн нэгжийн 70-аас дээш хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна. Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь олон улсын жишиг тогтсон, тодорхой зохион байгуулалт, бүтэцтэй байгууллага бөгөөд үйл ажиллагаа нь нийт улсын хэмжээнд хэрэгжиж, эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулдаг байна. Иймд цаашид бүс нутгийн зарчмаар биш аж ахуйн нэгжүүдийн явуулж байгаа үйл ажиллагааны чиглэл, онцлог, салбар зэргийг харгалзан эдийн засгийн үйл ажиллагааны салбар бүрд нэг салбарын танхим, тухайн аймаг, нийслэл, нийслэлийн танхим тус тус байгуулан ажиллахаар тусгаж, чиг үүрэг, уялдаа холбоог тодорхойллоо. Ингэснээр аж ахуйн нэгжүүд өөрсдийн үйл ажиллагааны чиглэлд хамаарах эдийн засгийн салбар танхимд нэгдэн тухайн салбарын хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах, хүний нөөцийн бодлогыг тодорхойлох, тухайн салбарын илүү нарийвчилсан судалгаа шинжилгээ хийх зэргээр тулгамдаж буй асуудлыг нэгтгэн боловсруулж харьяалах төрийн захиргааны байгууллагатай хамтран бодлогын баримт бичиг, хууль, дүрэм, журам боловсруулахад дэмжлэг үзүүлэх боломж бүрдэнэ.

2 дугаарт Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх орчныг сайжруулах, эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль, ёсны ашиг сонирхлыг төрийн байгууллагад төлөөлөх, төлөөлөн илэрхийлэх хамгаалах үндсэн зорилготой. Хуульд заасан дээрх зорилгын хэрэгжилттэй холбогдуулан 2002 онд 1600 аж ахуйн нэгжээс судалгаа явуулахад оролцогчдын 80 хувь нь бизнесийн холбогдолтой бодлого, хууль, дүрэм журам, шийдвэр гаргах процесст оролцоо муу, маш муу гэж хариулсан байна. Иймд Монгол Улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг, эдийн засгийн салбарын бодлого боловсруулахад оролцох мөн төрийн байгууллагын дэргэд зөвлөл, хороо, комисс, ажлын хэсэг байгуулахад бүрэлдэхүүнд нь танхимын төлөөллийг оролцуулах замаар аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийтлэг эрх ашиг, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн илэрхийлэх боломжтой байхаар тусгалаа.

Түүнчлэн Үндэсний танхим нь хууль эсвэл Засгийн газрын шийдвэрээр шилжүүлсэн төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлж болохоор хуулийн төсөлд тусгасан бөгөөд энэхүү зохицуулалт нь төрийн байгууллагын ачаалал, зардлыг тодорхой хэмжээнд бууруулах эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

3.2021 оны байдлаар Монгол Улсад 3762 бизнес, мэргэжлийн холбоо, эвлэл идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа гэж бүртгэгдсэн байна. Үүнээс 65 хувь нь 1-2 ажилтантай, 86 хувь нь 5 хүртэлх ажилтантай байгаа нь эдгээр төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын ихэнх нь хүний нөөцийн дутагдалтай байгааг харуулж байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллээс үзэхэд зөвхөн барилгын салбарт 24, аялал жуулчлалын салбарт 80, уул уурхайн салбарт 92, хүнсний салбарт 102 төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод бүртгэлтэй байгаа ч нийтэд мэдэгдэж үйл ажиллагаа явуулж байгаа нь эдгээр салбар тус бүрээс 4-10 орчим л байна. Энэ нь салбарын төлөөлөх чадамж, чадавх сул, зарим салбарын төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод нэгдмэл бус байгааг харуулж байна.

Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимаас бизнесийн холбогдолтой бодлого боловсруулахад бизнес эрхлэгчдийн оролцооны түвшнийг тодорхойлох судалгаа явуулахад бизнес эрхлэгчдийн 91 хувь нь Монгол Улсад шийдвэр гаргах түвшинд бизнесийн холбогдолтой төрийн бус байгууллагуудын нөлөөлөл сул нөлөөтэй гэж хариулсан байна. Иймд аймаг, нийслэлийн болон салбарын танхимыг байгуулах, түүний гишүүнчлэл, удирдлага, зохион байгуулалттай холбогдох харилцааг хуулийн төсөлд тусгалаа. Аймаг, нийслэлийн танхимыг тухайн аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа 50-аас доошгүй тооны аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдүүд сайн дурын үндсэн дээр нэгдэн байгуулж, үйл ажиллагаагаа бие даан хэрэгжүүлэх бөгөөд аймгийн танхим байгуулагдаагүй 2 болон түүнээс дээш аймгийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдүүд нэгдэж аймаг дундын танхим эсвэл хэд хэдэн аймгийн танхим хоорондоо нэгдэж аймаг дундын танхим байгуулж болохоор тусгасан. Харин салбарын танхимыг эдийн засгийн үйл ажиллагааны тодорхой нэг салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 50-аас доошгүй аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдүүд сайн дурын үндсэн дээр нэгдэн байгуулж үйл ажиллагаагаа бие даан хэрэгжүүлэх бөгөөд хэд хэдэн салбарын танхим нэгдэж салбар дундын танхим байгуулж болохоор тусгасан.

Мөн эдийн засгийн салбартаа олонхын төлөөллийг нэгтгэн идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа ашгийн төлөө бус хуулийн этгээдэд салбар танхимын чиг үүргийг гэрээний үндсэн дээр шилжүүлж болохоор тусгасан.

4. хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар иргэн, хуулийн этгээд нь үйл ажиллагааны чиглэл харгалзахгүй Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимд гишүүнээр элсэх боломжтой. Тодорхой эдийн засгийн салбар бүс нутгийг харгалзахгүй нэгдэл нь аливаа асуудлыг тоймлон ерөнхий авч хэлэлцэхэд хүргэдэг. Дээрх асуудлыг шийдэх хүрээнд аймаг, нийслэлийн болон салбарын танхимууд Монголын Үндэсний танхимын гишүүн байх, харин аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд нь өөрийн үйл ажиллагаа явуулж байгаа эдийн засгийн үйл ажиллагааны тодорхой нэг салбарын танхим эсвэл харьяа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хамаарах аймаг нийслэлийн танхимд сайн дурын үндсэн дээр гишүүнээр элсэж болохоор тусгалаа. Тодруулбал аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд нь Монголын Үндэсний танхимд гишүүнээр элсэхгүй бөгөөд өөрийн үйл ажиллагаа явуулж байгаа эдийн засгийн үйл ажиллагааны тодорхой нэг

салбарын танхим, эсвэл өөрийн харьяа аймаг, нийслэлийн танхимд гишүүнээр сайн дурын үндсэн дээр элсэж болно.

5.Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээгээр танхим төрийн байгууллагын харилцаа сул гэж үнэлэгдсэн бөгөөд хуулийн төсөлд Худалдаа, аж үйлдвэрийн танхимаас төрийн байгууллага, албан тушаалтантай харилцах зохицуулалтыг тусгасан.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар доор дурдсан үр дагавар гарна гэж үзэж байна.

1 дүгээрт Худалдаа, аж үйлдвэрийн танхимын бүтэц, зохион байгуулалт, түүний бүрэн эрх тодорхой болсноор аж ахуй эрхлэгчид ялангуяа жижиг дунд бизнес эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах, хамтын удирдлагын байгууллагуудаар дамжуулан дуу хоолойгоо төр болон олон нийтэд хүргэх бололцоо, боломж нэмэгдэнэ.

2 дугаарт Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тогтолцоонд үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 1 танхим, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар дагнан байгуулагдсан салбар танхим болон аймаг, нийслэлд байгуулагдах салбар танхимуудаас бүрдэх тул тодорхой бизнес, эдийн засгийн салбарын аж ахуй эрхлэгчид нь тус бүрийн салбарын асуудлаа харьяалагдах салбарын танхим дээрээ хэлэлцэж, дундын шийдэл, шийдвэрт хүрэх тогтвортой нэгдсэн бүтэцтэй болно. Ингэснээр үндэсний танхим улс орны эдийн засаг салбар хоорондын бодлогын уялдааг сайжруулах тал дээр илүү төвлөрөн ажиллах боломжтой болно.

3.Үндэсний танхим нь танхим болон аймаг, нийслэлийн танхим, салбар танхим нь үйл ажиллагааг хараат бус бие даасан байдлаар явуулах санхүүгийн боломж бий болно. Үйл ажиллагааны бие даасан байдал хангагдсанаар аж ахуй эрхлэгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлд ахиц гарна гэж бодож байна.

4 дүгээрт, аж ахуй эрхлэгчдийн хооронд үүссэн маргааныг заавал шүүхээр шийдвэрлэх биш эвлэрүүлэн зуучлагчийн тусламжтай шийдүүлж тухайн шийдвэр нь шүүхийн шийдвэрийн нэгэн адил биелэгдэнэ. Үүнтэй холбоотойгоор бизнесийн эрх зүйн холбогдолтой маргааныг дагнан шийдвэрлэх мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчид бий болгох боломжтой зохицуулалтыг оруулсан. Дээрх нөхцөлүүд бүрдсэнээр иргэний хэргийн шүүх дээр маргааны ачаалал буурах эерэг нөлөө гарна.

5 дугаарт нийгэм, эдийн засгийн бодлогын асуудлаар төрийн байгууллагын дэргэдэх зөвлөл, хороо, комисс, ажлын хэсэг байгуулагдахад хамтын удирдлагын бүрэлдэхүүн танхимын төлөөлөл оролцох боломжтой болж байна.

6.Хуулийн төсөлд танхимын удирдлагыг улс төрийн нам эвслийн үйл ажиллагаанаас хараат бус байх зохицуулалтыг тусгасан бөгөөд удирдлагын хараат бус байдал нь Худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагаа, улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас бие даасан байх нөхцөлийг бүрдүүлэх болно.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн бус байгууллагын тухай хуулиудад нийцүүлэн боловсруулсан бөгөөд хуулийн төслийг дагалдуулж 1995 оны

10 сарын 24-ний өдөр баталсан Худалдаа, аж үйлдвэрийн танхимын хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай зэрэг хуулийн төслүүдийг боловсруулсан болно.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөлд шинээр үүсгэн байгуулагдсан аймаг, нийслэлийн танхимын тоо 16, салбарын танхимын тоо 16 ба түүнээс дээш болсны дараа 180 хоногийн дотор анхдугаар Их Хурлыг зарлан хуралдуулахаар тусгалаа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Л.Соронзонболд: Энхтүвшин гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя.

Магнайбаатар Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын гүйцэтгэх захирал, Сарандаваа Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгчийн зөвлөх, Энхцэцэг Монголын олон улсын арбитрын дарга, Шинэбаяр Монголын олон улсын арбитрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Бадамхорол Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын Гадаад худалдааны баримт бичиг баталгаажуулалтын газрын дарга, Оюун-Эрдэнэ Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгчийн ажлын албаны мэргэжилтэн, Золбаяр Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын Гадаад худалдааны баримт бичиг баталгаажуулалтын газрын хуульч, Загдаа өмгөөллийн “Хэругэ Партнерс” компанийн гүйцэтгэх захирал, Эрхбаяр Улсын Их Хурлын гишүүний зөвлөх.

Хуулийн төслийн талаар хууль санаачлагчаас асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Батнайрамдал гишүүнээр, Уянгахишиг гишүүнээр тасаллаа. Мандхай гишүүн. Очирбат гишүүнийг нэмье. Мандхай гишүүнээр тасаллаа. Ганбаатар гишүүн асуулт асууна.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Энэ 2022 онд 1 хууль орж ирээд, гишүүдээс, Засгийн газраас гээд 2 хуулийг энд нэгтгэчихсэн байгаа юу гэдгийг 1 дүгээрт асууя. Нэгтгэчихсэн байгаа юу. Эсвэл 1 хууль нь ахиад орж ирэх гээд байна уу гэдгийг 1 дүгээрт асууя.

2 дугаарт 2022 онд орж ирсэн хууль бол миний саналаар буцсан юм. Тэгээд энэ ямар санал вэ гэхээр аж ахуйн нэгжүүдийг хүчээр орлогоос нь хамааруулаад танхимын гишүүн болгоно гэж энэ заалтыг хассан гэдэг дээр бүр ажлын хэсгээс

Энхтүвшин даргаас би бол түрүүн асуучихсан л даа. Тийм учраас ажлын хэсгээс асуумаар байна. Энэ Байнгын хорооны хурал чинь бас Их Хурлын дарга эртээр уншаад байсан шүү дээ. Худал мэдээлэл өгвөл хуулийн хариуцлагатай гээд. Тэгэхээр тэрийгээ хэлээрэй гэдгийг хэлье. Хассан. Орлоготой нь хамааралгүй гэдгийг нь бас хэлээрэй.

Нэгэнт Худалдаа, аж үйлдвэрийн танхимынхан байгаа, Ерөнхийлөгчийнх нь зөвлөх байгаа дээр би нэг зүйл хэлье. Танай наад топ 100 аж ахуйн нэгж гэдгийг чинь хүмүүс, ялангуяа энэ гишүүд хүртэл бодохдоо хамгийн мундаг татвар төлдөг компаниуд гэж ойлгодог. Тийм биш шүү дээ та нар сайн мэдэж байгаа. Энэ топ 100 аж ахуйн нэгж дотор чинь бүр 1, 2-т нь байгаа аж ахуйн нэгжүүд чинь Монгол Улсын хамгийн өртэй компаниуд. Татварын өртэй, алдагдалтай компаниуд маш их байгаа. Тэгэхээр энэ топ 100 аж ахуйн нэгжийгээ би Энхтүвшин гишүүнд бас хэлж байна лээ. Нэг мөрийн ойлголттой болгоорой. Монгол Улсын иргэд ойлгохдоо татвар мундаг төлдөг гэж ойлгоод байдаг. Яг бахь байдаг дээрээ бол шал өөр байгааг бүгдээрээ мэдэж байгаа байлгүй дээ. Та толгой дохиод байгаа сайн мэдэж байгаа байх. Тэгээд энийгээ засаарай. Би 3 дахь удаагаа хэлж байгаа шүү. 3 дахь удаагаа хэлж байгаа.

Би ер нь гудамж гудамжинд юм уу, энэ коридорт хэлэлцүүлэг дээр юм ярьдаггүй. Ер нь Байнгын хороон дээрээ л юмаа ярьдаг. Тэгэхээр энийгээ засаарай.

Дараагийн дугаарт нь хэлэхэд намайг Эдийн засгийн байнгын хорооны дарга байхад энэ ковидын үеэр юу билээ нэг ийм хураамж авсан шүү дээ та нар. Баахан хэл амтай хураамжууд явсан. Би хараадахъя. Тэр хураамжийнх нь нэр нь давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ билүү. Ийм зүйлүүд хэр гарах вэ. Би зүгээр Байнгын хорооны даргад хэлье. Би яах вэ энэ талаар нэлээн туршлагатай юм. Ажлын хэсгийг ахалъя гэж бодож байна. ажлын хэсэг байгуулагдах байлгүй дээ. Тэгээд ажлын хэсгийг ахалъя. Тэгээд яах вэ, сураг сонсох нь ээ Энхтүвшин дарга энэ тэр бол танхимуудын үгийг бага сонсоод байгаа юм уу гэж сонсогдсон. Тэгэхээр би бас дундыг нь бариад, энэ танхимынхны үгийг их сонсох ёстой. Тэгээд энэ танхимууд чинь бас өчнөөн олон танхимууд байгаа. Энэ танхимууд чинь их сэтгэл хангалуун бус байдаг юм байна лээ шүү дээ энэ хуульд.

Л.Соронзонболд: Эхний асуултад хууль санаачлагч хариулах уу. Энхтүвшин гишүүний микрофон өгье.

Д.Энхтүвшин: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. 2022 онд энэ хуулийн төсөл орж хэлэлцэгдсэн. Тэгээд энэ хуулийн төсөл дээр Ганбаатар гишүүний хувьд бол бас нэлээн тодорхой байр суурийг илэрхийлсэн. Тэгээд танхимын хувьд бол хэд хэдэн загвар байдаг. Ер нь зарим улсад бол бараг төрийн байгууллага шиг бүтцүүд байна. Тэрнээс гадна зарим улсуудын хувьд бол нөгөө талын хязгаар нь бол бүх аж ахуйн нэгжүүдийг гишүүнчлэлтэй байхыг шаарддаг. Энд нь татвар хураамжуудаа төлдөг ийм загварууд байдаг. Тэгэхээр анх эхэлж 2022 онд оруулж ирсэн загвар бол яг тийм бүх аж ахуйн нэгжүүдийг хамруулах ийм Герман болон Австри зэрэг орнуудад байдаг энэ загварыг оруулж ирсэн байсан. Тэгээд Ганбаатар гишүүний тухайн үед илэрхийлж байсан байр суурийг дараа нь судалж үзээд ер нь бол бас Монголд энэ загвар нийцэхгүй юм байна. Одоогийн хувьд бол энэ загвар нийцэхгүй учраас гээд заавал гишүүнчлэлтэй гэдэг зүйлийг авсан байгаа. Тэгээд заавал гишүүнчлэлтэй гэдэг зүйл байхгүй. Сайн дурын гишүүнчлэлийн үндсэн дээр салбарын болон аймаг, нийслэлийнхээ танхимд элсэж болохоор байгаа юм. Үндэсний танхим нь бол аж ахуйн нэгжүүд тэнд элсэхгүй, салбар танхимууд болон

салбартаа олонхын төлөөлөн авч ирж байгаа мэргэжлийн холбоод нь эд нарын нэгдэл байхаар ингэж тусгасан байгаа юм.

Топ 100-тай холбоотой асуудал дээр бол Ганбаатар гишүүнтэй бас санал нэг байгаа. Энэ ер нь аж ахуйн нэгжүүдийн хувьд гол шалгуур байдаг. Энийг нөгөө Засгийн газартай хамтарч гаргадаг учраас энэ шалгуур өөрчлөлт нь бас танхимаас хамаарахгүйгээр Сангийн яамтай хамтарч явдаг. Тэгэхээр энэ дээр жишээлбэл нэлээн олон ажлын байр бий болгосон, төлсөн татвар, хөрөнгө оруулалтын хэмжээ гэх мэтчилэн олон хүчин зүйлүүдийг харгалзаж үзүүлэлт гарч ирдэг. Тэгэхээр тэр агуулгаараа заримдаа жишээлбэл өртэй, тэгээд алдагдалтай аж ахуйн нэгжүүд ч гэсэн энэ жигнэсэн байдлаасаа хамаараад дээгүүр эрэмбэлэх ийм тохиолдол байдаг. Тэгээд энэ талаар бол танхимын удирдлагууд бас ер нь энийг өөрчилье. Энийг бас сайжруулах орон зай байгаа юм байна гэдгийг Сангийн яаманд хүсэлт гаргаж байгаа. Тэгэхээр одоогийн удирдлагууд ч гэсэн энэ талаар үргэлжлүүлж ажиллаж байгаа байх гэж бодож байна.

Тэгээд хураамжийн талаар, Давагдашгүй хүчин зүйлийн талаар тайлбар өгчхөөрэй.

Танхимуудын үгийг бага сонссон гэдэг дээр 2022 онд болон энэ хууль ер нь 2 удаа Улсын Их Хуралд орж ирсэн. Тэгэхээр үүнтэй холбогдолтой олон улсын гадаад улсуудын худалдааны танхимуудтай холбоотой асуудлууд байсан. Нэрийн хамгаалалт байсан. 2022 онд орж ирсэн Танхимын тухай хууль дээр танхим гэдэг нэрийг жишээлбэл хамгаалалтад авахаар заасан байсныг Америкийн худалдааны танхим, Австралийн худалдааны танхим гэх мэтчилэн гадаад улсуудын энэ худалдааны танхимууд энэ дээр бас эсрэг байр суурьтай байсан учраас уулзаж ярилцаад, энэ нэрийн хамгаалалтуудыг нь авсан байгаа.

Нөгөө талаас Улаанбаатар хотын танхим, аймгийн танхимуудын бас энэ эрх зүйн байдал, санхүүжилтийн асуудал нь тодорхойгүй байсан. Тэгэхээр аймгуудын компаниуд нь өөрөө аймаг, нийслэлийнхээ танхимдаа гишүүнчлэлээр элсэж, тэндээ хураамж төлөхөөр. Хэрвээ тэр хураамжаа болохоор удирдах зөвлөл нь өөрөө тогтоодог. Борлуулалтын орлогоос хамаарсан тийм асуудал байхгүй жигд өөрсдөө удирдах зөвлөлөөрөө шийдээд төлдөг иймэрхүү байдлаар зохицуулсан байгаа. Тэгэхээр танхимуудтай бас уулзаж, өмнөх 2 хуулийн төслийн дараа уулзалт хийж, саналуудыг энэ хуулийн төсөлд тусгасан байгаа.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 4 номер.

Ц.Магнайбаатар: Ганбаатар гишүүний хэлсэн топ 100-тай холбоотой асуудал дээр сая Энхтүвшин гишүүний хэлсэн санал дээр нэмээд хэлэхэд ХАҮТ, Сангийн яам, Татварын ерөнхий газар, НДЕГ, ГЕГ, СЗХ, танхим гээд энэ бүрэлдэхүүнтэйгээр топ 100 аж ахуйн нэгжийг шалгаруулах, эрэмбэлэх энэ үйл ажиллагаа явдаг. Тэгээд Төрийн байгууллагуудаасаа татаж авсан тоон үзүүлэлт дээр эрэмбийг хийгээд, зарим тодорхой хуулийн хязгаарлалттай үйл ажиллагаа явуулж байгаа ч юм уу онцгой албан татвартай аж ахуйн нэгжүүд дээр бол хасалт хийж тооцоод, эрэмбэлээд ингээд зарлаж байгаа. Тэгээд гишүүд, удирдах зөвлөлийн гишүүд болон бас топ 100 аж ахуйн нэгжийн эрэмбийг шалгаруулах дээр бол Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дэргэд шалгаруулалтыг сайжруулах ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Хамтарч эрэмбийн үйл ажиллагаанд оролцдог төрийн байгууллагууд энэ .../минут дуусав/

Л.Соронзонболд: Ганбаатар гишүүний асуусан 2 дахь асуултад тодорхой хариулъя. Тэр дээр 4 номер тодорхой хариулъя.

Ц.Ганбаатар: Ковидын үед гэлтгүйгээр Худалдаа, аж үйлдвэрийн танхимын үндсэн үйл ажиллагаа дээр давагдашгүй хүчин зүйл болоод Хүнд нөхцөл байдлын гэрчилгээг танхимаас олгоод явж байсан. Яг энэ ковидын үед бол яг энэ гэрчилгээг аж ахуйн нэгжүүд бол ихээр авсан. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй болон тендерт оролцсон энэ үйл ажиллагаануудтайгаа холбоотойгоор гэрчилгээ авах асуудлууд нь бол эрс нэмэгдсэн. Тухайн үед манай үйл үндсэн үйл ажиллагаа дээр давагдашгүй хүчин зүйлийн судалгааны зарцуулалттай холбоотой 100 мянган төгрөгийн хураамж авч, тэгээд судалгаа дээр нь үндэслээд аж ахуйн нэгжүүдэд гэрчилгээ олгож байгаа ийм үйл ажиллагаа явж байгаа.

Л.Соронзонболд: Ганбаатар гишүүн тодруулъя.

Ж.Ганбаатар: Тэр хураамж нь 100 мянга ч биш байх. 500 мянга, 1 сая төгрөг байсан байх шүү. өөр болчихсон юм болов уу.

Энхтүвшин гишүүн ээ, нэг зүйл хэлэхэд юу байна. Энэ танхим чинь ер нь хуучин бол ер нь танхимууд чинь өөрөө өөрсдөө танхимаа байгуулаад явчих бололцоотой хуулийн заалттай байсан. бол толгой танхим гэж 1 танхимтай болоод, тэгээд бусад танхимууд нь тэндээсээ салбарлана гэж. Би хуулийн хэллэгийг нь буруу хэлж магадгүй юм. Тэгэхээр энэ маань өөрөө цаг үеэ олж байгаа юу, зүйд нийцэж байгаа юу. Үүний ялгаа зааг нь яаж гаргаж байгаа юм. Үүний ялгаа заагийг харахын тулд би бас хуулийн ажлын хэсгийг ахалъя л гээд байна л даа. Хэрвээ яах вэ, өрсөлдөгч гарч ирвэл би бас больчихож болно. Мундаг хүн гарч ирээд надтай бас яавал би зүгээр больчихож болно шүү. Тэгэхээр энэ тал дээр хариулж өгөөч. Тэгээд минут бага байгаа учраас энийг яагаад ингэж хийх болсон юм бэ. Яагаад толгойтой байх ёстой юм заавал.

Л.Соронзонболд: Энхтүвшин гишүүний микрофоныг нээе.

Д.Энхтүвшин: Одоогийн хуулиар бол ер нь бас аж ахуйн нэгжүүд аймаг, нийслэл дээр танхим байгуулаад, энэ танхимууд нь нэгдэж үндэсний танхимаа бүрдүүлж байгаа. Энийг тэгэхдээ Үндэсний танхим дээрээ аж ахуйн нэгжүүд нь давхар бүртгэлтэй байсныг одоогийн шинэ хуулийн төслөөр болохоор Үндэсний танхим нь салбар танхимууд болон аймаг, нийслэлийн танхимуудаас бүрдээд, тэгээд аж ахуйн нэгжүүд нь Үндэсний танхимдаа гишүүнчлэлтэй байдаг байсныг нь болиулж байгаа юм. Тэгэхээр энэ нь ямар ач холбогдолтой вэ гэхээр жижиг дунд аж ахуйн нэгжүүдийн хувьд бас яг энэ дуу хоолой, үндэсний танхимдаа том компаниуд нь ч юм уу орчихоор яг энэ салбаруудын бодлого жижиг, дунд аж ахуйн нэгжүүд дээр нь салбар хоорондын энэ бодлогын уялдааны асуудлуудыг ярих бололцоогүй. Үндэсний танхим гэхээр яг л адилхан танхимтай адилхан иймэрхүү бүтэц болж байсан учраас олон улсын жишигт нийцүүлээд танхимуудыг нь танхим болгохоор ингэж өөрчилсөн байгаа. жишээлбэл Герман гэхэд бол бүс нутгаар жишээлбэл Баварын танхим ч гэдэг юм уу .../минут дуусав/

Л.Соронзонболд: Ганбаатар гишүүн нэмэлт 1 минут.

Ж.Ганбаатар: 1 зүйл хэлэхэд бол энэ танхим Хөдөлмөрийн хууль гээд хэлэлцэгдсэн. Би 47 асуулт асуусан. Танхим бол дан эсрэг байр суурьтай байсан шүү. Миний байр сууринаас биш, хуулийн санаачлагчийн байр сууринаас. Тэгээд

өнөөдөр Хөдөлмөрийн хууль ямар байгаа билээ. Ямар их маргаантай болсон байн Монгол Улс. Улс төрийн маргаанаас гадна бизнесүүдийн хоорондын маргаан. Жижиг, дундын хууль, Зөрчлийн хууль, бүх хуулиуд дээр танхим маш сонин байр суурьтай байдаг шүү. Сонин гэдэг үгний цаана маш тийм зүгээр эрх ашгаа хаана нь тавиад байгаа юм. Мэдэхгүй. Бизнес эрхлэгчдийнхээ эрх ашгийг хамгаалж чаддаггүй. Ялангуяа Хөдөлмөрийн хуулийг би хэлье. Хөдөлмөрийн хууль дээр ямар том маргаанууд байгааг мэдэж байгаа юу. Тэр үед хэрвээ тэгээд зассан бол ийм асуудал үүсэхгүй шүү дээ. Тэгээд Энхтүвшин гишүүний хэлж байгаа асуудлууд яг зөв байгаа эсэх дээр нь хяналт .../минут дуусав/

Л.Соронзонболд: Санал хэллээ. Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Яах вэ, шинэчилсэн найруулгаар орж ирж байгаа бөгөөд ерөнхийдөө тухайн хуулийн зохицуулах асуудлын хүрээнд бол нэлээн зарчмын том өөрчлөлт орж байгаа юм байна гэж харж байна. Өөрөөр хэлбэл яг ХАҮТ болон Худалдааны танхимын дэргэд үзүүлэх үйлчилгээнүүд байдаг. хэрэгжиж явж байгаа шүү дээ. Жишээлбэл арбитр. Тэгэнгүүт яг энэ хууль ингээд батлагдаад гараад ирэхээр нөгөө Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхим гэж нэг том толгой буюу гол танхим байгаад тэрнээсээ улбаалаад салбарынх болон орон нутгийнх гэдгээр явах гээд байна л даа. Аймаг, нийслэлийнх гэдэг юм уу. Тийм ээ. Тэгчихээр одоогийн байгаа зохицуулалтаар худалдааны танхимууд бас байгуулагдчихсан, дэргэдээ арбитртай. Жишээлбэл, Улаанбаатар худалдааны танхим гээд байж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ худалдааны тахимуудын үйл ажиллагааг хэрхэн зохицуулах юм бэ буюу нөгөө яг ингээд Аж үйлдвэрийн танхим, Худалдааны танхимууд өөрсдөө гишүүнчлэлээ бий болгоод, тухайн танхимууд адилхан үйлчилгээнүүдийг үзүүлээд, тэн дээрээ жишээлбэл үнээр өрсөлдөх боломж бий болдог ч юм уу эсвэл чадвараараа өрсөлддөг ч юм уу, арбитрчийн чадвар, бүрэлдэхүүнээр өрсөлдөх энэ боломжууд маань байхгүй болно гэж ойлгох уу.

Тэгэхээр яг ингээд бол хэлэлцэх эсэхийг хэлэлцэж байгаа учраас нарийн дотогшийгоо бол орж бас сайн мэдэхгүй байна. Гэхдээ яг ингээд уншигдахаар зөвхөн Үндэсний буюу одоогийн байгаа Аж үйлдвэрийн танхимаа хуульчлаад, нөгөө хуучин байсан танхим гэдэг ойлголт чинь байхгүй болоод уг нь одоогийн хүчин төгөлдөр хуулиар бол танхим гэдэг дотор Үндэсний аж үйлдвэрийн танхим, дээрээс нь жишээлбэл бусад Худалдааны танхим, Аж үйлдвэрийн танхим байдаг юм уу эд нар чинь өөрсдөө ороод явдаг зохицуулалттай. Тэр нь өөрөө илүү бизнесийн зарчмаар гэдэг шиг бичигдсэн байсан гэж би бол ойлгоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ бүх нөхцөл байдал чинь нэг төвлөрсөн систем рүү ороод ингээд явчихаар бусад танхимын үйл ажиллагаанууд чинь яах вэ. Энэ дээр заасан энэ тухайн үйлчилгээнүүдийг зөвхөн энэ Үндэсний аж үйлдвэрийн танхим, дээрээс нь Үндэсний аж үйлдвэрийн танхимтай гэрээ байгуулсан салбар танхимууд тэр үйлчилгээг үзүүлэх боломжтой болж орж ирж байна гэж ойлгож байна. Зөв үү.

Л.Соронзонболд: Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. Энэ түрүүн хэлсэн танхим нэртэй үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын худалдааны танхимууд байгаа. Эдгээрийн үйл ажиллагаа бол сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж байгаа учраас энэ үйл ажиллагаанууд бол чөлөөтэй явагдана. Тэр өмнөх 2022 оны хуулийн төсөл дээр болохоор нэрийн хамгаалалтыг танхим нь аваад, хэрвээ тэр танхим гэдэг нэр хэрэглэхээр бол Үндэсний танхимаас зөвшөөрөл авахаар ийм харилцаа, зохицуулалт байсныг энийг болиулсан байгаа.

Улаанбаатар хотын танхимын хувьд ер нь бол нийслэлд, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа ихэнх аж ахуйн нэгжүүдийн хувьд бол Улаанбаатарт үйл ажиллагаа явуулж байгаа учраас ер нь бол Улаанбаатар хотын танхим нь илүү хүчтэй болох том болох ийм дүр зураг харагдаж байгаа. Тэгээд эдийн засгийн салбаруудаас гадна ялангуяа худалдаатай холбоотой аж ахуйн нэгжүүдийн хувьд бол Улаанбаатар хотын танхим дээр илүү нэгдэхээр иймэрхүү дүр зураг байгаа. Тэгэхээр энэ танхимуудын үйл ажиллагаа нь энэ дээр бол шууд сөргөөр нөлөөлөх юм байхгүй. Тэр нөгөө шинээр ийм үндэсний танхим гэж бий болгож биш, одоогийн танхим гээд байгаа ойлголтыг бүтцийнх нь хувьд илүү салбар хоорондын бодлого ярьдаг нийтлэг эрх ашиг ярьдаг болохын тулд аж ахуйн нэгжүүд гишүүн байсныгаа болиод, салбарын танхимууд буюу өмнө нь бол бид нар аймаг, нийслэл гэж тавьж байсан. Гэхдээ аймаг, нийслэл гэдэг бүтэц маань ажиллахгүй байгаа учраас эдийн засгийн салбаруудаараа танхим байгуулъя. жишээлбэл уул уурхайн танхим. энэ хуулийн агуулгаар болохоор уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа Жишээлбэл уул уурхайн ассоциаци энэ салбарын төлөөллөө хэрэгжүүлж, илэрхийлж чадаж байгаа учраас гэрээ хийгээд, уул уурхайн салбар танхимын үүргийг гүйцэтгээд жишээлбэл уул уурхайн асуудлыг бол тэр дээрээ ярьдаг. Үндэсний танхим дээрээ болохоор салбар хоорондын асуудал, нийтлэг эрх ашгууд татвартай холбоотой, нийгмийн даатгалтай холбоотой, ер нь нийтлэг хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлуудаа ярьдаг. 1 компанийн асуудал ярьдаггүй иймэрхүү болгож байгаа.

Тэгэхээр ер нь бол явж байгаа танхимын үйл ажиллагаанууд дээр илүү дэмжлэг болж, илүү уялдааг нь тодорхой болгож байгаа иймэрхүү зохицуулалтууд байгаа.

Л.Соронзонболд: Уянгахишиг гишүүн асуулт асууя.

Г.Уянгахишиг: Энэ дээр би энэ 26 дугаар зүйлийг хэлэх гээд байна л даа. Энэ 26 дугаар зүйл дээр Монголын үндэсний танхим нь зарим үйлчилгээг үзүүлэх эрхээ аймаг, нийслэлийн болон салбарын танхимд гэрээний үндсэн дээр шилжүүлж болно гэж байгаа юм. Тэгэхээр яг энэ үйлчилгээтэй холбоотой зохицуулалт байгаад байгаа байхгүй юу. Энэ дээр ингээд нэлээн олон үйлчилгээнүүдийг аж үйлдвэрийн танхим хийж болно гэхчхэн байгаа юм. Тэгэхдээ тэр нь өөрөө яг Үндэсний аж үйлдвэрийн танхим гээд ороод ирчихсэн. Нөгөө худалдааны танхим гэдэг ерөнхий ойлголт нь уг нь энэ ерөнхий заалт дээрээ бол байж байгаа юм. ХАҮТ 4.2 дээр 4.1, 4.2 дээр байгаа боловч яг энийгээ базаад ороод ирэнгүүтээ 4.2 дээр 4.1-д заасан зорилгыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэгч Монголын үндэсний танхим, аймаг, нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэгч аймаг, нийслэлийн танхим, эдийн засгийн гээд ингээд явцууруулчихсан байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ чинь өөрөө .../минут дуусав/

Л.Соронзонболд: Хууль санаачлагч Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Уянгахишиг гишүүний саналыг ойлголоо. Ер нь 26.1 дээр үндэсний танхимын үйлчилгээний эрхийг шилжүүлэх талаар заалт бас хоёрдмол утгатай ойлгогдож байгаа бол хэлэлцүүлгийн явцад энийг сайжруулах бололцоо байгаа гэж бодож байна. Шинэчилсэн найруулга учраас энэ хуулийн төсөлтэй холбоотой сайжруулах зүйлүүдийг бас хэлэлцээд явах бололцоотой гэж бодож байна.

Л.Соронзонболд: Хууль санаачлагч Ганхуяг гишүүн нэмэх үү. Ганхуяг гишүүний микрофоныг нээе.

Х.Ганхуяг: Баярлалаа. Тэгээд ер нь манайд яг Иргэний нийтийн хуулийн этгээд гэхээр яг хуультай тийм байгууллагууд бол маш цөөхөн шүү дээ. хуульчдын холбоо гээд. Сүүлд аялал жуулчлалын хуулийг бичиж байхад Аялал жуулчлалын нэгдсэн холбоо гээд байгуулсан юм. Тэр нэгдсэн холбоог байгуулахаас өмнө бол нийтдээ 200 гаруй холбоотой байсан. 1 аж ахуйн нэгж 2-3 холбоотой байсан. Тэгээд яг тухайн салбар яам нь салбарын асуудлыг ярих гэхээр ярих эзэн олддоггүй. Нэгдэж нийлдэггүй. Тэгээд тийм учраас тэрийг нэгдсэн холбоог нь байгуулаад, тэгээд тэр хууль батлагдсанаас хойш өнөөдөр жуулчдын тоо бол 3-4 дахин нэмэгдэж, тэгээд бодлого нь илүү оновчтой болоод ингээд явж байгаа байхгүй юу. Тэгээд танхим дээр ч ялгаа байхгүй. Анх тэр 1997 оны хууль бол үндсэндээ бол яг төрийн байгууллагын бүтцийг дуурайгаад ерөнхийдөө биччихсэн хууль байсан байхгүй юу. 21 аймагт салбартай байна. Гэхдээ яг нөгөө эдийн засгийн салбарууддаа ерөөсөө оруулж өгөөгүйгээрээ сул талтай байсан. Тэгэхээр энийг .../минут дуусав/

Л.Соронзонболд: Ганхуяг гишүүн гүйцээж хариулъя.

Х.Ганхуяг: Яг өнөөдрийн бид нарын хамгийн том асуудал юу вэ гэхээр чинь бизнесийн орчин улам хумигдаад байдаг. Зөвшөөрлийн хуулийг хийж байхад ч тэр Зөвшөөрлийн хууль чинь бүхий л салбартай холбоотой хууль. Тэгээд төрийн байгууллага нь ингээд төлөөлөл нь байж байдаг. Хувийн хэвшил нь уулзъя гэхээр төлөөлөл байхгүй. Тэгээд жишээлбэл авто замын салбар дээр 70 гаруй төрийн бус байгууллага байдаг. Аялал жуулчлал дээр байлаа шүү дээ. 200 гаруй төрийн бус байгууллагууд. Тэгэхээр бид нар энэ танхимын хуулиараа эхлээд суурийг нь. Анх бол би энэ хуулийн бичихдээ яаж байсан. Илүү монопол байхаар бичиж байсан юм. Гэхдээ эхний удаадаа бол илүү либерал явуулж байгаад, тэгээд магадгүй бол цаг нь бас арай болоогүй байгаа юм шиг байгаа юм. Тэгээд 10-20 жилийн дараа дахиад нэг хийх ёстой юм шиг байгаа юм. Тэгэхээр энэ салбар тэнхимүүдийг байгаа тэнхимүүдийг нь ч байж л байг. Гэхдээ салбар тэнхимүүдийг бий болгоод, яг салбарыг хариуцсан төлөөлөлтэй болгохгүй бол, дээрээс нь институт бий болгохгүй бол манайд үндсэндээ яг бизнесийн орчныг төлөөлөх хэмжээний институт бий болж амжаагүй байгаа байхгүй юу. Тэгж байж манай бизнес орчин чинь сайжрахаар байгаа юм. Тэгэхгүй бол зөвхөн нэг талын .../минут дуусав/

Л.Соронзонболд: Уянгахишиг гишүүн тодруулъя.

Г.Уянгахишиг: Тэгвэл би асуултаа маш тодорхой асууя. Тэгэхээр энэ хууль шинэчлэгдээд батлагдчихсан тохиолдолд бусад худалдааны танхимууд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжтой юу. Эсвэл заавал үндэсний танхимтай гэрээлж байж одоогийн явуулж байгаа үйлчилгээнүүд эрхлэх боломжтой юу буюу энэ дээр жишээлбэл ХАҮТ гэж томъёолол байгаа боловч яг тэр танхимтай холбоотой заалтууд, зохицуулалтууд нь маш бага байгаа байхгүй юу. Үндсэндээ Үндэсний аж үйлдвэрийн танхим гэдэг л зохицуулалтууд гол нь орж ирээд байгаа гэсэн үг. Тэгэхээр яг энэ параллель явж байгаа тэр Худалдаа, аж үйлдвэрийн танхимын зохицуулалт нь хаана байгаа юм бэ. Эсвэл худалдааны танхим хуучин хуулиар байгаа хуулиараа байгаа. Худалдааны танхимын зохицуулалт нь яаж явах юм бэ.

Л.Соронзонболд: Энхтүвшин гишүүн хариулъя.

Д.Энхтүвшин: Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. Салбар үйл ажиллагаа явуулж байгаа танхимууд энэ хууль батлагдсанаар үүнээс хамаарч үйл ажиллагаа нь саатах, тасалдах юм байхгүй. Яг үйл ажиллагаа явуулж байгаагаараа явуулах бололцоотой. Энэ дээр бол ямар нэгэн хориг саад болох үйл ажиллагаа байхгүй. Энэ танхим маань сайн дурын үндсэн дээр явж байгаа нэгдлүүд нь заавал гэдэг зохицуулалтууд байсан бол яг энэ хязгаарлалтууд, тэр нэрийн хамгаалалт байсан бол ийм хязгаарлалт болох эрсдэлүүд байсан бол ийм заалтуудыг авсан учраас тийм эрсдэл байхгүй.

Тэгээд энэ үндэсний танхимаас гадна энэ дээр гол юу яаж байгаа юм бол аймаг, нийслэлийн болон эдийн засгийн салбар дахь танхимуудыг нь яаж байгуулах талаар заалтуудыг нэлээн тодорхой энэ дотор бас заачихсан байгаа. Тэгэхээр үүнтэй холбоотой зохицуулалт нь хуулийн төсөл дотор зүйл, заалт болгоод оруулчихсан байгаа.

Л.Соронзонболд: Эрдэнэбат гишүүний микрофоныг нээе.

С.Эрдэнэбат: Би ХАҮТ-ыг анх байгуулагдаж байгаа гээд харахад энэ гадаад руу үндэсний компаниудаа тэлж өгөх, дэмжих тал дээр бас нэлээн ажилламаар санагдаад байдаг юм. Анхны зорилго нь ч тэр болов уу гэж боддог юм. Яах вэ төлөөлөх чадавх үндэсний хэмжээний том байгууллага гэдэг талаас нь бол харж болж байна. Энэ хуулийг ерөнхийд нь харахаар яг нөгөө нийгмийн 3 талт гэдгийн 1 тал нь л даа. Би нөгөө үйлдвэрчний эвлэлийн хуулийг оруулах гээд ингээд яасан чинь Хууль зүйн яаман дээр ХАҮТ-аас асуу гээд ерөөсөө ингээд эрх ашиг нь хөндөгдөх байгууллага буюу нөгөө талаас нь асуу гэдэг байдлаар маш олон хуулийн заалт дээр бол наашаа цаашаа болгосон. Тэгэхээр Хууль зүйн яам болон энэ ажлын хэсгийн хүмүүсээс асуухад ийм зүйлийг яасан уу. Өөрөө энэ чинь нөгөө талдаа нөгөө талдаа ялгаа байхгүй шүү дээ. Хөдөлмөрийн харилцааны 2 талын 1 оролцоотой тал. Засгийн газраас бол санал авсан байх. Би бол яах вэ, ХАҮТ-ыг их олон, дэндүү олон төрийн бус байгууллага байхаасаа илүүтэйгээр үндэсний хэмжээний байгаасай, болж өгвөл 1 байгаасай гэдгийг дэмждэг хүн.

Ер нь энэ институт байгууллагууд. Тэр институт нь харин тэгэхдээ өөрөө явцуу болчихвол энэ хэцүү. Буруугаар ашиглавал их буруу болчихдог. Хууль дээр ингээд харахаар бас зарим нь ингээд байна. Саяынх асуулт шүү. Тэр Хууль зүйн яамнаас хуульд тавигдаж байгаа шаардлагын үүднээс буюу эрх ашиг нь зөрчигдөх, хөндөгдөх этгээдүүдээс санал хүсэлт авсан уу гэж. Яагаад асууж байна вэ гэхээр төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэнэ гэдэг нэрийдлийн дор маш олон үйлчилгээг авах боломжтой Худалдаа, аж үйлдвэрийн танхим. Гэхдээ болоогүй байж байхад нь баахан танхимуудад өгчих юм бол энэ өөрөө эргээд асуудал болдог. Насаараа нэг хүн ингээд өмчилчихсэн юм шиг байдаг байгууллагууд байна. Дүрэм дээр яах вэ асуудлууд орж ирж байна. Би бол дэмжиж байна. Тэр сонгогдохыг.

Гэхдээ ингээд харахаар зарим нь дэндүү хатуу заалтууд биш үү. Удирдах зөвлөл нь 11 хүнтэй байна гэдэг чинь дүрмээрээ зохицуулах ёстой байдаг. Сонгуулиа ингэж хийнэ, тэгж хийнэ гэдэг чинь дүрмээрээ зохицуулахгүй бол та нар сүүлд нь танхимынхан хуралдангуут хуулиа өөрчлөхөөс өөр арга байхгүй гэдэг юм руу орох вий дээ. Хэт ингээд хуулиар төрийн бус байгууллагын юмыг ингээд хаагаад хаагаад өгчихвөл бас энэ бол эргээд асуудал байдаг.

Дээрээс нь төрийн өмчийн компаниуд 50-аас дээш хувь нь гишүүн байж болохгүй гээд тавьчихаж. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын. Тэгэхээр энэ чинь

нөгөө эвлэлдэн нэгдэх эрхийг зөрчих гэдэг ийм асуудал руу орохгүй юу гэдэг асуудлыг та бүхэн юу гэж бодож байгаа вэ.

Дээрээс нь энэ дээр бас нэг юунууд байна л даа. Зөвхөн аймаг, нийслэлийн танхим нь үндэсний танхимаасаа зөвшөөрөл авч байж бусадтай харьцана гэххэж. Энэ чинь нөгөө монополын эсрэг юм болоод өөрөө аймгийн буюу тэр танхим нь хэн нэгэн гадаад, дотоод ч гэдэг юм уу аймгуудтай холбоо тогтоож л байг л дээ. Тэрийг заавал Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимаас ийм бичиг явуулж болох уу гэдэг зөвшөөрөл авна гэдэг чинь эргээд энэ байгууллагад хэтэрхий их толгойд нь мэдэл өгөхөөр явцуу болгох тал руу бий болох уу гэдгийг асуумаар байна.

Гарал үүслийн гэрчилгээг олгоно гээд. бид нар чинь нөгөө чөлөөлье, зөвшөөрлийг цуцалъя гээд байдаг. Гэтэл танхим маань баахан гарал үүслийн гэрчилгээг танхимаас очиж авчир гээд нэг хуудас цаас нэхдэг ийм юм руу .../минут дуусав/

Л.Соронзонболд: Хууль санаачлагч Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Тэр дарга, цэрэг сонгодог асуудлыг хуульд оруулахаас өөр аргагүй юм. Тэгэхгүй бол энэ чинь нөгөө дүрмээрээ зохицуулна гэхээр 50, 60 хүн суулгаж байгаад, тэр тусмаа аймгийн тэнхимийн дарга нар бол үндсэндээ бол томилгоот байдаг юм. Томилгоот байж ирсэн. Тэгэхээр нэг ёсондоо өөрийнхөө томилсон хүмүүсээ суулгаад, тэгээд дүрмээ өөрчлөөд, тэгээд өөрийгөө сонгуулаад явчихдаг байхгүй юу. Тэгээд сая Ганбаатар гишүүний ярьж байгаа үнэн шүү дээ. Тэр Ажил олгогч эздийн холбоо билүү. Ганцхан гишүүнтэй. Тэгээд ажил олгогч нарыг төлөөлөөд жишээлбэл 30, 40 жил явчихсан. 3 талт хэлэлцээрийг хувийн хэвшлийг төлөөлж орж суудаг. Амьдралдаа 1 ч удаа хувийн хэвшилд ажиллаж үзээгүй хүн, нэгхэн гишүүнтэй төрийн бус байгууллага ажил олгогч эздийг төлөөлөөд хэлэлцээр хийгээд суугаад байгаа байхгүй юу. тэрийг чинь танхим хийх ёстой шүү дээ.

Тэгээд энэ хуулиараа зохицуулдаг, дарга цэргээ сонгодог, сонгуультай болгодог, энэ чинь даргыг нь тэр бүү хэл 4 жилээр ганцхан удаа гэж оруулсан шүү дээ. Тэнхимийн даргыг. Насаараа суух эрх байхгүй. Тэгээд 4 жилд хийгээд, хийх ёстой ажлаа хийдэг, тэгээд буудаг. Аль болох улс төрөөс хол байлгахаар, төрөөс хамаарал бага байхаар энэ хуулийг бичсэн байгаа. Тэгээд хуучин бол энэ чинь тарифаа бүгдийг нь Сангийн ямаар, Сангийн сайдаар батлуулдаг байсныг нь болиулж байгаа гэсэн үг.

Л.Соронзонболд: Энхтүвшин гишүүн нэмж хариулъя.

Д.Энхтүвшин: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Гарал үүслийн гэрчилгээний зохицуулалт бол олон улс дээр ер нь бол төр биш хувийн хэвшил биш энэ дундын байгууллага олгодог ийм тогтчихсон дэг жаяг байгаа учраас олон улсын харилцаанд орж байгаа учраас энэ гарал үүслийг бол дэлхий даяараа ХАҮТ нь олгодог иймэрхүү жишиг тогтчихсон байгаа. Тэгэхээр үүнтэй холбоотой зохицуулалтаараа өнгөрсөн хугацаанд гарал үүслийн гэрчилгээг танхим олгож ирсэн. Тэгээд цаашдаа ч гэсэн энэ үйл ажиллагаа явна гэж хуулийн төсөлд тусгасан байгаа. Энэ төрийн өмчит 50-аас дээш аж ахуйн нэгжүүдийг энэ танхимын гишүүнд орохгүй байхаар хуулийн төсөлд тусгасан байгаа. Өөрөөр хэлбэл энэ хуулийн зорилго нь хувийн хэвшлийн оролцоог дэмжих, эдийн засаг дахь төрийн оролцоог багасгах, хувийн хэвшлийн оролцоо, бизнес эрхлэх орчныг сайжруулъя гэж байгаа учраас ер нь бол энэ том том төрийн өмчит компаниудын асуудлууд бас орж

ирэхээр яах вэ гэдэг агуулгаар энэ заалтыг оруулсан байгаа. Гэхдээ хэлэлцүүлгийн .../минут дуусав/

Л.Соронзонболд: Энхтүвшин гишүүн гүйцээж хариулъя.

Д.Энхтүвшин: Хэлэлцүүлгийн явцад бас энэ асуудлуудыг ярилцаж байсан. Яагаад гэвэл зарим салбар дээр бас төрийн оролцоо бас нэлээн өндөр байгаа. Жишээлбэл эрчим хүчний салбар гэдэг бол эрчим хүчний салбар байгуулагдвал төрийн өмчит компаниуд давамгайлсан. Уул уурхайн салбарт дээр ч гэсэн одоогийн үйл ажиллагаа явж байгаа Жишээлбэл уул уурхайн ассоциаци дээр гэхэд Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэ Тавантогой гэх мэтчилэн төрийн өмчтэй компаниуд байдаг учраас энэ асуудлуудыг яах вэ гэдгийг хэлэлцүүлгийн явцад бас ярилцах бололцоотой гэж бодож байна.

Тэр удирдах зөвлөлийн гишүүн 11 гэдэг тоог яагаад гаргасан гэхээр тодорхой тоо тогтоохгүй бол аймаг, нийслэлийн болон салбар танхимын удирдах зөвлөлийн гишүүд нь автоматаар үндэсний танхимынхаа хурлыг бүрдүүлж байгаа. Тэгэхээр энэ нь жигд байхгүй бол олон удирдах зөвлөлийн гишүүнтэй нь олон хүн төлөөлүүлж оролцуулах, энэ нь өөрөө тэнцвэртэй байдлыг алдагдуулах учраас тодорхой хэмжээний тоо заагаад энэ хүрээнд нь хязгаарлая гэдэг ийм агуулга оруулсан байгаа юм.

Л.Соронзонболд: Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: Яах вэ, би тэр үйлдвэрчний эвлэлийн хууль хэлэлцэж байхад заавал танхимаас зөвшөөрөл ав гээд байсан байхгүй юу манай төрийн байгууллагууд. Тэгээд алаг үзэж байгаа юм шиг нөгөө байгууллага нь хуулийн санал ороод ирэхээр нөгөөдхөөс нь асуух хэрэггүй гэдэг байдлаар хандаж байгаа бол энэ хууль бичдэг зарчим чинь маш ялгаатай асуудал. Тийм учраас яах вэ, би заавал санал өгөх гээд байгаа юм биш. Хуулийг боловсруулахад адилхан үндэсний хэмжээний байгууллагуудыг хуулийг нь хэлэлцэхэд харилцан бие биеийгээ хүндлэх, нэгэн нь хэлэлцээр гэдэг юм уу, 1 асуудлын 2, 3 тал болдгийн хувьд бол энийг ярьдаг юм байна лээ. Тэр утгаар нь хэлсэн шүү гэдгээ хэлмээр байна.

Яах вэ хуульд бол нөгөө байгууллагын дотоод бүтэц гэхээсээ илүүтэйгээр энэ аж ахуйн нэгж, байгууллагуудыг яаж гадаад, дотоодод гаргах вэ, яаж томруулах вэ гэдэг тал руу нь. Зарим оронд бол яг ний нуугүй хэлэхэд тэр гадаад бизнесийг дэмжихэд элчингүүдийн зөвлөх тавихад энэ танхимын саналыг авдаг юм байна лээ шүү дээ. Тэгээд иймэрхүү юмаа оруулж ирдэггүй юм уу. Тэгвэл та нарт хэрэгтэй биш үү. Түүнээс биш 1 даргыг тэд байна, эд байна мэдэг гэдэг юм чинь бол дүрмээрээ зохицуулчихвал бараг болох асуудал юм болов уу л гэж бодож байна.

Л.Соронзонболд: Санал хэллээ. Заяабал гишүүн.

Б.Заяабал: Баярлалаа. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг зарчмын хувьд дэмжиж байгаа юм. Тэгэхээр Монгол Улсын эдийн засаг бол хувийн хэвшил дээр суурилсан ийм эдийн засгийн системтэй. Сүүлийн 35, 36 жил бид нар ингэж явж ирсэн. Улс төрд гарч ирсэн Засгийн газар болгоны тэргүүнүүд юу гэж ярьдаг вэ гэхээр зэрэг энэ бизнесийг дэмжье, хувийн хэвшлийг дэмжинэ. Эдийн засгийг солонгоруулна, эдийн засгийг либералчилна, эдийн засгийн суурийг нь өргөтгөнө гээд бүгд л ярьдаг л даа. Гэтэл өнөөдрийн яг эдийн засгийн бүтцийг аваад үзэхэд бас тэр хэмжээндээ хүрч чадсан уу гэвэл бас

миний хувьд бол чамлалттай байгаа. Энэ дээр бол Худалдаа, аж үйлдвэрийн танхимын бас энэ 1995 оноос хойш ажиллаж эхэлсэн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын ажиллагаа бас хууль зүйн орчин нь бас дутуу байсантай холбоотой байх гэж ингэж үзэж байгаа юм. Аль ч улсын энэ chamber commerce буюу энэ ХАҮТ дээр байдаг хэдэн гол үүргүүд байгаа шүү дээ. Олон улсын худалдаанд болон төрдөө бизнес эрхлэгчид, хувийн хэвшил дуу хоолойгоо өргөх, хоорондоо сүлжээ хамтын ажиллагаагаа өргөтгөх, маргаан шийдвэрлэх, хөрөнгө оруулалт хамтын ажиллагааны чиглэлээр мэдээлэл авах, үйл ажиллагаатай холбоотой сургалт, форум, семинар гэдэг юм уу авах гэх мэтчилэн ийм л үндсэн хэдхэн үүрэгтэй байгаа юм. Энэ хуулийн төслөөс харахад дуу хоолой өргөх, төрийн байгууллагуудтай хамтарч ажиллах чиглэлээр тусдаа нэг зүйл орж ирсэн байна. Энэ дээр бас нэлээдгүй тодорхой биш хэтэрхий ерөнхий байдлаар бас дурдаж орж ирсэн байна гэж ингэж үзэж байна.

Сая бас Ганбаатар гишүүний хэлж байгаа тэр татвараас авдаг топ 100 мэдээлэл гээд төрийн байгууллагуудаас авдаг мэдээлэл бол энэ хууль дээр байхгүй. Засгийн газар, ХАҮТ 2-ын хооронд байгуулагдсан гэрээний шугамаар компаниудын мэдээлэл авагдаад явдаг. Яах вэ, цаанаа бол хувийн хэвшлийг, энэ бизнес эрхлэгчдийг хамгаалах олон нийтэд бас таниулах ийм л сурталчилгааны ажил явж л байгаа байх л даа. Гэхдээ энэ чинь хууль зүйн хүрээнд бас нийцээгүй юм шүү. Энийгээ бас ингээд хуульд нийцүүлэх чиглэлээр оруулж ирэх ийм шаардлагатай байсан болов уу гэж ингэж үзэж байгаа.

Хамтын ажиллагаа хоорондын нэтворк үүсгэх чиглэлээр энэ мэргэжлийн танхим гэж байгуулж байгаа юм байна. Энэ нь бас зөв байх гэж ингэж бодож байна. Би цаг бага байгаа учраас гол ганц 2 асуулт асуучихъя гэж бодож байна.

1 дүгээрт нь энэ барааны гарал үүслийг ХАҮТ өгч байгаа. Засгийн газар дээр бас санал өгөхдөө энэ бол бас олон улсын жишиг биш, дэлхийн худалдааны байгууллага, бусад байгууллагууд бол энийг гаалийн байгууллага нь өгөөд явах нь зөв гэсэн ийм дүгнэлт өгчихсөн гэж хэлсэн байна лээ. Энэ дээр яг үүний хэрэгжилттэй холбоотойгоор ХАҮТ маань яг энэ гарал үүслийн гэрчилгээг хэд хоногийн дотор олгодог вэ. Ямар нотлох баримтуудыг авч байж олгодог вэ. Хэчнээн хүн үүний цаана ажилладаг вэ. Тэгээд хэчнээн төгрөгийн төлбөр авдаг вэ гэсэн ийм асуулт 1 дүгээрт нь асууя.

2 дугаарт нь энэ 86-тай кодын цаана .../минут дуусав/

Л.Соронзонболд: Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Тодорхой асуултууд асуусан учраас ажлын хэсгээс Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимаас энэ барааны гарал үүсэлтэй холбоотой тодорхой нарийн асуулт асуусан учраас ажлын хэсгийн 6 номерын микрофон дээрээс хариулт өгье.

Л.Соронзонболд: 6 номерын микрофон.

Э.Бадамхорол: Сайн байцгаана уу. Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. МҮХАҮТ-аас гарал үүслийн гэрчилгээг бол Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн дагуу олгоод явж байгаа. Дэлхийн жишигтэй ч бас дэлхийн 70 гаруй танхимууд нь бол гарал үүслийн гэрчилгээг олгож явдаг. Гарал үүслийн гэрчилгээг Үндэсний танхим болон танхимын салбар 8 танхимаас бол олгоод явж байгаа.

Үндэсний танхим дээр бол 5 хүний бүрэлдэхүүнтэй. Орон нутгийн танхимын 8 гээд ингээд 13, 14 хүний бүрэлдэхүүнтэйгээр гарал үүслийн гэрчилгээг олгож байна. Гарал үүслийн гэрчилгээг авахад шаардлагатай бичиг баримтууд бол олон улсын хууль, дүрэм журмын дагуу гадаад худалдааны гэрээ, үнийн нэхэмжлэх, сав баглаа боодлын хуудас, аж ахуйн нэгжийн гэрчилгээ, тэгээд шаардлагатай тусгай зөвшөөрлүүдийн хуулбарыг авдаг.

2026 оны 1 сарын 2-оос эхлээд гарал үүслийн гэрчилгээг бол цахимаар олгож эхэлсэн. Энэхүү цахимаар олгож эхэлсэн хууль, эрх зүйн үндэслэл нь бол Монгол Улсын Ерөнхий сайдын 41 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг бас Эдийн засаг, хөгжлийн яаман дээр байгуулагдсан байгаа. Энэхүү ажлын хэсгийн төлөвлөгөөний биелэлт ийг хангах хүрээнд цахимаар олгоод явж байна. Тэгээд аж ахуйн нэгж, байгууллагууд маань бол бүх бичиг баримтаа төрийн үйлчилгээний нэвтрэлтийн дан системээр дамжуулан цахимаар илгээж байгаа. Тэгээд цахимаар гарал үүслийн гэрчилгээгээ аваад, танхимаас олгосон гарал үүслийн гэрчилгээ нь бол Монгол Улсын Гаалийн байгууллага болон хүлээн авагч талын байгууллагуудад шууд хүрч байгаа. Шууд хүрч байгаа гэдэг нь бол экспортлогч аж ахуйн нэгж, байгууллага цахимаар гарал үүслийн гэрчилгээгээ авч байгаа. Монголын гааль руу бол шууд танхимын системээс илгээгдэж байгаа. Олон улсын байгууллагууд бол тухайн гарал үүслийн гэрчилгээний баталгаажуулалтыг бол мөн танхимын веб сайтаар дамжуулаад шууд шалгах ийм боломж нь бүрдсэн байгаа.

Тэгэхээр шаардлагатай тохиолдолд бид бүхэн тухайн бараа бүтээгдэхүүний гарал үүслийг тухайн үйлдвэр дээр очиж, үйл явцтай нь танилцаж, гарал үүслийг бол тодорхойлдог. Тэгээд ажлын 1-2 цагийн дотор тухайн гарал үүслийн гэрчилгээг олгоод явж байгаа.

Л.Соронзонболд: Заяабал гишүүн тодруулъя.

Б.Заяабал: Тэр үнийн дүнг надаа бас хэлээд өгөөрэй. Гарал үүслийн гэрчилгээтэй холбоотой. Дээрээс нь нотлох баримтыг нь яаж танайх бүрдүүлж авдаг юм. Яг гарал үүслийн гэрчилгээтэй холбоотой. Энийг яагаад асуугаад байна гэхээр зэрэг монголд үйлдвэрлэв гээд 86 кодтой бараанууд Монголд биш гадаадад үйлдвэрлэхээд Монголд орж ирээд бас үндэсний үйлдвэрлэлүүдтэй өрсөлдөөд байна. Үүний цаана Засгийн газраас хэрэгжүүлээд байгаа жижиг, дунд үйлдвэрлэл болон Ерөнхийлөгчийн хэрэгжүүлээд байгаа энэ Хүнсний хувьсгал гэх мэтчилэн энэ хувьсгалын төрөөс оруулж байгаа дэмжлэгүүд маань бас үр дүнгүй болох ийм асуудал үүсээд байна гэдэг зүйлүүдийг чинь бас хувийн дотоодын үйлдвэрлэгч нар маань сүүлийн үед нэлээдгүй яриад байгаа. Энэ дээр бас тодорхой мэдээлэл өгөөч.

2 дугаарт нь үйлчилгээний орлого гээд ороод ирчихсэн байна. Сая танилцуулга дээр харахад Худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагааны 80 орчим хувь нь үйлчилгээний орлогоос бүрддэг гээд хэлчихсэн байна л даа. энэ дээр чинь бол шинэ хуулиар 7, 8 төрлийн үйлчилгээ орж ирж байгаа юм байна. Энэ олон улсад байдаг жишиг үү. Тэгээд цаашдаа энэ нь орлогын чинь хэдэн хувь болох юм бэ.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 6 номер гүйцээж хариулъя.

Э.Бадамхорол: Эхний 2 асуулт дээр хариулахад нотлох баримтыг бол бид бүхэн түрүүнд хэлсэн бичиг баримтууд мэдээж хэрэг шаардлагатай. 2 дугаарт үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай бид бүхэн очиж үйл явцтай нь танилцдаг. Мэдээж

хэрэг бүх аж ахуйн нэгжүүдэд хүндрэл чирэгдэл учруулаад, өдөр шөнөгүй очоод шалгах бол боломжгүй. Тэгэхээр бид бүхэн бас тухайн үйлдвэрлэлийн үйл явцтай нь танилцаж, үйлдвэрлэлийн процессын явцтай танилцаж, тэгээд тодорхой нэмүү өртгийн шалгуурыг хангасан бараа бүтээгдэхүүнд бол олгодог байгаа. Үнэ тарифтай холбоотой асуудал дээр гэвэл дунджаар бол 10-30 мянган төгрөгийн тарифыг авдаг. Тэгээд тусгайлсан тариф байдаг. Тэгээд тарифынхаа дагуу үйлчилгээгээ явуулж байгаа .../минут дуусав/

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн ахлагч Энхтүвшин хариулна.

Д.Энхтүвшин: Үйлчилгээний талаар асуулт асуулаа. Заяабал гишүүний асуултад хариулъя. Ер нь энд дурдагдсан үйлчилгээнүүд бол явж байгаа үйлчилгээнүүд байгаа. Шинээр эвлэрүүлэн зуучлах үйлчилгээтэй холбоотой үйлчилгээг илүү тодорхой хууль дээр зааж өгсөн байгаа. Өмнөх буюу мөрдөгдөж байгаа хуулиар болохоор энэ үйлчилгээний үнэ тарифыг нь байхгүй болчихсон Худалдааны яам тогтооно энэ тэр гэсэн иймэрхүү хуулийн зохицуулалтаасаа болоод үнэ ханшаа ч гэсэн тогтоож чаддаггүй байгаа. Тэгэхээр шинэ үйлчилгээ нь орлогын бүтцэд нэг их өөрчлөлт оруулахааргүй байгаа. Өөрөөр хэлбэл эвлэрүүлэн зуучлах үйлчилгээний орлого бол нэг тийм том өндөр өөрчлөлт оруулахааргүй байгаа. Тэгэхээр одоогийн орлогын бүтэц бол гишүүнчлэл 20 орчим хувь, бусад үйлчилгээнээс 80 орчим хувь гэдэг энэ харьцаа бол хэвээрээ хадгалагдахаар байгаа.

Л.Соронзонболд: Батнайрамдал гишүүн асуулт асууя.

О.Батнайрамдал: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Хуулийг зарчмын хувьд бол дэмжиж байна. Гэхдээ ер нь хуулийн агуулгаас нь харах юм бол бараг 70, 80 хувь нь Худалдаа, аж үйлдвэрийн үндэсний танхим гэж яриад байгаа. Тэгээд Үндэсний танхимын дотоод асуудлыг л зохицуулсан хууль орж ирж байх шиг байна л даа. ТУЗ нь яах юм, Ерөнхийлөгч нь яах юм. Их Хурал нь яах юм. Тэгээд дэндүү бас дотроо ер нь дотоод зохион байгуулалтыг дүрмээрээ зохион байгуулж болох маш олон зүйлийг энд тусгачихсан байна л даа. Яах вэ маргаан гардаг гээд. Гэхдээ энэ чинь нэг төрийн бус байгууллага шүү дээ.

Тэгэхээр 1 дүгээр асуулт түрүүн Ганхуяг гишүүн ч бас хэлж байна л даа. Маш олон төрийн бус байгууллагууд хоорондоо учир нь олдохгүй хэн нь хаанаа байгаа нь мэдэгдэхгүй гээд. Тэгээд яг 2024 онд бас Мэргэжлийн нэгдсэн холбоодын эрх зүйн байдлын тухай хууль гээд бас баталсан. Тэр хуультай бас хэр уялдаж байгаа юм бол. Тэр хууль бол яг таны хэлж байгаа тэр асуудлыг уг нь шийдэх хууль гэж гэж ойлгож байгаа юм. Мэргэжлийн тэр олон холбоод нэгдээд 1 холбоотой байх нь гээд. Тэгэхээр өнөөдрийн орж ирж байгаа хууль бол ерөөсөө Үндэсний танхим гэсэн нэг ёсондоо энэ дээр бол нэлээн монопол эрх авсан төрийн эрх мэдлийг шилжүүлж авсан нэг байгууллагын дотоод асуудлыг нь зохицуулж байгаа л хууль гэж харагдаад байна л даа.

2 дугаарт Засгийн газраас өгсөн тэмдэглэл дээр бол бас ялангуяа энэ Худалдаа, аж үйлдвэрийн танхимын нийт орлогыг дийлэнхийг нь бүрдүүлэх хэд хэдэн сувгийг болохоороо Засгийн газар бол бараг гааль дээрээ байх нь зөв гэсэн агуулгатай юм ирчихсэн байна шүү дээ. Тэгэхээр энийг та бүхэн юу гэж тусгаж хэлэлцэж явж байгаа вэ.

3 дугаарт ер нь ХАҮТ гэдэг бол бизнесийн цэг дээр бүгдийнх нь төлөөлөл байх ёстой. Зөвхөн топ 100 биш, жижиг, дунд үйлдвэрлэлийн нэлээн том төлөөлөл байх ёстой. Тэгэхээр хувийн бизнес ч гэсэн жижиг, дунд үйлдвэрлэлийн эсвэл бизнесийн төлөөлөл дуу хоолой маш багатай байдаг гээд зөндөө л асуудал яваад байдаг. Энэ асуудал энэ дээр хэрхэн тус тусгагдаж байгаа вэ.

4 дүгээрт бас нэг чухал асуудал ерөөсөө яаж энийг нэгэнтээ төрийн зарим үйлчилгээг өөр дээрээ авч биелүүлж байгаа нь бол бараг зөв л дөө. Энэ бол зөв. Гэхдээ энийг яаж улс төрөөс ангид байлгах вэ. Яаж төрийн үйлчилгээ үзүүлдгээс илүү хурдан шуурхай бизнесийг дэмжсэн байлгах вэ гэдэг. Тэгэхээр гол зарчмынхаа 1 дээр улс төрөөс ангид байна гээд оруулчихсан байна. Ер нь үе үе бол дандаа улс төрийн томилгоо явж ирсэн. Энийг ер нь яаж хамгаална гэж бодож байгаа вэ. Хамгийн гол зарчим л энэ шүү дээ. Улс төрөөс ангид байлгаж чадах юм бол хуультай, хуульгүй бараг өөрөө бие даагаад ажиллаад явчхаж болно. Тэгэхээр энэ улс төрөөс ангид байлгах дээр яах вэ.

5 дугаарт төрийн өмчит компанийг түрүүн хариулж байна л даа. Тусад нь оруулчихсан. Яг ингээд л явахаар чинь хувийн бизнес тусдаа юм шиг, төрийн өмчит компани гээд 1 тусдаа юм шиг. Энэ 2 нь адилхан бизнес хийж байгаа мөртөө хоёулаа хоорондоо ингээд нийлэлтгүй эсвэл хуулиар хүртэл хязгаарлачихдаг. Энэ байдал бол нэг их тийм эерэг үр дүн авчрахгүй л байх. Энэ дээр бас.

Л.Соронзонболд: Хууль санаачлагч Ганхуяг гишүүн хариулна.

Х.Ганхуяг: Яг 1 дүгээр асуулт, 5 дугаар асуулт 2 чинь бол үндсэндээ яагаад тэр даргыг нь энэ хуулиар сонгох вэ. Удирдах зөвлөлийн яагаад ингэж хийх вэ. Тэр гишүүдийн хурлыг яагаад зохион байгуулж хийх вэ гээд. Яагаад хуульд оруулаад байгаа шалтгаан нь ерөөсөө л таны асуугаад байгаа асуулт, хариулт юм. Дүрэм гэхихээр энэ чинь 1997 онд анх энэ хууль нь батлагдаад, тэгээд дүрмээрээ зохицуулдаг байсан юм. Тэгэнгүүт анхны дарга нь 20 гаруй жил тэнхимийнх нь дарга хийсэн. Тэгээд 1 намаас дэвшсэн. Өнөөдөр тэнхимийн бүх дарга аль нэг намаас дэвшээд л явж байгаа. Энийг л засаж байгаа юм. нэг ёсондоо аль нэг том дарга энэ тэнхимийн дарга дээр энэ хүнийг тавь гэх боломжгүй болно гэсэн үг. Яагаад вэ гэхээр тэр бол бүх нийтийн гишүүдийнхээ хурлаар сонгогдоод орж ирэх ёстой. Тэгээд тэр нь хэдэн жилд ямар интервалаар, яаж явах вэ гэдэг нь хуульчилчихсан байгаа шалтгаан нь энэ. Тэрнээс биш өмнө нь болохоор чинь дүрмээр явна гэхээр бараг хурал хийхдээ дүрмээ өөрчлөөд, тэгээд тэр дүрэмдээ тааруулаад л дарга цэргээ сольчихдог байсан байхгүй юу. Тийм учраас энэ хуульд ингээд оруулаад байгаа асуудал нь тэр юм.

Энэ тэнхимийн хуулийг оруулж ирээд өнөөдөр бас хамт хэлэлцээд явах шалтгаан нь өнөөдөр бид нар яг Зөвшөөрлийн хууль хэлэлцээд явж байгаа юм. Зөвшөөрлийн хууль чинь бас ялгаа байхгүй салбар болгоны зөвшөөрлүүдийн уялдаа холбоотой асуудал тэн дээр явж байгаа юм. Тэнхим бас зөвшөөрлийн зүйлд ордог. Тэгэхээрээ бид нар энэ зөвшөөрлийн хууль энэ тэнхимийн хууль 2 чинь хоорондоо ерөөсөө хүйн холбоотой юм шиг байгаа юм. Тэгээд тэр салбар тэнхимүүдийг бий болгох, салбар тэнхим нь өөрөө тэр салбараа төлөөлөх чадамжтай болох гэдэг асуудал нь маш чухал байгаад байгаа юм. Тэгэхгүй бол тэр 200 төрийн бус байгууллагын хэнтэй нь харьцах юм. Яг л тэр аялал жуулчлал дээр бас яг ийм асуудал үүссэн байхгүй юу. Тэгээд өнөөдөр бол нэгдсэн холбоо байгуулагдсанаар тэр аялал жуулчлалын салбарын бүх юм нь аятайхан зохицуулагдаад явж байгаа. Сайн жишиг болоод явж байна.

Энэ жил бас энэ хаврын чуулганаар Эдийн засгийн тусгай бүсийн хуулийг өргөн барих гээд бэлдэж байна. Эдийн засгийн тусгай бүс нь ялгаа байхгүй ингээд л тэнхим, зөвшөөрлийн хуультай бас уялдаа холбоотой тийм хууль байгаа. Тэгэхээр энэ бүх хуулиуд чинь өөрсдөө эргээд бизнесийн орчныг дэмжих, тэгээд энэ чинь нөгөө мэргэжлийн боловсрол гээд уялдаа холбоотой асар олон юм бий. Энэ чинь боловсрол, тэнхимийн бас оролцуулах шаардлагатай байгаа гэсэн салбарууд их байгаа байхгүй юу. Тэгэхээр тийм учраас бүх орон би бүх оронд ч юу яах вэ дээ. Ямар ч байсан 100-аад оронд тэнхимийн хууль гээд байна. Тэнхимээ байгуулчихсан явж байна. Энэ ч тусдаа хуулиараа зохицуулагддаг субъект байгаа юм.

Өнөөдөр эдийн засгийн олон асуудлууд яагаад бид нар ингээд дандаа оновчгүй шийдэж явдаг вэ гэхээр бид судалгаа хийлгэж үзлээ л дээ манайд жишээлбэл эдийн засгийн тэргүүлэх чиглэл гээд хуулиар, Засгийн газрын тогтоолоор, Их Хурлын тогтоолоор хэдэн тэргүүлэх чиглэл байдаг гэж бодож байна. Та 1 тоо хэлээд үз дээ. Эдийн засгийн тэргүүлэх чиглэл 200-аад байна. 170, 180 тэргүүлэх чиглэл байна. Тэгэхээр чинь манайд яаж эдийн засаг хөгжих юм бэ. Яаж тэр тэргүүлэх чиглэлүүд хөгжүүлэх юм бэ. Асуудал нь ийм байгаа байхгүй юу. 180 тэргүүлэх чиглэл байна. Тэнхим өөрөө ийм сул дорой байхаар манайд бизнес яаж хөгжих юм бэ. Яаж оновчтой татварын бодлоготой болох юм бэ гэдэг л асуудал байхгүй юу даа. Өнөөдөр бизнесийг хэн төлөөлөх юм гэдэг бүгдээрээ маргаад л сууж байна шүү дээ. Тэр ажил олгогч эздийн холбоо гээд нэг нөхөр гарч ирээд сууж байдаг. Энд тэнхим гэхээр 20, 30 тэнхим гараад ирдэг. Авто замын салбар гэнгүүт чинь 70, 80 холбоо гараад ирдэг. Аялал жуулчлалын салбар гэсэн чинь 200 гаруй холбоо гараад ирдэг. Төр өөрөө хэнтэй ярих вэ гэдэг нь асуудал болдог. Яг энэ зөвшөөрлийн хуулийг бичээд явж байхад асуудал ерөөсөө л ийм байсан байхгүй юу. Төрийн байгууллага нь ороод ирдэг, хувийн хэвшил нь ороод ирэхээр 5, 6 холбоо орж ирээд нэгнийгээ хүлээн зөвшөөрөхгүй. Тэгээд хэрэлдээд гараад явчихдаг.../минут дуусав/

Л.Соронзонболд: Энхтүвшин гишүүн нэмж хариулъя.

Д.Энхтүвшин: Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Ер нь бол улс эх орон хөгжихийн тулд бол стэк холдерууд буюу оролцогч талууд бүгд идэвхтэй оролцож байж энэ улсыг хөгжих бололцоо боломжуудыг бий болгоно. Өөрөөр хэлбэл энэ оролцоог институцүүд бий болж байж энэ нь чадавхтай байж байж энэ хөгжлийн тухай асуудлууд илүү өөр шатад гарна. Тэгээд одоогийн хувьд бол институцийн хөгжил бол ер нь улс төрийн намаас өөр бараг хөгжихсөн институц бараг байхгүй болчихоод байна. Тэгэхээр түрүүн бас Эрдэнэбат гишүүн хэлж байсан. Өмнөх энэ харилцаанд бол үйлдвэрчний эвлэл, танхим, ажил олгогч гэдэг энэ бол нийгмийн гол стэк холдеруудын хувьд бол энэ оролцоог хангах үүднээс ийм хууль, эрх зүйн зохицуулалтууд хийж байсан. Тэгээд энэ танхимын хууль маань 1995 оноос хойш өнөөдрийн хувьд бол шаардлага хангахгүй байгаа учраас энэ институцийг нийгэмд бас идэвхтэй оролцоог .../минут дуусав/

Л.Соронзонболд: Батнайрамдал гишүүн тодруулж асууя.

О.Батнайрамдал: Тэгэхээр маш тодорхой хариулт авмаар байна. Хар даа Монголын бизнесийг аваад үзэх юм бол уул уурхайгаас бусад нь бол жижиг, дунд үйлдвэрлэл дийлэнх нь байхгүй юу. Тэгэхээр тэдгээрийн төлөөллийг яаж баталгаажуулах юм бэ л гэж асуугаад байгаа юм. Эсвэл үнэхээр тэгж удирдах зөвлөл гээд нарийн деталийг оруулж байгаа бол тэд нарын төлөөлөл 30 хувьд нь

байна ч юм уу тийм тодорхой байлгамаар байгаа юм. Тэгэхгүй бол яг энэ маргаан 1 дүгээрт дуусахгүй.

2 дугаарт улс төрөөс ангид байлгахгүй л бол энэ хэчнээн гоё удирдах зөвлөлийн 11 гишүүн гэж тодорхой оруулаад оруулаад асуудал дуусахгүй ээ. Тэгэхээр жишээлбэл энийг бас улс төрчид бэлтгэдэг курс болгомооргүй л байгаа байхгүй юу. Өнөөдөр Худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч нь өөрөө улс төрч болоод сууж байна шүү дээ. Хуулиа гаргачихсан. Тэгэхээр яг ийм юмнаас л бид нар ангижирмаар байгаа байхгүй юу. Тэгэхээр хэлэх гээд байгаа санаа улс төрөөс яаж ангид байлгаж болох бүх хаалтыг л энэ хууль дээр оруулах хэрэгтэй байна. Одоогийн Ерөнхийлөгчийг нь жишээлбэл аваад үзэх юм бол улс төрч байж байгаад орж болохоор ийм орон зай энэ дээр харагдаад байна гэж байгаа юм. Тэгэхээр яг энэ дээр тодорхой хариулт авъя.

Л.Соронзонболд: Хууль санаачлагч Энхтүвшин гишүүн хариулъя.

Д.Энхтүвшин: Батнайрамдал гишүүний хөндөж байгаа асуудал маш зөв. Тэгээд энэ нийгмийн гол чухал институцийн хувьд бол улс төрөөс хараат бус байлгах нь маш чухал байгаа учраас үүнтэй холбоотой энэ дүрэм дээр яаж тэр удирдлагыг нь сонгодог, энэ бодлого шийдвэрт яаж нөлөөлдөг юм, энэ бүтцүүдийг яаж сонгодог юм гэдгийг нарийн заахын тулд бүтэцтэй холбоотой заалтууд орсон байгаа. Ерөнхийлөгч нь улс төрийн намын харьяалалгүй байх талаар асуултууд байгаа. Тэгэхээр үүнтэй холбоотой заалтуудыг чухалчилж оруулсан байгаа. Тэгээд жижиг, дунд үйлдвэрлэлийн хувьд болохоор өмнө нь аж ахуйн нэгжүүд өөрөө үндэсний танхимдаа орчихдог байсан учраас энэнд жишээлбэл жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн хувьд бол төлөөлөл маш бага. Голчлон том компаниуд ордог байсан. Тэгэхээр үүнтэй холбогдуулаад аж ахуйн нэгжүүд нь өөрсдийнхөө салбарын танхимууддаа орж байгаа учраас энэ нь илүү төлөөллөө хангаж идэвхтэй оролцоо хангах бололцоотой. Дээр нь бас энэ нэг эцсийн өмчлөгчтэй аж ахуйн нэгжүүд тухайн салбарын танхимын удирдах зөвлөлийнх нь .../минут дуусав/

Л.Соронзонболд: Батнайрамдал гишүүн нэмж тодруулъя.

О.Батнайрамдал: Энэ 9.1 дээр танхимын Ерөнхийлөгчийг тодорхойлсон байгаа юм. Улс төрийн намын харьяалалгүй гээд. Тэр чинь намаасаа гялс гараад л орчихдог байхгүй юу. Эсвэл ямар нэгэн байдлаар харьяалалтай яваад байдаг. 10-аас доошгүй жил жишээлбэл аж ахуйн үйл ажиллагаа эрхэлсэн. Тэгвэл сүүлийн 10 жил улс төрийн албан тушаал хашаагүй байна гээд бүр ойлгомжтой болгож оруулах бүх хаалтыг хийхгүй бол хамгийн улс төрждөг, 21 аймагт салбартай учраас улс төрд ашиглагдах боломжтой туйл чинь өөрөө ХАҮТ болоод яваад байгаа шүү дээ. Тэгэхээр энийг л жишээлбэл яримаар байгаа юм.

Та бас дээрээс нь энэ хуулийг ярихдаа бас яг ингээд улс төрч болоод ордоггүй гэдэг яг өөрийнхөө жишээг бараг дурдаж байгаад ярих ёстой шүү. Дахиад ийм жишээ бүгдээрээ гаргахгүй байхын тулд энэ хуулиа зөв болгоод л явах ёстой л гэж үзэж байгаа юм. Санал байлаа.

Л.Соронзонболд: Хууль санаачлагч Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Энэ дарга болох тэр этгээд дээр яагаад энэ шалгууруудыг оруулаад өгөөд байна гэхээр хэрвээ зөрчиж байвал захиргааны шүүхэд өгөх боломж бүрдэнэ гэсэн үг. Дүрмийг бол яаж бол яаж бичиж болно. Дүрмийг бол тэр

байгууллагын дотоод дүрмийг бол зүгээр хэдүүлхнээ сууж байгаад бичээд, тэгээд л батлаад л явчихдаг шүү дээ. Тэгээд таны яриад байгаа эргэлзээ чинь энэ хууль нь өөрөө байхгүй юу. Хуульд яагаад эд нарыг оруулаад байна гэхээр цаашдаа тийм асуудал үүсгэхгүйн тулд энийг оруулаад байгаа. Тэгээд насаараа суухгүйн тулд 4 жилд 1 удаа гээд байгаа юм. Сонгох процедурыг нь яагаад оруулаад байна гэхээр хэн нэгний даалгавраар тэнд танхимын даргыг тавьдаг асуудлыг байхгүй болгохын тулд энийг оруулаад байгаа юм. Энэ асуултын хариулт нь ерөөсөө энэ.

2 дугаарт жижиг, дунд үйлдвэрлэлтэй холбоотой асуудал дээр энэ тухайн салбар тэнхимүүдийг байгуулах эрхүүдийг нь олоод байгаа асуудал нь юу вэ гэхээр ЖДҮ гээд та нар бүх салбарын юмнуудыг бүгдийг нь нэг сагсанд хийх гээд байгаа байхгүй юу. Энэ чинь өөр шүү дээ. 8 нэрийн бараа ажиллуулдаг .../минут дуусав/

Л.Соронзонболд: Мөнхсоёл гишүүн асуулт асууя.

Б.Мөнхсоёл: Юуны өмнө өдрийн мэнд хүргэе. Тэгээд ихэнх гишүүд бас давхацсан асуулт асуусан учраас би тодорхой хэдэн зүйлийг л маш товч хариултаар авчихъя гэж бодож байна.

1 дүгээрт нь бид нар хамт ХАҮТ дээр уулзалт хийсэн шүү дээ. Тэгэхэд бас Монголын Банкны холбооныхон ч гэсэн хэлж байсан. Ер нь ийм нэг амбрелла нэг дээвэр дээр ороод үндэсний нэг танхим доор гишүүд болохоор ингээд орох сонирхол жоохон тааруу байна уу даа гэж харсан. Тэр утгаараа ер нь тэд нарын санал болон энэ ХАҮТ-ынхны одоогийн ажиллаж байгаа хүмүүсийнх нь саналыг хэр тусгасан бэ. Тэгэхгүй бол маргаан цаашаа үргэлжлэх байх гэж хараад байна. Ойлгож байна. Институцлэх гээд байна буюу яг бизнесийн секторынхон олон жижиг томгүй ийм танхимууд нийлж байгаад чанга хүчтэй дуу хоолойтой больё гээд байна шүү дээ. Төртэй 1 шугамаар ажиллая гээд. Гэтэл нөгөө талдаа энэ чинь эрх мэдлийн хуваарилалт болоод гишүүнчлэлийн асуудал болоод энэ чинь цаанаа бас нэг өөрсдийн байгууллагаа хадгалмаар байгаа шүү дээ. Тэрийг нь яаж зөрчилдүүлэхгүйхэн шиг зөв авч явах вэ гэдэг нэг ийм асуудал байна.

2 дугаарт нь 16 дээр тэр олон салбарын гишүүн байж болно гэж байна шүү дээ. тухайн аж ахуйн нэгж шууд танхимын гишүүн болохгүй. Сонирхсон салбар салбарынхаа гишүүн байж болно гэж байна. Тэр тохиолдолд татвараа яаж төлөх юм. Жишээлбэл тэр олон танхимуудад олон дахин татвар төлөх юм уу. Энэ зохицуулалт нь яаж явах юм. Танхим бол 80, 20 хувьтай гээд түрүүн нэг юм ярьчихав уу. Тэрийг бас тодруулмаар байсан. Тэр 17 дугаар зүйлийн татварын асуудал.

26 дугаар зүйл дээр болохоор бусад жишээлбэл, Лондоны арбитрын юу гэж байдаг шиг үндэсний танхимаас гадна Улаанбаатар танхим арбитрын үйлчилгээ энэ тэр үзүүлж болох уу гэдэг дээр өмнө нь бас 1 гишүүн асуугаад байх шиг байна лээ.

27 дугаар зүйл энэ Батнайрамдал гишүүн бас асуугаад байна. Хараат бус байна. Энэ үндэсний ХАҮТ гээд. Энэ үг бол хаа сайгүй байдаг. Монголбанк ч хараат бус байх ёстой. Монголын Үндэсний олон нийтийн радио, телевиз ч хараат бус байх ёстой гээд бүх л юмнууд институтийнхээ чанарыг хадгалаад, хараат бусаар гол зорилг хүрэх ёстой гэдэг боловч бодит байдал дээр хараат бус байж чаддаггүй байхгүй юу. Тэр дээр тэгээд бусад гишүүд санаа зовоод байх шиг байна. Тэгэхээр энэ дээр хараат бус байхын тулд бас нэг оруулж өгөх өнцөг нь хариуцлагын асуудал байхгүй юу. Хараат бус байх, яг гишүүнчлэлтэй гишүүддээ үйлчилж чадахгүй байх,

зорилг хүрэхгүй байвал институц юм бол чек энд баланс гэж ярьдаг. Нөгөө хяналтын хариуцлагын хэсэг нь хаанаа байгаа юм бэ гэж асуумаар байгаа юм.

Нэмээд хамгийн сүүлийн асуудал бол тэр топ 100. Яагаад топ 100 гэж. Тэгвэл топ дундаж, топ бичил, топ жижиг гэвэл яадаг юм. Ажлын байр бий болгож байгаа хамгийн бас гол хэсэг чинь тэр жижиг, дунд, бичлүүд мөн юм чинь тэд нарыгаа бас сайшаая л даа. Тэд нарыгаа бас урам өгье л дөө. Тэд нарыгаа бас чухал шүү гэдгийг нь мэдрүүлье л дээ. Яагаад зөвхөн топ 100 гэж. Топ 100 чинь хүртэл начир дээрээ асуудалтай байна гээд түрүүний өмнөх гишүүн хэлж байна шүү дээ.../минут дуусав/

Л.Соронзонболд: Хууль санаачлагч Энхтүвшин гишүүн хариульъя.

Д.Энхтүвшин: Мөнхсоёл гишүүний асуултад хариульъя. Топ 100-тай холбоотой асуудал энэ хууль дээр байхгүй. Тэгэхдээ танхим дээр бас энэ санаачилга явж байгаа. Топ 500 гэдэг. Өөрөөр хэлбэл ер нь эдийн засгийн бүтцийг харах үүднээс энэ санаачилга яваад, эхний ирсэн мэдээлэлдээ тааруулаад 250-ийг шалгаруулж, өөрөөр хэлбэл энд жишээлбэл Монгол Улсынхаа эхний топ 500-д ордог, 250-д ордог гэдэг энэ бололцоо боломжуудыг бас аж ахуйн нэгжүүд өөрийгөө сурталчлах ийм бололцоо, боломжуудыг харах, нөгөө талаас бас эдийн засгийн багцаа баримжааг харах үүднээс иймэрхүү асуудлууд бас хийж байгаа. Тэгээд танхимын гишүүн болон энэ хууль батлагдахаас өмнө ер нь салбарын олонхын төлөөллөө авсан мэргэжлийн холбоод, салбарын холбоодтой уулзалт хийж байсан. Тэгэхэд бол ерөнхийд нь энэ холбоод яг энэ танхимын шинэ хуулийн үзэл баримтлалын хүрээнд энэ хууль дээр заачихсан байгаа нь 11-ийн тэр гэрээний үүргээ шилжүүлж болох заалт байгаа. Салбарын олонхын төлөөлөн авчихсан бол 11.6 дээр тийм холбоодод дахиж зэрэгцүүлж салбар танхим байгуулахгүйгээр эрх, үүрэг үүргийг нь шилжүүлж өгөхөөр заачихсан байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл энэ аж ахуйн нэгжүүд, холбоод өөрсдөө яг энэ танхимын нэг хэсэг болоод явах бололцоотой.

Үндэсний танхим гэдэг чинь ер нь бол хүмүүсийн хувьд яг энэ танхимыг одоогийн байгаа бүтцээр бодоод байх шиг байна. Үндэсний танхим гэдэг нь танхимуудын танхим, холбоодын холбоо болчихоор энэ чинь яг бүрдүүлж байгаа хэсгүүд нь тэр том хэдэн компаниуд биш, салбарууд нэгдэж байгаа байхгүй юу. Жишээлбэл банкны салбар нь түрүүн би хэлж байсан уул уурхайн салбар нь тээвэрлэлтийн салбартайгаа санхүү банкныхаа салбартай ярьдаг, салбар дундын бодлогоо ярьдаг энэ бололцоо боломжуудыг Үндэсний танхим дээрээ нээж өгч байгаа юм. Тэгээд олон салбарын гишүүн байж болохоор байгаа тэр төлбөрүүдээ болохоор жишээлбэл 1 компани 2 төрлийн үйл ажиллагаа явуулдаг уул уурхай ч юм уу, аялал жуулчлал 1 нэр дээр хийж явдаг бол энэ 2 салбар танхимд хоёуланд нь элсэж болохоор. Тэгэхдээ энэ нь тухайн салбар танхим дээрээ төлбөрөө яаж төлөх юм гэдгийгээ Удирдах зөвлөлөөс тогтоосон тэр хэмжээгээрээ төлөөд явахаар ийм байгаа.

Танхимын арбитрын хувьд бол үндэсний танхим дээр арбитр байгаа. Улаанбаатар хотын танхимын дэргэд ч гэсэн арбитр байгаа. Тэр арбитрын үйл ажиллагаанууд тэр чиг үүргээ шилжүүлж болох заалт бас байгаа. Тэгэхээр тусдаа арбитрын үйл ажиллагаанууд ингээд эрхлээд явж байгаа. Энэ нь бол үргэлжлээд явах бололцоотой.

Хариуцлагын хувьд болохоор танхимын Ерөнхийлөгч энэ асуудлын хувьд бол салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн, салбарын танхимууд жишээлбэл уул уурхайн ассоциаци ч гэдэг юм уу, эрчим хүчний танхим, ноос ноолуурын холбоо гэдэг энэ

салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн Ерөнхийлөгчдийнх нь тэр дарга нарын дундаас танхимын Ерөнхийлөгчийг тавих байхгүй юу. Тэрнээс биш хаа хамаагүй энд тэндээс хүн орж ирээд танхимд өрсөлддөг ийм асуудал байхгүй. Өөрөөр хэлбэл энэ нь өөрөө хариуцлагыг нь тэр салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн этгээд энэ танхимыг төлөөлөх ийм бололцоо боломжуудыг энэ хуулиар нээж өгч байгаа юм.

Л.Соронзонболд: Очирбат гишүүн асуулт асууя.

Г.Очирбат: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Тэгээд үг, өгүүлбэр 2 нь дандаа ингээд зөрөх юм. Аягүй хэцүү юм. Үнэхээр хэцүү юм. Ингээд хууль санаачлагч нар маань ярихдаа их гоё ярих юм. Энэ либералчилъя, төр оролцохгүй байя, улс төрөөс ангид байя гээд ингээд л ярих юм. Тэгээд оруулж ирж байгаа хуулийн төслөө та хэд сайхан унш л даа. Хуулийн төслийг чинь 6.3 дээр бүр аймшгийн юм биччихсэн байна шүү дээ.

6.3 дээр ХАҮТ нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19.1-д заасан холбогдох шийдвэрийн дагуу төрийн гүйцэтгэх байгууллагын зарим чиг үүргийг хэрэгжүүлж болно гээд. Тэгээд Засгийн газартай гэрээ хийж та нар мөнгө авах гээд байна шүү дээ. Үгүй ээ, тэгээд энийгээ больчих л доо. Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль орж ирэхээр л энэ орж ирдэг. Танхимын тухай хууль орж ирэхээр л энэ орж ирдэг. Тэгээд яах гэж байгаа юм. Засгийн газарт ярьж тохироод мөнгө аваад, гэрээгээр ажил гүйцэтгээд, тэгээд ар дээр нь Засгийн газрын шийдвэрийг л дэмжих гэж байгаа шүү дээ. Энэ төрийн бус байгууллага гэдэг чинь энэ ардчиллын бас мөн чанар шүү. Тэнд эвлэлдэн нэгдэж, дуу хоолойгоо нийлүүлж, төрийн болохгүй байгаа юмыг яг энэ хувийн хэвшлийнхэн буюу аж ахуйн нэгжүүд, бизнесүүд чинь нийлж байж үг, үзэл бодлоо илэрхийлж, энэ нь хуулийн төсөл цаашаа бодлого болоод хэрэгжих ёстой. Тэгээд ярихаараа их гоё ярих юм. Орж ирж байгаа юм чинь дандаа нэг ийм юм орж ирнэ.

Дараагийнх нь хуулийн төслийн 18.4 бүх шатны төрийн байгууллага, албан тушаалтан ХАҮТ-д ийм дэмжлэг туслалцаа үзүүлнэ гээд оруулаад ирж байгаа юм. Тэгээд яах гэж байгаа юм. Танхим энэ хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүд нийлж хамтарч болж бүтэхгүй байгаа татварыг бууруулъя, төрийн хүнд суртлыг багасгая, зөвшөөрлөөс салъя гээд явж байгаа үед үгүй ээ, тэд нарын тусламж дэмжлэг авахаар чинь та хэд чинь дахиад л ард нь атгад нь орчихно шүү дээ. Тэгээд энийг хуульчлах гэж оруулж ирээд байх юм.

Дараагийнх нь тэр хуулийн төслийн 9.1 дээр гишүүд бас хэлээд л байна. Монголын Үндэсний танхимын Ерөнхийлөгч нь улс төрийн намын харьяалалгүй байхаар зааж байна гэж байгаа юм. Тэгвэл одоо яаж ойлгох вэ. Сонгогдох үедээ улс төрийн намын харьяалалгүй байх юм уу, сонгогдсоныхоо дараа өгөх юм уу. Тодорхой заалт байхгүй. Тэгээд 1 ийм байдал чинь ерөөсөө ингээд төөрөгдүүлээд байна шүү дээ. Тэгээд бид нар Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг энэ жилийн 1 сарын 20-нд танхим дээр очиж хэлэлцүүлсэн. Энэ танхимынхан бас МУИС-ийн хуульч нар, профессор, доктор мэргэжлийн хүмүүстэй яриад энэ хуулийн төсөл бас боловсруулсан юм байна лээ шүү дээ. Энэ ажлын хэсгийнхэн бид нарын үгийг сонсохгүй байна л гээд байсан. Тэгээд энэ ажлын хэсгийн хүмүүс бас хариулаарай. Сонссон юм уу, сонсоогүй юм уу. Ингээд үндсэн 4 асуулт.

Дараагийнх нь танхимынхан нь түрүүн бас хариулж байх шиг байна. Тэр 66 кодтой дотоодын үйлдвэрлэл, үндэсний үйлдвэрлэгч нартаа код өгдөг. Бар код. Наадах чинь ерөөсөө энэ хилийн чанадад гараад тэр бар кодыг чинь авч очоод

гадаа шошго дээрээ зөвхөн үйлдвэрлээд л наагаад л орж ирдэг болчихсон шүү дээ. Алийг нь үндэсний үйлдвэрлэл гэж ялгах гээд байгаа юм. Тэгээд бид энд хөгжлийн 5 жилийн хөтөлбөр, жилийн хөтөлбөр .../минут дуусав/

Л.Соронзонболд: Хууль санаачлагч Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Тэр Засгийн газрын юуг хэрэгжүүлнэ гэдэг чинь нөгөө Зөвшөөрлийн хуультай яагаад уялдаатай вэ гэдгийг бас дахиад хэлъе. Чөлөөлъе, түр зөвшөөрлөө багасгая, зарим зөвшөөрлүүдээ хувийн хэвшлийн төлөөний байгууллагуудаар олгуулдаг больё. Төрийн бус байгууллагаар олгуулъя. Энэ Боловсролын хууль дээр бол мэргэжлийн боловсрол дээр тэнхимийн үүрэг рольтой оролцож байгаа. Тэнхим өөрөө. Тэр нь юу вэ гэхээр ажил олгогчтой холбож өгөх үүрэг рольтой оролцдог юм. Жишээлбэл, Боловсролын хуулиар гэх мэтчилэн энэ тэнхимтэй холбоотой асар олон салбарын хуулиуд байгаа. Тэр асуудлыг л хэлж байгаа юм. Тэрнээс биш тэнхим ингээд үйлчилгээний хураамж аваад, төрийн үйлчилгээг үзүүлэх гээд байгаадаа биш. Харин тэр хүнд суртлыг зарим нэг хэсгийг нь энэ хувийн хэвшил буюу төрийн бус байгууллага буюу тэнхим эд нар луу шилжүүлэх асуудлыг л ярьж байгаа юм.

Миний санаж байгаагаар 2 дахь асуулт нь юу байлаа. Яагаад энэ тэнхимтэй холбоотой асуудлыг орж ирээд ингэхээр цөмөөрөө харъя. Сая ажил олгогч эздийн холбоодын асуудлыг ярилаа. Бусад салбар яамдыг хараарай. Барилгын ассоциаци гээд байна. Барилгын ассоциаци хэд байдаг гэж бодож байна. Та 1 тоо хэлээд үзэхгүй юу. Жишээлбэл тийм ээ. Би аялал жуулчлалын холбоог хэллээ шүү дээ. Манай аялал жуулчлалын холбоо гэсэн чинь 200 гаруй явж байдаг. Чи юу гээд загнаад байгаа юм бэ. Үгүй ээ, чи зүгээр хариулж байхад юу гээд орилоод байгаа юм. Үгүй ээ, би чамаас зүгээр жишээ болгоод ярьж байна шүү дээ. Чи юу гээд томроод байгаа юм. Тэгээд зүгээр ярьж байхад чи юу гээд томроод байгаа юм бэ.

Л.Соронзонболд: Ганхуяг гишүүн асуултад хариулъя.

Х.Ганхуяг: Үгүй ээ, би хариулаад л явж байна шүү дээ. Үгүй ээ, чи тэгээд дуугүй байж л бай л даа. Би юмаа хариулаад дуусгачихъя.

Л.Соронзонболд: Энхтүвшин гишүүн хариулъя.

Д.Энхтүвшин: Очирбат гишүүний асуултад хариулъя. Тэгээд ер нь бол энэ хууль дээр төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх, ер нь төр дээр хийж байгаа зарим чиг үүргүүдийг жишээлбэл төр дангаар нь үлдээчихээр нэг талаас хэтэрхий барьсан асуудлууд гардаг учраас ер нь бол түрүүн хэлсэн 5 жилийн үндсэн төлөвлөгөө дээр ч гэсэн энэ аажмаар төрийн гүйцэтгэж байгаа чиг үүргүүдийг хувийн хэвшилд шилжүүлэх, ялангуяа энэ мэргэжлийн төрийн бус байгууллагуудад нь шилжүүлэх иймэрхүү бодлого барьж байгаа. Тэгэхээр энэ хүрээнд нь энэ заалтыг баталгаажуулах үүднээс оруулсан байгаа юм.

Дээр нь нөгөө талаас энэ төрийн байгууллагуудын хувьд бол жишээлбэл яг энэ бүтцэд ороод ажиллахаараа хувийн хэвшлийг ерөөсөө дэмждэггүй, үл тоодог байсан учраас дэмжих үүднээс энэ тодорхой хэмжээний шахах үүднээс энэ дэмжлэг туслалцаа үзүүлнэ гэдэг ийм заалт оруулсан байгаа юм.

Одоогийн энэ танхимын удирдлага бас хуулийн төсөл тусдаа өөр байгууллагуудаар судалгаа хийлгэсэн байна лээ. Энэ төслийн хувьд бол хууль

өргөн барьж байгаа гишүүдийн хувьд бол бүрэн эрхийнхээ хүрээнд энэ хуулийн төслийг боловсруулсан байгаа. Тэгээд ажлын хэсгийн явцад хэрвээ хууль дэмжигдэх эсэх нь хэлэлцэгдэж дэмжигдвэл энэ асуудлыг үргэлжлүүлж ажлын хэсэг дээр ярилцаж, нөгөө саналыг тусгах, зарим заалтуудыг нь харгалзаж үзэх иймэрхүү бололцоо боломжууд байгаа гэж хэлмээр байна.

Л.Соронзонболд: Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: Ер нь сүүлийн 10 жилд бол Монгол Улсад хувийн хэвшлийн орон зай гэж бараг байхгүй болсон. МАН-ын хулгай, ковид 2 хавсраад гэдэг шиг ер нь бол манай бизнес эрхлэгчдийг бол элгээр нь хэвтүүлсэн байгаа. Тэр хугацаанд бол энэ нийтлэг бизнес эрхлэгчдийн эрх ашгийг төлөөлөх хамтын байгууллагууд нь ч гэсэндээ ажлаа хийгээгүй гэж бол би хувьдаа харж байгаа. Энхтүвшин гишүүн өнөөдөр энд гоё юм ярьж байж болно их хурал дээрээ гоё юм ярьж байж болно. Гэхдээ та Монгол Худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч байхдаа тэр Ерөнхийлөгчийнхөө албан тушаалыг эрх баригч намд жагсаалтад нь ороод, тэгээд тэр бүх нэр хүндтэй нь аваачаад тавиад туучихсан. Одоо энэ чинь өөрөө гишүүн болоод сууж байгаа шүү дээ. Тэгээд ийм хууль оруулж ирж байдаг. Надаас хойш бол танхимын Ерөнхийлөгч улс төрч байж болохгүй юм байна гэдэг шиг. Тэгэхээр ийм бас 2 нүүртэй гэдэг шиг ийм энэ байдлаар бас асуудалд бас хандмааргүй байна.

Танхимын өнөөгийн нөхцөл байдал надад бол их сонин санагдаж байна. Энхтүвшин гишүүний араас болохоор бас нэг сонгууль явсан гэж ойлгож байгаа. Тэгээд тэр сонгуулиар гарч ирсэн хүнийг нь бас огцруулаад, одоо үүрэг гүйцэтгэгчтэй ажиллаж байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр тэр одоогийн тэр эрх зүйн байдал чинь ер нь ямар байгаа юм бэ. Тэр дараачийн сонгууль энэ тэр чинь хэзээ явах юм бэ.

Дээрээс нь нэгэнтээ танхимын хуулийг авч хэлэлцэж байгаа нөхцөлд одоогийн энэ танхимынхаа ерөнхийдөө энэ бүтэц, зохион байгуулалт энэ үйл ажиллагаатай холбоотой тодорхой мэдээллүүдийг бас өгмөөр байна. Татвар хураамж төлдөг хэдэн компани байгаа вэ. Аймгийн танхимууд дунджаар хэдэн гишүүн компанитай байдаг вэ. Хамгийн цөөн гишүүнтэй аймаг нь хэдэн гишүүнтэй вэ. Хамгийн олон гишүүнтэй аймаг нь хэдэн гишүүнтэй вэ. Нийт жилийн төсөв чинь хэд вэ. Үүнээс хэдэн хувь нь гишүүдийн татварын орлого вэ. Хэд нь бусад үйл ажиллагааны орлогууд вэ. Ямар төрлийн үйлчилгээнүүдээс орлого олж байна. Түрүүний гишүүдийн асуугаад байгаа гарал үүслийн гэрчилгээ, арбитр гэдэг шиг. Тэгээд одоо байгаа энэ танхимынхаа бүтэц, зохион байгуулалтыг нэлээн сайн бас ойлгомжор байна.

Тэгээд өнөөдөр яг танхимыг төлөөлж хэн ирсэн бэ. Тэр Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч байхгүй гэж хараад байна. Ер нь энэ хууль дээр энэ арын чинь удирдлагаас ямар оролцоотой, ямар байдлаар саналаа өгч ажилласан юм бэ гэдэг байна.

Хуулийн гэдэс дотор луу нь ороход тухайлах юм бол энэ 6.1 дээр танхимын бүрэн эрх гэдэг зүйл дээр ерөнхийдөө дандаа төртэй харилцах зүйлүүд тавьчихсан байна. Ерөөсөө л энэ байгууллага чинь төртэй харилцаад байх юм шиг. Гэтэл 1995 оны хуулийг харах юм бол маш ойлгомжтойгоор гишүүдийнхээ эрх ашгийг хамгаална гэчихсэн байж байна шүү дээ. Тэгэхээр яг үнэндээ бол энэ танхимын эрхэм зорилго нь бол гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалах болохоос биш төртэй

харилцах явдал бас биш шүү дээ. Тэгэхээр чинь энэ чинь ингээд философийн хувьд бол маш тийм өөр ойлголт байгаад байна.

2 дугаарт гол өөрчлөлт нь тэр нөгөө салбар танхимууд байна гэж байна. Тэр эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлийн хэчнээн салбар танхим байна гэж бодож байна вэ. Одоо байгаа энэ бүтцээ бүтэн самраад 50 компани нэгдээд л тэгээд л нэг салбар .../минут дуусав/

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 4 номер хариулъя.

Ц.Магнайбаатар: Эхлээд сонгуультай холбоотой асуултад хариулъя.Магнайбаатар Худалдаа, аж үйлдвэрийн танхимын Гүйцэтгэх захирал. Энхтүвшин Ерөнхийлөгчийг ажлаа өгсний дараагаар бол танхимын ээлжит бус их хурал зарлагдаад, түүний дараагаар Төр-Од гэж хүн танхимын Ерөнхийлөгчөөр сонгогдсон байгаа. Тодорхой хугацаанд үйл ажиллагаа явуулаад, тодорхой хэмжээний зөрчил дутагдлууд гаргасан учраас танхимын удирдах зөвлөлийн 75 гишүүн хуралдаад Төр-Одыг түр үйл ажиллагаа явуулах боломжгүй гээд итгэл үзүүлээгүй, чөлөөлсөн. Тэгээд чөлөөлсний дараагаар удирдах зөвлөлийн гишүүд дундаасаа Лхагважав гээд одоогийн өнөөдрийн танхимын Ерөнхийлөгчөөр ажиллаж байгаа Баатаржавын Лхагважавыг танхимын Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгчээр томилсон байгаа. Ээлжит сонгууль бол 2027 онд болох ийм хуваарьтай байгаа. Энэ хэрвээ хууль батлагдаад, хэлэлцэх нь дэмжигдээд, хууль батлагдсан тохиолдолд бол шинэ зарчмаар явна. Одоо энэ байгаагаараа үргэлжлэх юм бол 2027 онд бид бүхэн танхимын ээлжит бүх гишүүдийн хурлыг зарлаад, дараагийн Ерөнхийлөгчийн асуудлыг хийх ёстой байгаа.

Танхим өнөөдөр 6768 гишүүн үндэсний хэмжээнд байна. Улаанбаатар хотод 3147, орон нутагт 3621 гишүүн үйл ажиллагаа явуулж байна. Эндээс хамгийн олон гишүүнтэй аймаг гэх юм бол манай Хэнтий аймгийн салбар танхим 440 орчим гишүүнтэй байгаа. Хамгийн бага гишүүнчлэлтэй бол Баян-Өлгий аймагт 44, араас нь Говьсүмбэр аймагт 50 гаруй гишүүдтэй байна.

Танхимын төсөвтэй холбоотой та асуулаа. 2026 оны байдлаар бол Худалдаа, аж үйлдвэрийн танхимын төсөв 10 орчим тэрбум төгрөгөөр батлагдсан байгаа. Төсвийн бүрдлийг үйл ажиллагаанаас оруулж байгаа орлогыг хараад үзэх юм бол арбитр, гарал үүсэл, үзэсгэлэн худалдаа, гадаад үзэсгэлэн худалдаануудаас бүрдүүлж байгаа.

Дээрээс нь танхимын дэргэд Гадаад худалдааны академи гээд академи бий. Академиасаа сургалтын үйл ажиллагааг зохион байгуулдаг. Хурал, уулзалт, форумууд гээд, дээрээс нь бас танхим дээр явуулж байгаа аж ахуйн цайны газар ч гэдэг юм уу ийм үйл ажиллагаануудаас өөрийгөө санхүүжүүлээд ингээд үйл ажиллагааны орлого нь төвлөрөөд явж байгаа.

Гишүүнчлэлийн орлогын хувьд бол танхимын өнөөдрийн байдлаар бол 8-9 орчим хувийг нь гишүүнчлэлийн орлогоосоо бүрдүүлж байгаа. Төв танхим бол.

Түрүүн бас нөгөө Монголын бараа бүтээгдэхүүний кодтой холбоотой асуулт байсан. Тэн дээр бол ХАҮТ бар код буюу 8, 65 гэсэн Монгол Улсын бар кодыг олгодоггүй. GS1 нийгэмлэгээс энэ бар кодыг олгодог. Энэхүү түрүүн гарсан саналууд дээр бол оюуны өмчийн эрхийн хамгаалалтуудыг ХАҮТ хийгээд явж байгаа. Гаднын зах зээл дээр бол оюуны өмчийн эрхийн хамгаалалтуудыг бас хийх

тал дээр ажиллаад, ялангуяа Хятадад манай монголын бараа бүтээгдэхүүнүүд хуурамчаар үйлдвэрлэгдээд, нөгөө 8, 65 гэсэн кодууд маань хэвлэгдэж орж ирээд зарагддаг энэ байдал дээр бол бид бүхэн нөгөө оюуны өмчийн эрхийн хамгаалалтын асуудал дээр араас нь мөрдөж бас Хятадын ССРIT буюу Худалдааг дэмжих хороо, Оюуны өмчийн газруудад нь тодорхой хүсэлтүүдээ гаргаад, ингээд бас анхаарал хандуулаад явж байгаа. Энэ дээр бас дотоодын аж ахуйн нэгжүүддээ энэ олон улсын зах зээл дээр Хятадын болоод энэ бусад зах зээлүүдэд.../минут дуусав/

Л.Соронзонболд: Хууль санаачлагч Энхтүвшин гишүүн хариулъя.

Д.Энхтүвшин: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Надтай холбоотой асуулт асуусан учраас миний хувьд ямар нэгэн улс төрч болох гэж ч юм уу энд орж ирээгүй. Хувийн хэвшлийн эрх ашгийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч байж байхад бид нар олон уулзалт хийдэг байсан. Ямар ч хүч байхгүй. Зүгээр яриад л, сонсоод л явдаг иймэрхүү бүтцүүд байсан. Тэгэхээр тухайн үед санал тавьсан МАН-аас. Тэгээд энэ нийгмийн бүлгүүдийн төлөөлөл тэгээд та нар гаднаас нь ярих биш дотор нь оролцоод өөрчлөх бололцоо боломж байна гэдэг агуулгаар энэ хувийн хэвшлийн хөгжилд тодорхой хэмжээгээр тус дэм болъё гэдэг агуулгаар энэ саналыг нь хүлээж авч, улс төрд орж ирсэн. Энэ саналыг нь хүлээж авч орж ирсэн. Тэгэхдээ өнгөрсөн хугацаанд би бол ямар нэгэн хувийн улс төр биш энэ хувийн хэвшлийн орон зайг нэмэгдүүлэх, энэ төрийн оролцоог багасгах чиглэлээр тууштай явсан. Жишээлбэл, төсвийн зардлыг бууруулах чиглэлээр амласан мөрийн хөтөлбөрийн шаардлага ч гэдэг юм уу, хувийн хэвшлийн орон зайг бууруулж байгаа энэ асуудлуудын эсрэг намын ямар нэгэн үзэл баримтлал баригдалгүйгээр дуу хоолойгоо илэрхийлж ингэж явсан. Тэгэхээр миний хувьд бол ямар нэг улс төрийн ашиг хонжоо хөөж энэ асуудал орж ирээгүй. Яг энэ хувийн хэвшлийн эрх ашгийг сайжруулахын тулд, энэ орон зайг сайжруулахын тулд тодорхой хэмжээний олдсон боломжийг ашиглая гэдэг зорилгоор орж ирсэн байгаа гэдгийг бас Жаргалан гишүүнд хэлье. Баярлалаа.

Л.Соронзонболд: Эдийн засгийн салбарын тухай асуусан. Төртэй харилцах харилцааны тухай асуусан шүү дээ. Хууль санаачлагч Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Яагаад түрүүн би нөгөө тэргүүлэх чиглэлүүдийн тоо, тэр салбар болгоны төрийн бус байгууллагын тоо эд нарыг хэлээд байна гэхээр жишээлбэл, уул уурхай бол манай тэргүүлэх чиглэл мөн үү. Мөн. Тэгсэн мөртөө лиценз олгодоггүй. Банк жишээлбэл манай тэргүүлэх чиглэл мөн үү. Мөн. Шинээр банк байгуулагдахгүй. Үгүй ээ, тэгэхээр чинь манай эдийн засаг яаж урагшлах юм бэ. Тэгээд энэ танхимыг яагаад төртэй харьцах энэ институц болгох гээд ингээд хуульчлаад ингээд явуулаад байна гэхээр жишээлбэл, энэ өнгөрсөн хугацаанд асар олон хувийн хэвшлийг барьж хорихыг нь хориод, тэр Хөгжлийн банкаар ингээд л харлуулахыг нь харлуулаад л байдаг. Хувийн хэвшлийг төлөөлж хэн дуугарсан юм бэ. Хэн ч дуугарахгүй л байна. Татварын асуудал дээр хувийн хэвшлийг төлөөлж хэн дуугарсан юм бэ. Хэн ч дуугарахгүй л байна. Энийг дуугаргадаг, платформыг нь бий болгодог гол нь хуулиар хүлээн зөвшөөрсөн институцийг бий болгох хэрэгтэй байгаа байхгүй юу. Тэр бол чөлөөтэй .../минут дуусав/

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 3 номер.

Л.Загдаа: Ажлын хэсгийн гишүүн, хуульч Загдаа. Жаргалан гишүүний асуултад хариулъя. Хуулийн төсөл дээр болохоор салбарын ангиллыг батлахдаа эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал буюу Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны даргын баталсан хамтарсан тушаал байгаа. Энэ хамтарч баталсан салбарын ангилалд нийцүүлж батална. Энийг Үндэсний танхимын удирдах зөвлөл батлахаар ингэж тусгаж өгсөн байгаа. Тэгэхээр өөрөөр хэлэх юм бол энэ салбарын ангилал батлагдсанаар одоо байгаа тэр ангилалд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагууд бол үйл ажиллагаагаа явуулаад, танхимтай хамтраад явуулах боломж нь нээлттэй. Шинээр 22 нь дотроо дахиад задрах боломжтой. Байгуулагдаж болно. Тэр нь Үндэсний танхимын удирдах зөвлөлийн бүрэн эрх байгаа.

Л.Соронзонболд: Жаргалан гишүүн тодруулж асууя.

Б.Жаргалан: Яах вэ, түрүүн Ганхуяг гишүүний хэлдэг хувийн хэвшлийг хэн хамгаалж дуугарсан юм бэ гэдэг дээр түрүүний миний Энхтүвшин гишүүн тавьсан шүүмжлэл бас хамаарч л байгаа. Тэгээд таны кноп олонхын бүлэг дээр тоологдоод л явж байгаа. Тэгэхээр хэдийгээр хувь хүний хувьд улс төрийн ашиг хонжоо хайгаагүй гэж байгаа боловч яг эрх баригч намд бол тийм боломж бол олгосон гэж бол хараад байгаа.

2 дугаарт бид нар институцлэх зорилгыг бол маш ихээр ярьдаг. Тэгээд Монголын Худалдаа, аж үйлдвэрийн танхим бол бас олон жил тогтсон, тогтночихсон бас өөрийн гэсэн соёлтой ийм байгууллага байгаад байгаа. Бас өөрийн гэсэн ийм юуг бий болгочихсон институцийг. Тэгээд яах вэ, энийг сайжруулах юм байгаа юу гэдэг дээр бол бүгдээрээ санал нэг байна. Гэтэл ингээд бүтцийг нь задлаад, нэгэн зэрэг 40, 50 юу гэдэг юм салбар танхим шинээр байгуулагдах, аймгийн танхимууд шинээр зохион байгуулагдах байдал бий болчих юм бол энэ 50-аас дээш компаниуд нэгтгэх тийм уралдаан гарчих вий гэж би бол хувьдаа болгоомжилж байна. Өөрөөр хэлбэл энэ дахин хуваарилалт хийнгүүт дор бүрнээ ингээд .../минут дуусав/

Л.Соронзонболд: Хууль санаачлагч Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Ингээд гишүүн болгон ЖДҮ ярьдаг. Гэтэл ЖДҮ гэдэг маань зүгээр л нэг сав руу асар олон төрлийн бизнесийг л хийчхэж байгаа байхгүй юу. Тэгэхээрээ тэр олон салбарууд бий болог. Тэр олон салбар танхим бий болж байж тэр ТҮЦ эрхлэгч байдаг юм уу, тэр 8 нэрийн барааны дэлгүүр байдаг юм уу, тэрний эрх ашгаа хамгаалж дуугардаг болохгүй бол энэ чинь өөрөө оновчгүй бүтэц болчихоод байна шүү дээ. Зүгээр 21 аймаг. 21 аймгийн бизнес эрхлэгчдийн зовлон яг адилхан биш байхгүй юу. Тэнд үйл ажиллагаа явуулж байгаа дэлгүүрийн эзэн ч байдаг юм уу, эсвэл уул уурхай эрхэлж байгаа хүний, эздийн зовлон өөр байхгүй юу. Тийм учраас энэ салбар танхимуудыг бий болгоно. Гэхдээ энэ чинь заавал хүчээр бий болгох гээгүй шүү дээ. Эвлэлдэн нэгдээд өөрснөө байгуулна гэвэл байгуулна. Байгуулахгүй гэвэл байгуулахгүй л байхгүй юу.

Л.Соронзонболд: Энхтүвшин гишүүн нэмж хариулъя.

Д.Энхтүвшин: Тэгээд энэ нөгөө хуулийн төсөлтэй холбогдуулж олонхын төлөөллөө авчихсан мэргэжлийн холбоодтой уулзсан байгаа. Тэгэхээр яг энэ дагуу бол бараг бид нар эхний 20-иод холбоотой уулзсан. Тэгэхээр энэ дагуу бол бараг эхний салбар танхимууд бараг 10-20 танхим бол шууд байгуулагдахаар, өөрөөр

хэлбэл бид нар бужигнуулахгүй, тэр түүхэн жамаараа бий болчихсон энэ төлөөллөө хангачихсан энэ бүтцүүдийг үймүүлэхгүй тэд нарын чиг үүргийг нь шилжүүлэх байдлаар гэрээ хийгээд, салбар танхимын чиг үүргийг нь тэр салбарт нь бид нар зэрэгцүүлж шинэ салбарын танхим байгуулахгүй байхаар ингэж ярилцсан. Тэрийг холбоод бас нэлээн нааштай хүлээж авахаар ярилцсан байгаа. Гэхдээ яах вэ энийг бол яг хэрэгжүүлэлтийн явцад бас одоогийн танхимын удирдлагууд бас яг яаж хэрэгжүүлэх вэ. Энэ чиг үүрэг бас бодлого хандлагууд бас үргэлжилж явах уу гэдгийг ажлын хэсэг дээр .../минут дуусав/

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 2 номер нэмж хариульъя.

М.Сарандаваа: Сайн байцгаана уу. Тэгээд гишүүддээ их баярлалаа. Маш их бүтээлч санал, санаачилга гаргаж асуулт, тодруулга авч байгаад. Тэгээд 43 саналыг бол маш ажил хэрэгчээр ингэж тусгаж авч байна. Та бүхний хэлж байгаа. Миний нэр Сарандаваа. Энэ МҮХАҮТ-д 10 жил удирдлагад нь ажиллаж байгаа ийм хүн байгаа юм. Тэгээд сая хэд хэдэн гишүүдийн асуулт болон тодруулга дээр дурдагдсан 1 зүйлийг хариулах ёстой болов уу гэж бодоод хариулж байна. Юу вэ гэхээр энэ хууль маань өөрөө 2 ч удаа өмнө хэлэлцэгдээд, унаж байсан ийм түүхтэй хууль. Тэгээд Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын удирдах зөвлөлөөс үүрэг болгосон 1 дүгээрт энэ хууль дээр танхимын саналыг жич боловсруулахыг, 2 дугаарт танхим дээр 115 санал ирсэн байгаа. Гишүүн байгууллагууд болон бидэнтэй хамтарч ажилладаг байгууллагуудаас. Тэгээд энэ 2 санал дээр үндэслээд өнөөдөр ярьж байгаа энэ өнгөрсөн оны 10 сард бид нар хууль санаачлагчид болон Улсын Их Хурал дахь намын бүлгүүдийн дарга нарт бол танхимын санал гээд саналыг бол хүргүүлсэн .../минут дуусав/

Л.Соронзонболд: Мандхай гишүүн асуулт асууя.

М.Мандхай: Яах вэ, Танхимын хууль дээр 1 зүйл дээр би жоохон шүүмжлэлтэй хандаад байдаг юм. Тэр нь юу гэхээр энэ топ 100-г шалгаруулж байгаа байдал дээр. Одоо бол энэ жагсаалтад байгаа хамаарал бүхий этгээд ер нь бол нэг группийн доторх компаниуд нэлээн орчихсон байгаад байдаг. Та бүхэн мэдэж байгаа MSC гээд л тэгэнгүүт MSC Кока Кола, Проперти, Юнител, Юнивишн Энержи ресорс гээд л Апу гээд л тэгэхээр Апу, Апу трейдинг гээд. Номин, Шунхлай гээд л тэгэнгүүт Шунхлай трейдинг, Шунхлай гээд л баахан компаниуд ингээд л харахаар ерөөсөө энэ топ 100 аж ахуйн нэгж дээр чинь ерөөсөө яг бие даасан бизнес гэхээсээ илүүтэйгээр нэг группээс юм уу олон охин болон харьяа компани орсон байдал бол нэлээд байдаг. Тийм болохоор ингээд шинээр төрж байгаа инновацийн ч гэдэг юм уу өөр ингээд бизнесүүд орох гэхээр аягүй хүндрэлтэй. Тэгэхээр эдийн засгийн яг энэ бодит төрөлжилтийг ер нь илүү энэ корпорацын бүлгүүдийн хэмжээгээр нь тэлсэн ийм дүр зураг бол нэлээн эрсдэлтэй харагддаг. Тэгэхээр танхимын энэ хууль дээр сайн дурын бизнесийн холбоо гэж үзэж байгаа юу. Эсвэл төрийн үйлчилгээ авах төрийн зарим чиг үүргийг тогтмол хэрэгжүүлдэг тийм нийтийн шинжтэй байгууллага гэж харж байгаа юу гэдэг 1 дүгээр асуулт байна.

2 дугаарт энэ танхим бүх аж ахуйн нэгжийн нийтлэг эрх ашгийг төлөөлнө гэж байгаа бол топ 100 зэрэг шалгаруулалт дээр салбарын тэнцвэр, тэр компанийн хэмжээ, бүс нутгийн төлөөллийг яаж хангах вэ.

3 дугаарт хуулийн төсөл салбарын танхимын тогтолцоог дэмжсэн мөртөө 50-аас доошгүй гишүүний босго тавьчихаж байгаа. Тэгэхээр энэ нөгөө зарим жижиг юм уу эсвэл чухал салбарыг төлөөлөлгүй үлдээх ийм эрсдэл бас байгаад байна гэж

харж байгаа. Тэгэхээр энэ үр нөлөөний үнэлгээндээ энэ босгыг хэрхэн нийцүүлэх вэ.

Танхимын хараат бус байдал зөвхөн улс төрийн намаас ангид байхаар тавьсан. Гэхдээ түрүүн хэлсэнчлэн томоохон групп компаниуд төвлөрсөн байдаг. Тэгэхээр энэ төр томоохон гишүүн, хандивлагч, 1 группийн нөлөөнөөс ангид байх тухай асуудлыг яаж зохицуулах юм бэ энэ хуулиараа. Энэ хуульдаа тодорхой тусах юм уу. Жишээлбэл, энэ Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал, Удирдах зөвлөлийн гишүүдийг ашиг сонирхлын мэдүүлэг, холбоотой этгээдийн ил тод байдлыг нь хууль дээр тусгах уу. Яг бодит байдал дээр бол би өөрөө ч гэсэн удирдах зөвлөлд сууж байсан хүний хувьд яг энэ Ерөнхийлөгчийг хэрхэн сонгох, удирдах зөвлөлийн сонголтыг бол үндсэндээ хараат байдлаар шийдчихдэг шүү дээ. Хэдхэн том групп компанийн захирлууд л өөр өөрсдийнхөө хүмүүсийг оруулаад л зааланд удирдаад л явчихдаг. Тэгэхээр энэ шинэчлэл яг хийгдэж байгаа юм уу гэдгийг асуумаар байна.

Хуулийн төсөлд энэ улс төрийн нөлөөг хориглосон ч гэсэн хэрэв зөрчигдвөл хариуцлагын механизм тодорхойгүй байгааг яаж засах юм бэ.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 3 номер. Ажлын хэсгийн 4 номер хариулъя.

Ц.Магнайбаатар: Топ 100 бол Худалдаа, аж үйлдвэрийн танхимын явуулдаг зүгээр нэг ийм үйлчилгээ, гишүүддээ үзүүлдэг л үйлчилгээ л дээ. Шалгаруулалт гээд топ 10, интрепренёр гээд 2 том шалгаруулалтын арга хэмжээг зохион байгуулдаг. Нэг нь эрэмбэлэх арга хэмжээ, нөгөөдөх нь интрепренёр гээд оны эцэст аж ахуй нэгжүүдийн өөрсдийнх нь хүсэлт шаардлага, тайлан дээр үндэслээд олгодог ийм 2 үйл ажиллагаа. Энийг бол хамтрагч байгууллагуудтай хамтраад цаашид сайжруулах бүрэн бололцоотой. Салбар чиглэлээр нь гаргах бол бололцоотой. Энэ дээр бол шалгаруулалтын үйл ажиллагааг яг хийхэд бас эдийн засгийн тоон үндэслэлүүд дээр сууриалаад ингээд хөдөлдөггүй тоонууд дээр хийгээд, сууриалаад ингээд эрэмбэлдэг учраас бусад нөлөөллийн үйл ажиллагаануудыг бас энэ дээр харгалзаж үзэж болдоггүй учраас юу яаж байгаа. Зүгээр түрүүн Энхтүвшин ерөнхийлөгчийн хэлснээр бол бид салбарлаж бас болно. Дээрээс нь энэ жилийн хувьд бол топ 500-г зарлана гэдэг төлөвлөгөөтэй байсан боловч энэ жилийн хувьд бол бид нар эхний 800 компанийн тоог татаж аваад, эхний топ 300 компанийг эрэмбэлээд зарлахаар бэлдэж ажиллаж байгаа. Эхний топ 100 болоод төрийн өмчийн 10 аж ахуйн нэгж гээд нийтдээ 110 аж ахуйн нэгжийг бид бүхэн эрэмбэлэхээр ингээд ажиллаж байна.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн ахлагч Энхтүвшин гишүүн хариулъя.

Д.Энхтүвшин: Мандхай гишүүний асуултад хариулъя. Мандхай гишүүний хөндөж байгаа асуулт маш зөв. Улс төрөөс гадна яг энэ том компаниудын ч юм уу энэ нөлөөнөөс хамааралтай болох эрсдэлүүд бас байгаа. Тэгэхээр үүнээс хамгаалахын тулд тодорхой хэмжээний заалтуудаа бас оруулсан байгаа. Жишээлбэл, салбарын танхимуудын удирдах зөвлөлийн гишүүдийн бүтцийг 1 эцсийн өмчлөгчтэй 5-аас дээш тооны этгээд байхыг хориглохоор ингээд заачихсан байгаа. Тэгэхээр энийг бас одоогийн танхим дээр хийлгэсэн судалгаагаар энэ 5 гэдгийг 2 болгож бууруулах санал юу орж ирсэн байна лээ. Тэгэхээр энийг бас ер нь дэмжээд, заавал энэ 5 биш ер нь буулгах бололцоотой гэж бодож байгаа. Ажлын хэсэг энэ хэлэлцүүлэг дэмжигдсэний дараа энэ өөрчлөлтийг оруулаад, 1 эцсийн өмчлөгчтэй компаниудын удирдах зөвлөлд нөлөөлөх нөлөөллийг энүүгээр бууруулах бололцоотой гэж бодож байгаа.

Нөгөө талаасаа .../минут дуусав/

Л.Соронзонболд: Хууль санаачлагч Ганхуяг гишүүн гүйцээж хариульъя.

Х.Ганхуяг: Энэ өргөн барьсан хууль бол шинэчилсэн найруулга байгаа. Тэгэхээр би бол энэ намын төлөөллүүдийг маш сайн оруулаад, заглаад, тэгээд энэ хуулиа хэлэлцүүлээд явбал зөв болов уу гэж харж байна. Тэгээд яагаад гэхээр шинэчилсэн найруулга болохоор та бүхэн маань энд танхимын өнөөдрийн байгаа статус, яагаад ийм үзэл баримтлалтай орж ирсэн гэдгийг бас ойлгох болов уу. Яах вэ, өнөөдөр бас хариулах гэж хичээлээ. Мэдээж хэрэг цаана нь зөндөө асуултууд үлдэж байгаа байх. Гэхдээ нөгөө хэлэлцэх эсэх явсны дараа ажлын хэсэг нь байгуулагдаад, ингээд гүйцээгээд сайн ажиллаасай гэж хүсэж байна.

Гэхдээ энэ бол 2 дахь удаагаа би өргөн барьж байгаа юм. Тэгээд өмнөх нь болохоор арай илүү монопол эрхтэй гэхдээ тэр нь болохоор бараг бүх нөгөө аж ахуйн нэгжүүдийг яг энэ танхимын гишүүн болгочихъё гээд. Тэгчих юм бол уг нь бид нар асар олон юунаасаа сална. Яг энэ танхим гэдэг үүргээ бас гүйцэтгэх чадвартай болох байсан юм. Гэхдээ одоо бол энэ бас яг тийшээ явж байгаа эхний алхам юм. Ингэж байж бид нар яг нөгөө бизнесийн төлөөний байгууллагатай болох, бизнесийн .../минут дуусав/

Л.Соронзонболд: Хариултыг гүйцээе. Ганхуяг гишүүний микрофоныг нээе.

Х.Ганхуяг: Бизнесийн нөгөө платформ өөрөө бий болох ийм боломжтой болох юм. Одоо ингээд өнөөдөр Татварын хуул бид нар хэдэн жил хэлэлцээд явж байна. Ноднин жилийн 1 сараас хойш Татварын хууль хэлэлцээд л явлаа, өнөөдөр дуусаагүй л явж байна. Зөвшөөрлийн хууль явж байна. Тэгэхээр нөгөө энэ танхим гэдэг энэ хүчтэй институт бий болохгүй бол манайх чинь яг бизнестэй холбоотой энэ хуулиуд чинь очоод дандаа хана мөргөчхөөд байгаа юм. Яг ингээд төрийн бус байгууллагыг нь дуудна, төлөөллийг нь дуудна. Жишээлбэл, би хэлээд байна шүү дээ. Аялал жуулчлалын компани дээр 1 компани 5-6 төрийн бус байгууллагатай байгаа байхгүй юу. Тэгээд ерөөсөө манай эдийн засаг өөрөө клиентилист болчихсон. Яагаад тэр олон төрийн бус байгууллага байгуулагддаг шалтгаан нь юу вэ гэхээр төрөөс тодорхой хэмжээний санхүүжилт авах зорилгоор ч байдаг юм уу эсвэл аль нэг салбарын хэлэлцүүлэг дээр очиж салбараа төлөөлж байгаа гэсэн байдлаар хувьдаа эрх ашгийг олж авах гэж тэгдэг юм уу, ингээд ерөөсөө бүх салбарууд гацчихсан байдалтай болчихсон. Яг ингээд л тэргүүлэх чиглэл гээд 180 тэргүүлэх чиглэл байна. Тэргүүлэх чиглэл .../минут дуусав/

Л.Соронзонболд: Мандхай гишүүн тодруулж асууя.

М.Мандхай: Тийм ээ. Шинэчилсэн найруулга учраас энд бас дутуу хөтүү өшөө сайжруулах шаардлагатай, ялангуяа засаглалын хувьд болон ер нь тэгээд энэ танхимын чинь үндсэн ер нь зорилго нь яг юу юм бэ. Энэ баахан холбоодыг бүтэцлэж ажиллах үндсэн зорилго юм уу. Эсвэл манай эдийн засгийг төрөлжүүлээд, экспортлогч орон болгоод, энэ байгаа аж ахуйн нэгжүүдийг дэмжээд явах зорилготой танхимын үндсэн зорилго юм уу гэдэг юмаа бас нэг ялгаж салгаж өшөө сайжруулахгүй юм бол одоо байгаа хуулийгаа л бүтэц, зохион байгуулалтад оруулаад нэгтгэж байгаа юм шиг тийм одоо юу гэдэг юм бэ дээ эдийн засгийг илүү нөгөө чанарыг нь харуулсан, солонгоруулсан, төрөлжүүлсэн ийм ач холбогдол бүхий хүчтэй ийм байгууллага болох гэдэг юм яг эндээс бол уншигдахгүй байгаад байгаа юм. Харамсалтай нь. Тийм учраас би хууль санаачлагчтай бол санал 1

байна. Өөрөө ч гэсэн санал 1 байх шиг байна. Ер нь бол өшөө ажлын хэсэг .../минут дуусав/

Л.Соронзонболд: Санал хэллээ. Гишүүд асуулт асууж дууслаа.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Мандхай гишүүнээр тасаллаа. Лувсанжамц гишүүн үг хэлнэ.

Г.Лувсанжамц: Гишүүддээ болон Худалдаа, аж үйлдвэрийн танхимыг төлөөлж ирсэн ажлын хэсгийн гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Ер нь бол тогтолцооны дизайныг л гаргах гэж байгаа хуулийн агуулга гэж бол харж байгаа. Тэгээд мэдээж санал зөрөлдөх зүйл заалтууд байна. Тодорхой заалтууд дээр тоог нь нэмж, хассан ч гэсэн тийм зүйлүүд байгаа учраас ажлын хэсэг дээрээ бүтээлч байдлаар саналаа оруулаад, хамтраад дундаа уулзацгаавал зүгээр юм болов уу гэж бодож байгаа. Тийм ээ. Тэгэхээр мэдээж ширүүн хэлэлцүүлгүүд бол байлгүй л яах вэ. Гэхдээ илүү хэлж байгаа саналаа зарчмын зөрүүтэй санал хэлбэрээр байгуулагдах ажлын хэсэг дээр нь ярилцаад явах нь зүйтэй болов уу. Тэгэхээр хэлэлцэх эсэхийг нь дэмжээд, ажлын хэсэг дээрээ нарийвчлаад аль аль намынх нь төлөөлөл нь оролцоод явсан нь зүйтэй гэж бодож байна.

ХАҮТ-д сая топ 100 ч юм уу, 300 ч юм уу, 500 гэсэн тоонууд хэлж байна. Энэ дээр үндсэн шалгуурууд нь болохлоор борлуулалтын орлого, төлсөн татварын дүн, даатгуулагчийн тоо, ашгийн хэмжээ, хөрөнгийн хэмжээ гээд нөгөө том байх тусмаа топ гэсэн хандлага хэвшмэл болчихоод байгаа гэдэг дээр хувьдаа жоохон шүүмжлэлтэй ханддаг. Тэгээд нэгэнт та хэд маань оюуны өмчийн бүртгэл гэсэн ийм асуудлууд дээр бас орж ирж байгаа учраас магадгүй уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортоор тэргүүлдэг компаниуд ч байдаг юм уу, гадаадаас валют оруулж ирж байгаа ч байдаг юм уу эсвэл оюуны өмчөөрөө олон улсад хүлээн зөвшөөрөгдөх хэмжээний стандартаар баталгаажсан буюу манай хөдөө аж ахуй ч байдаг юм уу, уламжлалт энэ техник технологийг хөгжүүлээд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ийм оюуны бүтээлч бүтээгдэхүүнүүдийг үнэлдэг аргачлал нь бас байвал зүгээр юм болов уу гэж боддог. Тэр дундаа бас магадгүй дижитал AI ч байдаг юм уу цахим салбар дээрээ ч гэсэн ийм зүйлүүд нь байвал хэрвээ энэ хууль батлагдах юм бол цахим салбарын танхим гэж бас байгуулагдаж магадгүй юм байна шүү дээ. Тэгэхээр энэ дээрээ ч гэсэн зөвхөн төрөөс үйл ажиллагаа эрхлээд аваад яваад гэдэг цахим компаниудыгаа шалгаруулдаг бус харин гадаад руу үйлчилгээ эрхлэх эсвэл гадаадад олон салбартай байдаг ч юм уу тийм компаниудыгаа аль болох зөвхөн дотооддоо харах гэхээсээ илүүтэйгээр гадагшийгаа харсан, гадагшийгаа өөрсдийгөө сорьсон тэгж сорьж амжилт гаргаж байгаагаа урамшуулж чаддаг тийм үнэлгээний бас үзүүлэлтүүд байвал зүгээр юм болов уу гэсэн саналтай байна.

Л.Соронзонболд: Очирбат гишүүн үг хэлье.

Г.Очирбат: Энэ яах вэ, тэгээд нөгөө хонины арьс нөмөрсөн чоно гэдэг шиг дандаа л нэг ийм юм яваад байгаа юм. Тодорхой хуулийнх нь зүйл заалттай нь хэлж өгөөд байна шүү дээ. Энэ хуулийн төслийнхөө 6.3-ыг та нар маань оруулж ирэх шаардлага ч үгүй байсан шүү дээ. Тэгээд энийгээ л больчих л доо. Яагаад энэ 6.3 байгаад байгаа юм. 6.3 дээр чинь Засгийн газрын тухай хуулийн 19.1, 2 ороод ирж байгаа байхгүй юу. 19.1 дээр яана гээч Засгийн газар шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох

зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно гээд заачхаад байгаа байхгүй юу Засгийн газрын тухай хууль дээр чинь. Тэгээд энийгээ л больчих л доо. Мөнгө хаана байгаа юм. Тэнд л шийдвэр гараад байна шүү дээ. Өнөөдөр манай танхимынхан, аж ахуйн нэгжүүд дуу хоолойгоо нийлүүлээд юм хийе гэхээр дээд суугаа удирдлагууд нь баахан гэрээ хийж хэдэн төгрөг авчхаад доошийгоо ажлаа явуулахгүй дардаг шүү дээ. Үгүй ээ, чөлөөтэйгөөр тэр төрөөс хамааралгүй болгоод, мөнгөнөөс нь хамааралгүй болгоод өөрсдөө хоорондоо мэтгэлцээд, муудалцаад, юмаа гаргаад ир л дээ. Тэгээд нэгдэж нийлээд, дуу хоолойгоо төрдөө илэрхийлнэ биз дээ. Энэ чинь л ардчиллын зарчим шүү дээ. Тэгэхгүй заавал татвар төлөгч нарын мөнгийг ингэж оруулж ирчхээд маргаан үүсгээд байгаа Энхтүвшин та нар хууль санаачилж байгаа юм бол асуултдаа л хариулчих л даа. Тэгээд хамгийн сүүлийн энэ Хассуурийн Ганхуяг гишүүний үг зөв л байна шүү дээ. 1 бол энэ чинь болохгүй байвал энэ чинь шинэчилсэн найруулга юм чинь ажлын хэсгээ гаргаад, цаашаа яваад сайжруулаад л явъя. Тэгэхгүй тэгээд энэ хооронд чинь заавал илүү дутуу юм юу ч яриагүй, улс төржөөгүй. Яг энэ хуулийн төслийн чинь зүйл, заалттай би гуравхан л асуулт асууж байна шүү дээ. Тэгээд энэ дээр л хариулаад өгчих. Тэгээд л болоо шүү дээ.

Ер нь хардаа, Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль дээр энэ орж ирж байсан. Энэ дээр энэ орж ирж байгаа юм. Танхимын тухай хууль. Дахиад нөгөө Мэргэжлийн холбоодын эрх зүйн байдлын тухай хууль дээр бас байгаа. Ингээд олон хуулиуд дээр байгаа. Тэр яаж байна гэхээр төр өөрөө төрийн бус байгууллагыг гаргаж ирээд, тэд нарт гэрээ хийгээд мөнгө өгөөд, мөнгө өгснийхөө ард дээр шийдвэрээ гаргуулдаг. Тэгэхээр тэр эвлэлдэн нэгдсэн байгаа тэр төрийн бус байгууллагууд мэргэжлийн холбоод чинь дуу хоолойгоо хаана илэрхийлэх юм. Хэдэн дарга нар нь нийлээд хэдэн гэрээ хийгээд хэдэн цаас авчихдаг. Тэгээд мөнгөнд л дарагдаж байгаа шүү дээ. Хэдүүлээ ингээд үнэтэйгээ нүүр тулья л даа. Ялангуяа энэ хуулийн төслүүд орж ирж байхад энэ төрөөс ингээд мөнгийг нь салгая л даа. Энэ ямар ч байсан мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагуудаас төрийн мөнгийг салгаж байж яаж явна шүү дээ. Тийм байна. Ерөнхийдөө энэ хуулийн төсөл анх орж ирж байхад нь ч энэ нэлээн мэтгэлцээн болсон гэсэн. Хэн гэдэг 2 хүний лоббигоор энэ 6.3 орж ирсэн гэдгийг ч бас би мэдэж байгаа шүү. Тэр нь цаашдаа зарлаад явна. Тэгээд юм хэлэхээр хуулийн төсөл санаачлагч юм бол сайхан хүлээж аваад, энэ нь болж байна, энэ нь болохгүй байна гээд эцсийн дүндээ энэ хууль чинь манай танхимынханд хэрэгжээд, аж ахуйн нэгжүүд маань өнгөтэй өөдтэй байгаад, ард иргэд маань орлоготой, мөнгөтэй болоосой л гэж л бодож байгаа биз дээ бид нар бүгдээрээ. Тэгээд л аль болох л энд тэндээс нь болох бүтэхгүй юмыг нь шүүгээд л сууж байгаа шүү дээ.

Л.Соронзонболд: Баярлалаа. Жаргалан гишүүн үг хэлье.

Б.Жаргалан: Бид бол ардчилсан нийгэмд амьдарч байгаа. Тэгээд аливаа салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа, эсвэл ер нь хүн болгон л өөрийнхөө ашиг сонирхол, эрх ашгийг хамгаалахын тулд ямар нэгэн байдлаар эвлэлдэн нэгдээд тэр эрх ашгаа хамгаалах нь бол нээлттэй ийм улс оронд амьдарч байгаа гэж ойлгоод байгаа. Тэгэхээр тэр утгаараа МҮХАҮТ бол 1995 онд энэ анхных нь хууль нь тухайн үеийн ардчилсан Үндсэн хуульд нийцүүлж батлагдаад, тэгээд түүнээс хойш өнөөдрийн байдлаар ийм 6768 татвар төлөгч аж ахуйн нэгжүүдийг нэгтгээд ингээд явж байгаа ийм байгууллагын хувь заяаны асуудлыг бид нар ярьж байгаа.

Улсын Их Хурал дээр хэлэлцэгдэж байгаа дийлэнх хуулиуд, дээрээс нь нэн ялангуяа манай Эдийн засгийн байнгын хороогоор орж байгаа дийлэнх хуулиуд бол

танхим дээр очиж хэлэлцэгддэг. Тэндээс бас санал, дүгнэлтүүдийг нь авда. Аж ахуйн нэгжийн дуу хоолой танхимаас гардаг гэсэн ийм ойлголттой явдаг. Тэгэхээр тэр утгаараа энэ танхимын эрх зүйн байдал ер нь цаашдын хувь заяа бол маш чухал.

Тэгээд би юунд санаа зовоод байна вэ гэхээр нөгөө нуухыг нь авах гэж байгаад нүдийг нь сохлов гэгчээр энэ 6768 одоо байгаа тэр аж ахуйн нэгжүүдийнхээ эрх ашгийг бүр их хөсөр хаяад гэдэг юм уу, өнгөрсөн хугацаанд бий болгосон тэр байгууллагын соёл, тэр институтийнхээ хэв шинжийг бүүр алдуулчих вий гэсэн тийм санаа зовнил бол яах аргагүй байна. Тэгээд жишээлбэл мэргэжлийн салбарын холбоод, салбарын танхимууд гээд байгаа юм. Тэр салбарын танхимууд гэдэг зүйлүүд бий болчхонгуут бусад жишээлэх юм бол нөгөө байдлаар зохион байгуулагдаж байсан тэр салбар болгондоо өөр өөрсдийнхөө салбарын онцлогт тааруулаад эвлэлдэн нэгдээд бий болгож байсан тэр байгууллагуудыг бүр хүчээр энэ танхим гэдэг юм руу түлхээд гэх мэтчилэн ийм санаа зовнилууд бол байна. Тэр дээр бол би өнөөдөр тийм үндэслэлтэй хариултуудыг аль аль талаас нь сонссонгүй. Тэр битгий хэл одоо байгаа танхимын удирдлага тэр 6768 компаниас юу бодож байгаа тал дээр үндэслэлтэй яг тийм аргумент огт сонссонгүй. Тэгэхээр маш ийм болгоомжтой хандах ёстой асуудал гэж бодож байна. Ер нь бол ингээд хуулийг нь засаад гоё болчихдог зүйл ч гэж ер нь бол өнгөрсөн хугацаанд байсангүй шүү дээ. Бид нар ерөөсөө байгаа юмыгаа улам дордуулаад байгаа л дүр зураг ажиглагдаад байна. Тэгэхээр бол маш болгоомжтой хандах ёстой гэж харж байгаа. Тэгэхээр би бол хувьдаа бол энэ хуулийг дэмжих үндэслэл бүхий үндэслэл бол ерөөсөө олж харсангүй. Тэгээд бараг л тэр байгаа хуучин 1995 оны хууль чинь маш ойлгомжтой, тодорхой, илүү дутуу зүйл, заалт байхгүй ийм хууль харагдаж байна шүү дээ. Тэгэхээр бүр ингээд нэг байгаа зүйлийг олон давхар бүтэц зохион байгуулалт руу нь ороод л бүр тэр дүрмийнх нь зүйл заалт руу нь ороод, Ерөнхийлөгчийнх нь эрх үүргийг нь хүртэл хуулиар томьёолоод байх шаардлага байсан юм уу, үгүй юм уу. Ер нь бол ойлгохгүй л байгаад байна. Тэгэхээр би бол хувьдаа энэ хуулийг яг энэ байдлаар нь дэмжихэд бол бэрх байна л гэж харагдаж байна.

Тэгээд дээрээс нь хууль санаачлагч нарт бас хэлэхэд яг энэ нөгөө салбарынхаа хүмүүсээр хэлэлцүүлсэн, тэгээд энэ компаниудын төлөөллийн санал бодлогууд, тэр бүх зүйлүүдээ та хэд ерөөсөө гаргаж ирсэнгүй. Тэгээд 1 төртэй л харилцах юм яриад байна. Ер нь бараг төрийн өнцгөөс харахад бүх зүйлүүд нь юу гэдэг юм ингээд компаниуд нь овоороод нэгдсэн 1 байгууллага болоод ороод ирчихвэл бид нарт амар байна гэж ярих гээд байна шүү дээ. Гэтэл бид нарын хүсэж байгаа зүйл чинь тэс хөндлөн шүү дээ. Тийм биз дээ. Тэр компаниуд чинь өөрсдийнхөө олон янз байдлаараа эвлэлдэн нэгдээд, өөр өөрсдийнхөө эрх ашгийг тухай бүрдээ төлөөлөөд явах ёстой шүү дээ. Түүнээс биш Ганхуяг гишүүний яриад байгаа шиг ингээд төр харьцах гээд байнгуут 30 байгууллага нэгэн зэрэг гарч ирээд байна. 1 л болчихмоор байна гэсэн зүйл чинь бол мэдэхгүй тэр ардчиллынхаа үнэт зүйлийнхээ өнцгөөс бол надад бол бүр ойлгомжгүй санагдаж байна. Тэгэхээр бол би бол хувьдаа бол энэ хуулийг бол дэмжихгүй .../минут дуусав/

Л.Соронзонболд: Мандхай гишүүн үг хэлье.

М.Мандхай: Танхимын хуулийг нэгэнтээ шинэчилсэн найруулга хийж байгаа учраас дахиад би хэлэхэд бол танхим ер нь ямар байх ёстой юм бэ. Яг бизнесүүдэд яг ямар ач холбогдолтой юм бэ гэдэг асуултад өөрөө хариулагддаг байх ёстой болов уу. Мэдээж энэ өөрөө ингээд гишүүнчлэлийн хураамж өгөөд, тэгээд зардал биш өөрөө энэ давуу тал нь яг юу юм. Төрд яг бодитой нөлөөлөх чадамж нь юу юм.

Жишээлбэл, татвар хөнгөлөлтийн асуудал дээр яаж нөлөөлөх юм. Лиценз, экспортод яг давуу байдал яаж үүсэх юм. Хөдөлмөрийн тухай хуулиуд дээр жишээлбэл энэ танхим яаж ажиллах юм. Зах зээлийг нээж өгөх дээр. Тэгээд л гадаадын зах зээл нийлүүлэлтийн сүлжээг яаж тэлж өгөх юм. Vtb бизнесүүдийг яаж нэмэгдүүлэх юм. Энэ өөрөө эрсдэлээс яг хамгаалж чадах юм уу. Бизнесүүдийн дата мэдээлэл дээр ямар давуу байдал үүсгэх юм. Чадавхжуулах тэр талант нэтворкуудыг яаж хийх юм бэ. Жижиг бизнесүүдийг энэ хамгаалж өгч чадах юм уу. Ялангуяа энэ орон нутагт байгаа жижиг бизнесүүдийг яаж энэ дээр төвлөрүүлж хамгаалах юм. Эсвэл энэ том бизнесүүдийн төвлөрсөн ийм клуб маягийн юм болох гээд байгаа юм уу. Дахиад л хэлсэн түрүүний топ 100 аж ахуйн нэгжүүдийг харах юм бол яг л төвлөрсөн хэдхэн компани, групп компаниудын нөлөөлөл байна. Тэгээд энэ нөлөөллийг яаж хязгаарлах юм. Танхимын шийдвэр гаргалт өөрөө бизнесүүдэд ямар өгөөж авчрах юм бэ гэдэг ийм чухал суурь асуултуудад өөрөө энэ хууль хариулагдах ёстой байх. Тэгж байж энэ хууль, эрх зүйн орчин тодорхой болж байж энэ танхимд нэгдэх сонирхолтой холбоод нь ч бий болно. Гишүүнчлэлүүд ч гэсэн нэмэгдэх болов уу гэж харж байгаа учраас энэ хуулийг өшөө сайн амин сүнс дээр нь өшөө суух хэрэгтэй юм байна гэдэг байр суурьтай байна.

Л.Соронзонболд: Гишүүд үг хэлж дууслаа. Ажлын хэсгийнхэн гарч байж болно. 3 гишүүн хажууд Байнгын хорооны санал хураалт явж байгаа учраас түр хүлээгээч гэсэн. Түр хүлээж байя.

Гишүүд санал хураалтдаа бэлдье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг үндэслэн хуулийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна.

1.Худалдаа, аж үйлдвэрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 47,6 хувиар санал дэмжигдсэнгүй.

2. Хамт өргөн мэдүүлсэн, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 42,9 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

3.Хамт өргөн мэдүүлсэн, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 42,9 хувийн саналаар тухайн саналыг хэлэлцэхийг дэмжсэнгүй.

4.Хамт өргөн мэдүүлсэн, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 42,9 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

5.Хамт өргөн мэдүүлсэн, Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 38,1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

6.Хамт өргөн мэдүүлсэн, Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 38,1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

7.Хамт өргөн мэдүүлсэн, Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал дэмжигдсэнгүй. 33,3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

8.Хамт өргөн мэдүүлсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 33,3 хувийн саналаар энэхүү санал дэмжигдсэнгүй.

9.Хамт өргөн мэдүүлсэн, Чөлөөт бүсийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 23,8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

10.Хамт өргөн мэдүүлсэн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 38,1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

11.Хамт өргөн мэдүүлсэн, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 38,1 хувийн саналаар энэхүү санал дэмжигдсэнгүй.

12.Хамт өргөн мэдүүлсэн, Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 38,1 хувийн саналаар энэхүү санал дэмжигдсэнгүй.

13.Хамт өргөн мэдүүлсэн, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 33,3 хувийн саналаар энэхүү санал дэмжигдсэнгүй.

Санал хураалт явуулж дууслаа.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль шинэчилсэн найруулгын хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг танилцуулна. Хуулийн төслүүдийг хэлэлцэж дууслаа.

17.34 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн талаарх хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүн танилцуулна. Гишүүний микрофоныг нээнэ үү.

С.Цэнгүүн: Эдийн засгийн байнгын хорооны гишүүддээ энэ оройн мэндийг хүргэе.

БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн танилцуулгыг та бүхэнд хүргэе.

Хуулийн төслийн зорилго:

1991 онд батлагдсан БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болсонд тооцож, зах зээлийн эдийн засгийн тогтолцоо, Монгол Улсын үндсэн хуулийн зарчим, Иргэний хууль, Компанийн тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудтай нийцсэн эрх зүйн орчныг бүрдүүлэхэд энэхүү хуулийн төслийн зорилго оршино.

Тус хуулийн төсөл нь төрийн өмчит компанийн засаглалд захиргааны шууд хяналт тогтоох, өмнөх нийгмийн зохицуулалтыг халж, компанийн дотоод хяналт, хариуцлага, хувьцаа эзэмшигчдийн хяналтыг ил тод байдал, хязгаарлагдмал механизмаар орлуулах эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэж байна.

Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлага:

1991 онд батлагдсан хууль нь Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн харилцаанд шилжиж байсан түр шилжилтийн үед эдийн засгийн хямралыг даван туулах, стратегийн үйлдвэр байгууллагын үйл ажиллагааг зогсолтгүй үргэлжлүүлэх зорилгоор гарсан онцгой арга хэмжээний шинжтэй зохицуулалт байсан юм. Гэвч энэхүү хууль өнөөдрийг хүртэл хүчингүй болгоогүй хэвээр байгаа нь эрх зүйн орчны зөрчил, давхардлыг бий болгож, төрийн байгууллагын оролцоог албадлагын замаар хэт төвлөрүүлэх, компанийн засаглалын хараат бус байдалд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдлыг бүрдүүлж байна. 2019 оноос хойш тус хуулийг үндэслэн Эрдэнэт үйлдвэр, Монросцветмет, Эрдэнэс Тавантолгой ХК зэрэг хэд хэдэн томоохон компанид онцгой дэглэм тогтоож, Засгийн газраас бүрэн эрхт төлөөлөгч томилсон. Энэ нь эдгээр компанийн удирдлагын бүтэц, ТУЗ-ийн үйл ажиллагаа, гүйцэтгэх удирдлагын шийдвэр гаргах эрхэнд шууд хяналт тогтоох замаар компанийн бие даасан байдлыг хязгаарлаж, улс төрийн оролцоо, ашиг сонирхлын зөрчлийг нэмэгдүүлэх эрсдэл дагуулсан байна. Үүнтэй зэрэгцэн төрийн өмчит компаниудын зарим нь ашигт ажиллагаа нь түр зуурын өсөлт үзүүлсэн боловч энэ нь зах зээлийн механизм бус төрийн шууд оролцоотой захиргааны удирдлагын нөлөөлөлтэй холбоотой болохыг судалгаанууд харуулж байна.

Иймээс энэхүү хуулийн хэрэгцээ нь өнөөгийн эдийн засгийн бодит нөхцөлд нийцэхгүй болсон нь харагдаж байна. Хуулийн төслийн гол агуулга нь 1991 оны БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох онцгой дэглэмийн хүрээнд эдийн засгийн хариу арга хэмжээг авах асуудлыг онцгой

байдлын тухай хуульд тусгах, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалд удирдлагын хариуцлагыг дотоод хяналтын тогтолцоо, ТУЗ-ийн хараат бус байдлаар хангах боломжийг бүрдүүлэх, төрийн өмчит компанид хяналт хэрэгжүүлэхдээ Компанийн тухай хуульд заасан хувьцаа эзэмшигчдийн эрх, ТУЗ-ийн бүрэн эрхийн хүрээнд ажиллах зарчмыг баталгаажуулах.

Энэхүү хуулийн төслийг баталгаажсанаас гарах эрх зүйн болон эдийн засгийн үр нөлөө:

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар хууль зүйн орчны давхардал, зөрчил арилж, төрийн оролцоо хуульд заасан хүрээгээр хязгаарлагдана. Төрийн өмчит компанийн засаглал ил тод, хариуцлагатай болж, улс төрийн нөлөө, авлига, ашиг сонирхлын эрсдэл буурах нөхцөл бүрдэнэ. Төрийн болон орон нутгийн өмчит компаниуд зах зээлийн зарчмаар бие даан үйл ажиллагаа явуулах, ашгийн төлөө үр ашигтай менежмент хэрэгжүүлэх чадамж нэмэгдэх бөгөөд компанийн гүйцэтгэл, үр ашиг илүү тогтвортой хэмжээнд хүрэх боломжтой болно.

Зардлын тооцоог Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу хийсэн бөгөөд энэ хууль батлагдсанаар төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэдэд материаллаг болон материаллаг бус зардал гарахгүй.

Нийгэм, эдийн засгийн түвшинд хүлээгдэж буй үр дүн:

Төрийн өмчит компанийн хариуцлага, хяналт сайжирна. Ингэснээр ил тод төрийн хязгаарлагдмал хяналтын тогтолцоо төлөвшиж, улс төрийн оролцоо буурна. Зах зээлийн зарчим бэхэжнэ. Компанийн удирдлага санхүүгийн шийдвэр зах зээлийн нөхцөлд тулгуурлах тул үр ашиг өрсөлдөх чадвар нэмэгдэнэ. Авлига, ашиг сонирхлын эрсдэл буурна. Төрийн орон нутгийн өмчит компаниуд улс төрийн бүлэглэл албан тушаалтны ашиг сонирхлын нөлөөллөөс ангид ажиллах боломж бүрдэнэ. Мөн иргэдийн итгэл, төрийн нэр хүнд нэмэгдэнэ. Төрийн өмчийг ашиглах үйл явц ил тод болж, нийгэмд итгэлцэл, хариуцлагын соёл төлөвшинө. Хууль дээдлэх зарчим баталгаажна. Төрийн байгууллагын бүрэн эрхт хуульд заасан хязгаар баригдаж, хууль зүйн нэгдмэл тогтолцоо бий болно. Хуулийн төслийн тогтоох үйл хэрэгт олон нийтийн санал бодлыг тусгах, иргэдийн эрх ашигт нийцсэн бодлого шийдвэрийг гаргах, тэдний дуу хоолойг хүргэх, ард олны засаглах эрхийг хангах зорилготой Улсын Их Хурлын Тамгын газрын D-Parliament.mn сайтад хуульд заасан хугацаанд байршуулсан бөгөөд иргэдээс цахим хэлбэрээр санал ирээгүй болно. Харин зарим төрийн өмчит үйлдвэрийн газар болон хуульч, судлаачдын дунд зохион байгуулсан нээлттэй хэлэлцүүлэгт оролцогчид салбарын мэргэжлийн холбооноос албан бичгээр ирүүлсэн саналуудыг үндэслэн төсөлд зарим өөрчлөлтийг оруулсан болно.

Ингээд Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүд энэхүү хуулийг хэлэлцэх эсэхийг дэмжиж өгнө үү хэмээн хүсье.

Л.Соронзонболд: Цэнгүүн гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулья.

Уянга “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Хууль, эрх зүйн газрын дарга, Сундуй “Төв тусгал” сургалт судалгааны төвийн судлаач байгаа юм уу. Дамбаасүрэн Өмгөөллийн “Грандлекс партнерс” компанийн өмгөөлөгч, Болд-Эрдэнэ Монголын хуульчдын холбооны удирдах зөвлөлийн гишүүн, өмгөөлөгч, Мөнхбат Монголын хуульчдын холбооны гишүүн хуульч, Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн,

өмгөөлөгч, өмгөөллийн “Миранда Партнерс” Хуулийн фирмийн үүсгэн байгуулагч, Дарханбаатар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Удирдлага төлөөллийн албаны дарга, Цэрэнбадам “Бороогоулд” компанийн гүйцэтгэх захирал.

Хуулийн төслийн талаар хууль санаачлагчаас асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Жаргалан гишүүнээр тасаллаа. Лувсанжамц гишүүн асуулт асууна.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе. Хуулийн үзэл баримтлалыг бол дэмжиж байгаа. Гэхдээ агуулга дээр нь хэдэн асуулт байгаа учраас тодруулмаар байна. 2019 оноос хойш нийтдээ 6 төрийн өмчит компани дээр БЭТ томилоод, үйл ажиллагаанд нь Засгийн газраас чиг үүргүүдийг өгөөд оролцоод явсан байна гэсэн агуулга туссан байна.

Тэгээд эндээс харахад жишээлбэл, Эрдэнэс Тавантолгой компани 2022 оны экспортын хэмжээ нь 11,5 сая байсан нь 2023 онд 32,8 сая тонн, 2023 оны эхний 7 сарын байдлаар 14,4 сая тонн гээд борлуулалт нь 1,4 тэрбум ам.долларт хүрсэн нь 2022 оны бүтэн жилийн борлуулалттай харьцуулахад 150-аар өссөн үзүүлэлттэй.

Эрдэнэт үйлдвэр дээр 2018 онд онцгой байдал тогтоосноор 1,4 дахин улсын төсөвт төвлөрүүлсэн орлого нь ихэссэн байна гэж байна. Эсрэгээрээ буурсан дээр нь болохоор Монголросцветмет дээр 36 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлдэг байсан бол 33,7 тэрбум буюу ойролцоогоор 10 орчим хувиар буурсан байна. Бусад 3 аж ахуйн нэгж дээр төрийн өмчит компани дээр ямар үр дүнгүүд гарсан юм бол. Яг энэ авсан 3 жишээгээр харах юм бол бүрэн эрхт төлөөлөгч томилсноороо энэ байгууллагуудын үйл ажиллагаа нь сайжирсан харагдаж байна. Тэгээд олон улсын судалгаа, эрх зүйн орчин ямар байгаагаа харахад бол бүх улсад бас энэ арга хэмжээг хэрэгжүүлдэг юм байна. Шаардлагатай тохиолдолд хувийн хэвшил дээр ч гэсэн зарим улсууд дээр хийж байна. Гэхдээ хувьдаа бол хувийн хэвшил дээр БЭТ томилох нь бол зохисгүй гэж бодож байгаа.

Онцгой байдлын тухай хууль дээр энэ дээр өөрчлөлт оруулаад явахаар яг ийм байгаа нөхцөл байдлууд маань жишээлбэл хөрөнгийн өгөөж, төвлөрүүлж байгаа татвар, улсын төсөвт төвлөрүүлж байгаа орлогын хэмжээ нь бага байх юм бол Засгийн газар ямар арга хэмжээ авч ажиллах боломжтой байдаг юм бол. Энэ бололцоо нь хаагдчихгүй юу гэсэн 3 асуулт байна.

Л.Соронзонболд: Хууль санаачлагч Цэнгүүн гишүүн хариулъя.

С.Цэнгүүн: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийн үндсэн үзэл санаа нь өөрөө 1991 онд батлагдаж гарсан. Тухайн үедээ шилжилтийн үеийн процессыг зохицуулахаар түр ашиглахаар батлагдаж байсан хууль байгаа. Энэ хугацаанаас хойш 1992 онд манай Монгол Улсын Үндсэн хууль батлагдсанаар БНМАУ-ын Засгийн газрын үед ашиглаж байсан хуулиудыг хүчингүй болгоно гэж заасан. Тэр утгаараа энэ хууль маань бол аль уже хүчингүй болчихсон байх ёстой байсан. Гэтэл 2019 оноос хойш Эрдэнэт үйлдвэр дээр та бүхний мэдэж байгаагаар онц байдал зарлаж, БЭТ бол томилсон байгаа. Тэгэхээр эндээс бас санхүүгийн үзүүлэлтүүдээс нь харагдахаар мэдээжийн хэрэг Эрдэнэс Тавантолгой болон Эрдэнэт үйлдвэрүүд дээр 2019 оноос хойш бол орлого болон борлуулалтын тоо хэмжээ нэмэгдсэн харагддаг боловч нөгөө талдаа болохоороо тэр нь БЭТ томилсонтой шууд холбоотой бишээр эдийн засгийн түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнийн өсөлт нь өөрөө нөлөөлөөд явчихсан байгаа

гэдэг нь бол тоон дээрээсээ харагдаж байгаа. Мөн түүнчлэн Эрдэнэс Тавантолгой компани дээр байсан зарлагыг хараад үзэх юм бол 2019 онд 1,2 тэр их наяд байсан бол 2024 онд 4,5 их наяд болж мөн 3,4 их наядар буюу хийсэн ашигтайгаа яг адилхнаар зардал нь бас нэмэгдээд явчихсан байж байгаа юм. Тэгэхээр үр өгөөж болон бүтээмжийг нь бид бүхэн харьцуулаад харахаар бас нөхцөл байдал өөрөөр харагдана.

Дээрээс нь бас энэ хуультай холбоотойгоор үүсээд байгаа асуудал нь бол энэ төрийн өмчит компаниуд маань ялангуяа Эрдэнэс Тавантолгой, Эрдэнэт үйлдвэрүүд дээр санхүүгийн тайлан өөрөө нээлттэй биш байгаад байгаа юм. Тийм утгаараа бид бүхэн маань бол нээлттэй хэлэлцүүлгээр яг энд бүтээмж хэд байгаад байгаа юм бэ. БЭТ-ийн гаргасан шийдвэрүүд нь үр нөлөө сайн байсан уу, үгүй байсан уу гэдэг дээр нь дэлгэрэнгүй судалгаа хийж болохгүй байгаа учраас төрийн өмчит компаниуд дээр бас хяналтын сонсгол бид нар хийх зайлшгүй шаардлагатай байгаа юм гэдэг нь бас энэ хуультай хамт ер нь дараагийн шатад бид нар харах ёстой зүйл гэж харагдаж байгаа юм.

Олон улсын нөхцөл байдал дээр бол ер нь энэ бүрэн эрхт төлөөлөгч томилоод байгаа шаардлага нь онцгой байдал үүссэн буюу дайн байлдааны нөхцөл байдалтай, хүнсний хангамж тасарсан эсвэл цаг агаарын нөхцөл байдал хүндэрсний улмаас иргэдэд хүнсний хангамж очиж чадахгүй байгаа гэх мэт хүндрэлтэй нөхцөл байдлууд дээр Улсын Их Хурлуудаас парламент дээр нь бүрэн эрхт төлөөлөгчдийг томилох шийдвэрүүдийг тухай бүрд нь бол гаргаад явах эрх нь бол байдаг.

Манай улсын хувьд бол энэ БНМАУ-ын тухай хуулиас гадна 1995 онд Онц байдлын тухай хуулийг баталсан байдаг. Тэр Онц байдлын тухай хууль дээр бол өнөөдрийн бид нарын хэлэлцэж байгаа энэ хуулийн агуулгуудыг нь ерөнхийд нь бол шингээгээд өгсөн. Зарим зүйл, заалтууд дээр нь цаг үетэй холбоотойгоор илүү тодруулж орохыг нь өнөөдөр бид нар хууль дээрээ бас дагалдах хуулиар оруулж өгсөн байгаа юм.

Л.Соронзонболд: Лувсанжамц гишүүн тодруулж асууя.

Г.Лувсанжамц: Баярлалаа. Энэ 3 төрийн өмчит компани дээр дурдаад Тавантолгой, Тавантолгой төмөр зам, ДЦС 3 дээр бол ямар нэгэн дүгнэлт гаргах боломжгүй байсан гэж ойлгож байна зөв үү. Тэгээд 2 дахь буюу зөвхөн энэ онцгой байдлын хуулиараа явах юм бол хэрвээ төрийн өмчит компани нь өөрөө менежмент нь муу байх юм бол тодорхой хэмжээгээр төрөөс оролцох ёстой гэж бодож байгаа. Энэ оролцоо нь хаагдчихгүй юу гэсэн энэ 2 асуулт.

Л.Соронзонболд: Хууль санаачлагч Цэнгүүн гишүүний микрофоныг нээе.

С.Цэнгүүн: Төрийн өмчит компанийн үндсэндээ удирдлагыг томилж байгаа этгээд нь өөрөө төр байж байгаа. Тэгэхээр төрийн өмчит компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн нь бол угаасаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон ихэнх тохиолдолд бол тухайн салбарын яамд оролцоод тухайн ТУЗ-ийн гишүүдийг томилдог. Тухайн ТУЗ-үүд нь өөрсдөө бас хуралдаанаараа гүйцэтгэх захирлаа томилж байгаа юм. Тэр агуулгаараа төр өөрийнхөө томилсон этгээд, хүмүүст хариуцлага тооцож чадахгүй байгаа нь манай төр өөрөө чадамжгүй болсны бас нэг том илрэл байгаад байгаа юм.

Дээрээс нь энэ хууль дээр бас нэг байгаа аюултай зүйл нь болохоороо ганцхан төрийн өмчит компаниудын тухай бид нар яриагүй. Энэ нь болохоороо үйлдвэрийн газар болон байгууламжийг давхар оруулсан байгаа. Хуулийн нэршил дээрээ хараад үзэх юм бол энэ нь ХХК болон ХК, сан, ТББ гэх мэт бүх төрлийн ерөнхийдөө байгууллагууд дээр оруулах буюу хувийн өмчид халдах үндсэн маш том ноцтой зөрчил энэ хуулиар бол олгогдчихоод байгаа гэдэг нь байгаа.

Л.Соронзонболд: Яах вэ, ер нь төрийн өмчийн 2, 3 компани дээр ямар дүгнэлт байсан юм бэ л гэж асуусан шүү дээ. Тэр дээр нь хэн хариулах юм. Ажлын хэсгээс 5 номер хариулъя.

Ц.Мөнхбат: Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамцын асуусан асуултад хариулъя. Рой аргачлал болон хэд хэдэн зүйлийг анхаарах ёстой. Энэ хуулийн хамгийн гол асуудал нь бол эрх зүйн онцгой дэглэм бий болгож байгаа. Өөрөөр хэлбэл энэ эрх зүйн онцгой дэглэм нь Монгол Улсын нийтлэг хууль тогтоомж, олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг бусад энэ хууль тогтоомжийг огт хэрэглэхгүй ийм зохицуулалтад байгаа. Тэгэхээр яах вэ, энэ яг 3 компани дээр БЭТ томилогдоод явж байгаа асуудал бол компанийн засаглалын хүрээнд явах ийм боломжтой. Өөрөөр хэлбэл төр өөрөө хувьцаа эзэмшигч. Хувьцаа эзэмшигчийнхээ хүрээнд бол компанийн засаглалыг сайжруулах замаар Ки пи ай үзүүлэлтүүдийг сайжруулах боломж нь бол байгаа. Тийм учраас энэ хуулийн төсөл дээр тэр төрийн өмчийн холбогдох хууль тогтоомжууд мөн онц байдлын тухай хууль тогтоомжоор явах ийм боломжтой. Хамгийн гол нь 1991 оны хуулийн хамгийн гол асуудал нь юу вэ гэхээр ерөөсөө 1992 оноос хойш бүхий л хууль тогтоомжийг хэрэглэх боломж .../минут дуусав/

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн гишүүд хариулахдаа өөрийгөө танилцуулаад хариулна шүү. Лувсанжамц гишүүн тодруулъя.

Г.Лувсанжамц: Тийм ээ. Нөгөө санааг нь ойлгоод л байна л даа. Тэгээд нөгөө 3 компани дээр нь сайн нөлөө гарсан юм уу, муу нөлөө гарсан юм уу гэдгийг л тодруулж асуумаар байгаа юм. Тэгээд сая энэ нээлттэй, ил тод байдлыг нь гаргах ёстой гэдэг дээр Онц байдлын тухай хууль дээрээ яг энэ онцгой байдал тогтоосон нөхцөлд тайлангаа улирал тутам ч байдаг юм уу, тийм зүйл заалтыг оруулах боломж байгаагүй юу.

Л.Соронзонболд: Хэн хариулах вэ. Маш тодорхой асуугаад байна шүү дээ. Тэрэнд нь тодорхой л хариулмаар байна л даа. Хэн билээ. Хэдэн номер юм. Тэр номертой ширээ дээр суучих. 4 номер дээр суучих.

Э.Уянга: Та бүхэнд оройн мэнд хүргэе. “Эрдэнэс Тавантолгой” компаниас оролцож байгаа ажлын хэсгийн гишүүн Уянга байна. Манай компани дээр 2022 оноос хойш нийтдээ 4 удаа онцгой дэглэм тогтоогдсон. 3 удаа Засгийн газрын тогтоолоор, 1 удаа сунгах тогтоол шийдвэр нь бол Улсын Их Хурлаас 2022 онд гарсан. 2023 онд гарсан ийм байдалтайгаар зохицуулалтад ажилласан. Бид компанийн хэмжээнд Засгийн газраас томилсон онцгой бүрэн эрхт төлөөлөгч болон дараагийн удаа төлөөлөгчийн багийн гишүүдтэй хамтарч ажиллахдаа Засгийн газарт эрх олгох тухай хуулийнхаа одоо байгаа хүчинтэй хуулийнхаа ерөнхийдөө 8 дугаар зүйлийг бол голчлон баримталж ажилласан буюу засгаас өгсөн үйл ажиллагааны чиглэлийн хүрээндээ нүүрсний тээвэр, борлуулалт, хил нэвтрүүлэлт, гаалийн хурдан нэвтрүүлэх үйл ажиллагаа дээр онцгой анхаарч буюу бусад төрийн

байгууллагуудтай хамтарч ажиллах ажил дээр илүү чиглэж бүрэн эрхт төлөөлөгчийн баг бол яг нөгөө дэд .../минут дуусав/

Л.Соронзонболд: Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Энэ өдрийн мэнд хүргэе. Хуулийн төслийн зорилгыг хараад зорилгуудтай нь уяад асуултуудаа асуугаад явъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зорилго нь болохоороо хуучирсан зохицуулалтыг халж, орчин үеийн эрх зүйн тогтолцоонд нийцүүлнэ гэжээ. Энэ хүчин төгөлдөр биш болгох гэж байгаа хууль маань БНМАУ-ын хуулиуд буюу 1992 оны Үндсэн хууль батлагдсанаас өмнө батлагдсан ийм хуулиуд байна гээд тэгж байгаа юм. Тэгээд яах вэ, энэ хуулийг санаачилж орж ирж байгаа Цэнгүүн гишүүнээсээ асуухад яг одоо legalinfo дээр 1991 онд батлагдаад, одоо болтол хүчингүй болоогүй 6 хууль байна. Өнөөдөр таны орж ирж байгаа хууль бол тэрний 1 нь юм байгаа юм. Бусад 5 нь болохоор намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалын тухай, ОУВС-тай холбоотой, Өмч хувьчлах тухай хууль, Өршөөл үзүүлэх тухай хууль, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль. Тэгэхээр энэ хуулийн төслийн зорилго буюу хуучирсан зохицуулалтыг халъя гэж байгаа бол яагаад зөвхөн БЭТ-тэй холбоотой энэ хуулийг онцолж орж ирж байгаа вэ. Бусад 5 хуулийг яах вэ.

Хоёрдугаарх нь компанийн засаглалыг хуулийн дагуу хэрэгжүүлэх. Үүнтэй бол ерөөсөө маргалдах хүн энд байхгүй байх.

3 дугаар зорилго нь болохоор төрийн оролцоог хязгаарлаж, хариуцлагыг тодорхой болгох. Энэ хуулийн төсөл дээр дурдсан байгаа 2019 оноос хойш БЭТ томилсон энэ бүх компаниуд буюу Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэс Тавантолгой, Монросцветмет Тавантолгой, Тавантолгой төмөр зам, ДЦС 3 гэдэг бол бүгдээрээ төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой эсвэл орон нутгийн өмчийн оролцоотой ийм компаниуд байна. Тэгэхээр өнөөдөр яг өнөөдөр хувийн хэвшилд БЭТ томилно гэдэг асуудал ер нь хаанаас ч, хэний ч сэтгэл санаанд багтахгүй байх байх. Тэгэхээр түрүүн таны танилцуулга дээр ярьсан авлига ихдүүлэх гээд байна, асуудлууд үүсэх гээд байна гэдэг асуудал нь харин эсрэгээрээ 2019 оноос хойш эдгээр БЭТ томилогдсоноор асуудлууд нь арай цэгцрээд олон авлигал, янз бүрийн асуудлууд нь ил болсон биш билүү. Энэ дээр таны саналыг сонсьё.

Тэгээд мэдээж амьдрал баялаг шүү дээ. Төрийн өмчит компаниудыг нэмнэ гэдгийг бол хэзээ ч хүлээн зөвшөөрөхгүй байр суурьтай байгаа Улсын Их Хурлын гишүүдийн 1. Тэгээд төрийн оролцоог багасгах ёстой гэж байгаа. Тэгэхдээ аль хэдийн байгуулагдчихсан компаниуд хариуцлагатай ажиллах ёстой. Тэгээд үнэхээр амьдрал баялаг янз бүрийн юм боллоо. Ашиггүй ажиллаад байвал БЭТ томилох нь гарцаагүй гэж бол бодож байна. Тэгээд энэ дээр хариултыг нь сонсьё.

4 дүгээр зорилго болохоороо онцгой нөхцөл дэх зохицуулалтыг Онц байдлын тухай хуульд төвлөрүүлье гээд энэ хуулийг дагаад та Онц байдлын тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа юм байна. Тэгэхээр энэ Онц байдлын тухай хуульд өөрчлөлт оруулахдаа одоо энэ хүчингүй болж байгаа хуулийн зохицуулалтыг нь хэвээр нь хадгалж байна уу. Яг ямар сайжруулалтыг оруулж байна вэ. 4 асуулт байгаа.

Л.Соронзонболд: Хууль санаачлагч Цэнгүүн гишүүн хариулъя.

С.Цэнгүүн: Уянга гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр хуулийн төслийн зорилго маань бол ердөөсөө Монгол Улсын Үндсэн хууль батлагдсанаас хойш өмнөх нийгмийн үед ашиглаж байсан хуулиудаа бүгдийг нь хүчингүй болгоод, өнөө цагийн Үндсэн хуульдаа буюу хувь хүний өмч болон хувь хүний эрхийг хамгаалсан тэр олон улсын фактуудад гэрээ конвенцуудад орсныхоо жишгээр энэ хуулиа бид бүхэн нийцүүлж шинэчлэх шаардлага нь бол үүсэж байгаа. Харамсалтай нь бас таны хэлдгээр хэд хэдэн хуулиуд бол амь бөхтэй өнөөдрийг бол хүрсэн.

Миний хувьд яагаад энэ хуулийг анхаарах болсон бэ гэвэл өнгөрсөн жилийн 6 сард болж байсан ДЦС 3 дээр болсон дэлбэрэлт байгаа. Тэр ДЦС 3 дээр үүссэн дэлбэрэлтийн дараа ямар нэгэн байдлаар тухайн эрчим хүчний компанийг удирдаж байсан гүйцэтгэх захирал тухайн шатад ажиллаж байгаа хүмүүсээс ямар нэгэн хариуцлага хүлээхгүйгээр тэр дээр БЭТ томилох шийдвэр Засгийн газраас томилогдоод явсан. Энэ дээр бол салбарын сайд болон ямар нэгэн хүн хариуцлага хүлээхгүйгээр Чойжилсүрэн сайд тухайн үед бол 1 хүний амь нас эрсэдчихээд байхад ч гэсэн ажлаа өгөөгүйгээр цааш нь үргэлжлүүлээд ажилласан байгаа. Энэ хуулийн дараагийн 1 хүндрэлтэй, хүндрэл үүсгээд байгаа асуудал нь бол энэ компанийн засаглалыг сайжруулахаа бид бүхэн зайлшгүй хийх ёстой буюу төрийн өмчит компаниуд дээр үүсээд байгаа энэ авлага болон зардлын хяналтыг бид бүхэн тогтоож чадахгүй байгаад байгаа юм. Тэр нь юутай холбоотой вэ гэхээр БЭТ-ийн гаргасан шийдвэр нь Монгол Улсын бусад хууль тогтоомжоор шүүгдэхгүй буюу шүүх дээр очоод тэр хүний гаргасан шийдвэр нь энэ Хөдөлмөрийн тухай хууль, Компанийн тухай хуулиар ч байдаг юм уу зохицуулагдахгүй буюу бүрэн эрхт гэдэг нь хязгааргүй эрхт хаан шигээр ажиллах боломжийг нь олгоод байгаа дээрээ хүндрэл үүсчээд байгаа юм.

Ингээд дараагийн нөхцөл байдал дээр бол Онцгой нөхцөл байдал дахь зохицуулалтыг Онц байдлын тухай хуульд төвлөрүүлэхээр бид бүхэн тусгаж өгсөн байгаа юм. Тэгэхээр Онцгой байдлын тухай хуулийг бид бүхэн 1995 онд гаргасан. Энэ хууль дээр бол онцгой нөхцөл байдал үүсэх үеийг бол Улсын Их Хурлаас журмаар гаргаж байгаа. Онцгой байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэх зөвлөлийн онцгой бүрэн эрх буюу энэ хууль дээр бол тухайн цаг үед нь шийдвэрүүдийг нь баталгаажуулаад зөвлөл гаргана. Тэр зөвлөлийн үүргийг ямар нэгэн байгууллага, аж үйлдвэрүүд нь жишээ нь хүнсний хангамж тасарсан байгаа тохиолдолд тухайн байгууллагын бараа бүтээгдэхүүнийг нь зах зээлийн дундаж үнээр нь аваад, онц байдал үүсэхээс өмнөх үеийн дундаж үнээр нь авна гэх мэтээр илүү тодорхой заалтуудыг нь бол гаргаж өгсөн. Энэ хуулийн үндсэн үзэл баримтлал дээр бол Засаг даргын онцгой бүрэн эрх буюу бас Засаг даргад нь бас бүрэн эрхүүд нь байж байгаа. Тэгэхээр энэ мэтчилэн шигтгэж илүү тодорхой байлгах зүйлүүдийг нь гаргасан. Жишээ нь, Онц байдлын тухай хууль дээр бол шийдвэр болон түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдах албан тушаалтныг бол шууд огцруулж байсан. Тэгэхээр бидний оролцуулж байгаа нөхцөл байдал дээр бол онц байдлын хугацаагаар тэр албан тушаалтныг түдгэлзүүлж байгаа буюу тэр хүнийг шууд ажлаас нь халах биш, тухайн онц байдлын нөхцөл дээр нь түдгэлзүүлж байгаад онц байдал цуцлагдсаны дараагаар буцаад тэр хүн хэвийн ажлаа хийх, аль эсвэл тухайн хүн дээр нь хариуцлага шүүхийн шийдвэртэйгээр гүйцэтгэх байгаа юм.

Дээрээс нь Онц байдлын тухай хууль дээр 1 зүйл байгаа нь манай хуулиуд уялдаагүй явдгийн 1 илрэл нь бол онц байдлын хэрэгжүүлэх хугацаанд бас 1 заалт байгаа нь болохоор би та бүхэнд хариулъя. Онц байдал хэрэгжүүлэх хугацаанд

үйлдсэн гэмт хэрэгтээ цаазаар авах ял шийдэгдсэн хүний ялыг онц байдал үргэлжлүүлэх хугацаанд болон онц байдал дуусгавар болсон, онц байдлыг цуцалснаас хойш 30 хоногт гүйцэтгэж болохгүй буюу Монгол Улс цаазын ялгүй болсон. Тэрэнтэй холбоотойгоор энэ зүйл заалт бас Онц байдлын тухай хуулиас хасагдах ёстой байсан байгаа. Тэгэхээр бас энэ хуульдаа энэ зүйл заалтыг бас хүчингүй болгохоор өгсөн байгаа.

Л.Соронзонболд: Уянга гишүүн тодруулж асууя.

Б.Уянга: Тодорхой хариулт өгч байгаад баярлалаа. Энэ Онц байдлын тухай хуулийн та хэдийн оруулж ирж байгаа энэ хувилбарыг харахаар төслийг харахаар 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтад ингэж уншигдаж байгаа. Зохих ёсоор биелүүлээгүй буюу хариуцлага хүлээх гэж байгаа асуудал гарлаа. Бүх шатын удирдах ажилтныг онц байдлын хугацаагаар түдгэлзүүлнэ. Орны хүнийг онц байдлын хугацаагаар томилно. Тэгэхээр зүгээр анх энэ хууль өргөн баригдсаны дараа юу гэж ойлгосон гэхээр БЭТ гэдэг зүйлийг ер нь байхгүй болгох гэж байгаа юм байна гэж ойлготол дагаж орж ирж байгаа хууль дээр бол БЭТ гэдэг нэрээрээ биш зүгээр орны хүнийг онц байдлын хугацаагаар томилно л гэсэн байна шүү дээ. Тэгэхээр чинь БЭТ гэдэг зүйл бол байсаар байх юм байна. Тэгэхдээ яг зохих ёстой хуульдаа орж байгаа юм байна. Тэгээд хариуцлага нь илүү тодорхой болж байгаа юм байна гэж ойлгож болохоор байна уу.

Л.Соронзонболд: Хууль санаачлагч. Хэн хариулах юм. Ажлын хэсгийн 6 номер.

Э.Сундуй: “Төв тусгал” сургалт, судалгааны төвийн судлаач Сундуй гишүүний асуултад хариулья. Энэ Онц байдлын тухай хууль дээрээ 16 дугаар зүйл нь өөрөө онцгой нөхцөл байдлын талаар зохицуулсан зохицуулалт. Тийм учраас сая гишүүний яг хэлж байгаа шиг бүрэн эрхт төлөөлөгч маань онц байдлын үед бол ажиллаж болох зохицуулалт орж байна л гэсэн үг. Онцгой нөхцөл байдлын тухай зохицуулалт учраас. Тэгээд илүү тодруулж байгаа бусад зүйлүүд дээр гэсэн үг. Баярлалаа.

Л.Соронзонболд: Энхцэцэг гишүүн байхгүй байна. Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: Баярлалаа. Юуны өмнө Цэнгүүн гишүүний өргөн барьсан хуулийн төслийг бол үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа. Ер нь бол сүүлийн 10 жилд манай эдийн засаг дахь төрийн оролцоо хэт хавтгайрсан, алдаа завхрал гарсан гээд л бид нарын яриад байгаа зүйлийн бас нэг тод илрэл бол энэ БЭТ томилж байсан явдлууд. Тэгээд энэ БЭТ томилсон тохиолдлуудыг хараад байхад нөгөө түрүүний миний хэлдэг Монгол Ардын намын үнэмлэхүй олонхоороо далайлгасан тэр ийм дарангуйллын эхлэл бөгөөд ковид хавсарсан энэ эдийн засаг дахь төрийн оролцоо хэтэрсэн явдлыг л бас илтгэж байгаа зүйл байгаад байгаа юм л даа. 2019 оны 3 дугаар сард хэний ч мэдэхгүй байсан ийм хуулийг үндэслээд тэгээд анх удаагаа БЭТ томилсон. Тухайн үед хэрэв би андуураагүй бол Хүрэлсүх Ерөнхий сайд байсан. Мөн Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын үед энэ явдал давтагдсан. Хамгийн сүүлд бол Занданшатар Ерөнхий сайдын үед бол энэ явдал дахиад хэд хэдэн тохиолдлоор бол давтагдсан байгаа. Тэгэхээр ер нь бол өнгөрсөн хугацаанд бий болж байгаа энэ нөгөө хуулийн засаглалаас ухарч байгаа байдал, төрийн оролцоог хэт даамжруулж байгаа байдлын л 1 илрэл гэж хараад байгаа юм. Энэ БЭТ томилж байгаа явдал бол.

Тэгэхээр 1 асуулт байна. Энэ бол ардчилсан Үндсэн хууль батлагдахаас өмнө БНМАУ-ын Засгийн газарт онцгой эрх олгосон ийм зохицуулалт гээд байгаа шүү дээ. Тэгэхээр зүгээр эрх зүйн чадамжгүй болчихсон, тэгээд ер нь бол аль уже хүчин төгөлдөр бус байх ёстой байсан хууль. Тэгэхээр захиргааны хэргийн шүүх дээр ч юм уу эсвэл аль 1 шүүх дээр энэ асуудлыг эсэргүүцэж нэхэмжлэл гаргасан тохиолдол байна уу. 1 дүгээр асуулт.

Яагаад вэ гэхээр ер нь бол төр засгийн буруутай шийдвэрүүдийг иргэд, аж ахуйн нэгж, иргэний нийгмийнхэн эсэргүүцэж байж тухай бүр таслан зогсоож байх ёстой. Тийм ээ. Тэгэхээр тийм шүүхийн кэйс бол бас маш чухал байдаг. Ер нь цаашид бид нар бас аливаа ийм төрийн эрх мэдлээ хэтрүүлж байгаа явдал дээр нийт иргэд маань, иргэний нийгэм маань эсэргүүцэх ёстой. Тэгээд тэр бол шүүхээр явах нь бас 1 арга хэлбэр шүү дээ. Энэ Их Хурал дээр ингээд цуцлах санаачилга оруулж байгаа нь бол бас дахиад 1 арга хэлбэр. Тэгэхээр энэ дээр хариулт өгөөч гэж хүсэж байна.

2 дугаар асуулт нь болохлоор Онц байдлын тухай хуульд бол өөрчлөлт оруулж байна. Тэгэхээр Онц байдлын тухай хуульд оруулж байгаа зохицуулалтууд бол зөвхөн онц байдал зарласан тохиолдолд үйлчилнэ гэж ойлгож байгаа шүү дээ. Одоо нөгөө Онц байдлынхаа тухай хуулиар яг онц байдал тогтоосон тохиолдолд л энэ саяын түр орлон гүйцэтгэгч тэр албан тушаалтнуудыг солих боломж нээгдэнэ гэж ойлгож байгаа. Зөв биз дээ.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 3 номерын микрофоныг нээе.

Д.Цэрэнбадам: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Намайг Цэрэнбадам гэдэг. Жаргалан гишүүний асуултад хариулъя. Би 2019 оноос хойш Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд энэхүү Засгийн газарт эрх олгох тухай хуулийн асуудлаар гомдол мэдүүлээд, энэ асуудал нь өөрөө өнөөдрийг хүртэл яагаад шийдэгдээгүй вэ гэхээр Монгол Улсын цэцийн тухай хуульд 1992 оны Үндсэн хууль батлагдахаас өмнөх хугацааны бүх хуулиудыг авч хэлэлцэх эрх зүйн үндэслэл байхгүй байсан. Тэгээд энэ асуудал өөрөө 2024 онд Их суудлын хуралдаанаар эцэслэгдэн шийдвэрлэгдсэнээр энэ маргаан бол өнөөдөр хэлэлцэгдэх боломжтой болсон. Тэгээд энэ асуудлыг бол манай яг энэ чиглэлээр явж байсан өмгөөлөгч бол хариулна.

Гол 3 асуудал байгаа. 1 дүгээрт нь юу юм гэхээр 1966 онд Монгол Улс улс төрийн болон иргэний эрхийн батлагдсан фактад бол нэгдэж орсон байгаа. Энэхүү фактын зүйл заалтаар юу юм бэ гэхээр Монгол Улс хүний эрхээсээ буцсан тохиолдолд энэ талаар НҮБ-ын ЕНБД-д 3 хоногийн дотор мэдэгдэх ёстой. Өөрөөр хэлбэл онцгой нөхцөл байдал тогтоож байгаа тохиолдолд 3 хоногийн дотор Гадаад харилцааны сайдаараа дамжуулаад мэдээлэл өгөх ёстой. Энэ зохицуулалт өөрөө энэ Засгийн газарт эрх олгох тухай хууль дээр байхгүй байгаа юм. Тийм учраас Цэнгүүн гишүүний санаачилсан энэ ажлын хэсэг энэ хууль тогтоомжийг олон улсын факттай нийцүүлье гэж байгаа юм. Нэгдүгээрх нь.

2 дугаарт Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйл дээр онцгой дэглэмийг тогтоож болно. Хуулиар бол хүний эрхийг хязгаарлана. 25, 33 дугаар зүйл дээр Улсын Их Хурал тогтоохоор, Монгол Улсын Ерөнхийлөгч тогтоохоор зааснаас биш Засгийн газарт эрх олгох тухай зохицуулалт байхгүй. Тийм учраас Монгол Улсын Үндсэн хуульдаа нийцүүлье гэдэг агуулга явж байгаа юм.

3 дахь агуулга нь юу юм бэ гэхээр БНМАУ-ын тухай энэ 1991 оны хууль нь 1992 онд Үндсэн хууль батлагдсанаараа 1996 онд багтааж тэр хавсралт хуулийн дагуу хүчингүй болох ёстой. Гэтэл энэ хүчингүй болгох арга ажиллагааг Улсын Их Хурал өнөөдрийг хүртэл хийгээгүй байгаа учраас ажлын хэсэг энэ асуудлыг оруулж ирж, энэ хуулийг хүчингүй болгуулах санал тавьж байгаа юм. Энэ хуулийн өөрөө үзэл санаа, мөн чанар нь юу юм бэ гэхээр Засгийн газар шаардлагатай гэсэн тохиолдол. Шаардлагатай гэдэг үг үсэг бол дураар авирлах, ямарваа нэгэн эрх хэмжээгээ хэтрүүлэх энэ боломжийг бүрдүүлнэ гэж ойлгож байгаа юм. Тийм учраас Монгол Улсын эрх зүйн салбарт энэ хууль бол хүчин төгөлдөр байснаараа Монгол Улсын хүний эрхийн олсон ололтыг цаашид ямарваа нэгэн байдлаар доош нь ухраах, хүний эрхийн үзүүлэлтүүдийг хойш нь татах ийм үзүүлэлт болох юм. Тийм учраас энэ хуулийг Монгол Улсад байхгүй байх ёстой гэдэг ийм ажлын хэсгийн байр суурь байгаа. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Соронзонболд: 5 номер гүйцээж хариулья.

Ц.Мөнхбат: Ажлын хэсгийн гишүүн Мөнхбат. Яг энэ Эрдэнэс Тавантолгой болон бусад компани дээр БЭТ томилсонтой холбоотой маргаанууд дээр би 20 орчим маргаан дээр явсан. Үндсэн хуулийн цэцэд яг энэ Засгийн газарт эрх олгох тухай хуулийг бол 2 удаа хандсан. Энэ дээр 1 жишээ хэлье. Энэ 1991 оны хууль зөвхөн БЭТ томилох тухай асуудал биш. Өөрөөр хэлбэл эрх зүйн онцгой дэглэм буюу өөрөө Үндсэн хуулиас давсан онцгой дэглэм тогтоох эрхийг олгочхож байгаа юм. Үүний ганцхан жишээ хэлье. Эрдэнэс Тавантолгой компани дээр бүтцийн өөрчлөлт хийгээд уг нь бол Хөдөлмөрийн тухай хуулиар бол бүтцийн өөрчлөлтөөр ажлын тэтгэмж авдаг. Ажилласан хугацааны тэтгэмжийг авдаг. Гэтэл энэ Засгийн газрын 1991 оны хуулийг баримтлаад нийтлэг хууль тогтоомжийг хэрэглэхгүй буюу ерөөсөө энэ хуулиас өөр хууль тогтоомжийг огтоосоо хэрэглэхгүй. Ингээд шүүхэд нэхэмжлэл гаргаад, шүүх 1991 оны хуулийг баримтлаад тэдгээр хүмүүст бол ажилд эргүүлэн тогтоох байдаг юм уу эсвэл .../минут дуусав/

Л.Соронзонболд: Жаргалан гишүүн тодруулья.

Б.Жаргалан: Тэгэхээр түрүүн бас зарим гишүүд БЭТ томилсноороо тухайн компанийн ашиг орлого сайжраад байна шүү дээ гэсэн зүйлийг бас ярьсан. Тэгэхээр тухайн компанийн ашиг орлого яагаад сайжирсан гэдэг дээр бид нар бас үнэлэлт дүгнэлт өгөөд, тэр нөгөө Нийтийн өмчийн тухай хууль байдаг уу, энэ төрийн өмчийн компаниудын засаглалтай холбоотой асуудлууд дээр бас оруулах ёстой гэж харж байгаа. Тэгээд саяын Мөнхбат хуульчийн хэлснээр нөгөө талд нь хэчнээн бас иргэдийн эрх ашиг хохирсон бэ гэдэг тоо бас гармаар байгаа юм. . Одоо жишээлэх юм бол нөгөө цалин хөлс, гэнэтийн халагдсаны тэтгэмж энэ тэр аваагүй ч гэдэг юм уу. Нөгөө талд нь гарч байгаа хохирлыг бид нар бас яг зохих хэмжээнд нь дүгнэх ёстой. Яагаад вэ гэхээр энэ чинь өмчийн хамгааллын тухай асуудал яригдаж байна. Иргэдийн хөдөлмөрлөх эрхийн тухай асуудал яригдаж байна. Тэгэхээр бол иймэрхүү тооцоо судалгаанууд ер нь гарч байна уу. Ер нь тэгж бид нар харьцуулалт хийх боломжтой юу. Тэгээд энэ БЭТ томилсон жишээнүүд дээр жишээлбэл тэр компанийн засаглалтай холбоотой асуудлууд дээр ямар .../минут дуусав/

Л.Соронзонболд: Хууль санаачлагч. Ажлын хэсгийн 4 номерыг микрофоныг нээе.

Ж.Дамбаасүрэн: Оройн мэнд Жаргалан гишүүний асуултад хариулья. Ажлын хэсгийн гишүүн Дамбаасүрэн. Мөн энэ ташрамд Улсын Их Хурлын гишүүн

Лувсанжамцын мөн асуултад гүйцээгээд хариулъя. Өнгөрсөн хугацаанд нийт БЭТ томилсон 7 компаниас Дулааны 3 дугаар цахилгаан станц компани болоод Тавантолгой төмөр зам компаниудын мэдээллийг бол авах боломжгүй буюу гаргаж өгөхгүй байгаа. Дулааны 3 дугаар цахилгаан станц дээр өнгөрсөн оны 6 дугаар сарын 18-нд томилогдсон төлөөлөгч бол одоогийн байдлаар Авлигатай тэмцэх газарт шалгагдаж байгаа шалтгаанаар бол ажил үүргээ гүйцэтгэхгүй байгаа. Энэ компани дээр бол одоогийн байдлаар ашигтай зүйл харагдахгүй байгаа. Тухайлбал, 5 хоногийн өмнө Эрчим хүчний сайдаар ахлуулсан ажлын хэсэг тухайн компани дээр ажиллахад урт хугацааны өр төлбөр нь 37,5 тэрбум төгрөг, богино хугацаат өр төлбөр .../минут дуусав/

Л.Соронзонболд: Хариултыг гүйцээе. 4 номерын микрофоныг нээе.

Ж.Дамбаасүрэн: Жижиг Тавантолгойн тухай буюу Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулдаг Тавантолгой компани дээр 10 сарын хугацаанд Засгийн газраас БЭТ томилсон. Энэ хугацаанд бол Монгол Улсын нийтдээ экспортолж байгаа нүүрсний хэмжээ бол 2022 онд 27,5-30 сая, 2023 онд 60-70 сая тонн буюу 1 дахин нэмэгдсэн нь бол Орос-Украины дайнтай холбоотойгоор нүүрсний үнэ дэлхийн зах зээл дээр 457 доллар болсноор нэмэгдсэн. Өөрөөр хэлбэл бүрэн эрхт төлөөлөгчийн үйл ажиллагаатай хамааралгүйгээр дэлхийн зах зээлд нэмэгдсэн. Мөн худалдан авагчийн худалдан авах нүүрсний хэмжээ нэмэгдсэнээрээ л ашигт ажиллагаатай харагдаж байгаа.

Төгсгөлд нь Тавантолгой төмөр зам дээр бол бид нар мэдээлэл авахаар оролдсон боловч энэ дээр тодорхой мэдээлэл бол өгөөгүй. Тэгэхээр .../минут дуусав/

Л.Соронзонболд: Гишүүд асуулт асууж дууслаа. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Уянгахишиг гишүүнээр тасаллаа. Уянгахишиг гишүүний микрофоныг нээе.

Г.Уянгахишиг: 1991 оны 1 сарын 4-ний өдөр батлагдсан БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай гэдэг хуулийг хүчингүй болгох хуулийг бол дэмжиж байгаа. Харин энэ дээр 1 юмыг бид нар бас анхаарч хармаар байна. Одоо дагалдах хуулиар дагалдуулж оруулж ирсэн нь болохоор Онцгой байдлын тухай хууль дагалдуулаад оруулаад ирж байгаа байхгүй юу. Гэтэл яг энэ хуулийн зохицуулсан асуудлыг харах юм бол энэ яг онцгой байдалтай бол хамаатай биш. Өөрөөр хэлэх юм бол шилжилтийн үед буюу нөгөө төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн систем рүү шилжихэд тухайн үед бол хувийн хэвшил байгаагүй. Хувийн компаниудын тухай ярих боломж байгаагүй буюу төрөөс үйлчилгээ үзүүлдэг үйлдвэрийн газрууд, тэгээд байгууллагуудын хувьд тухайн засаглалын асуудлыг шийдэх, үйл ажиллагааг нь онцгой дэглэм тогтоох байдлаар шилжилтийн үед зохицуулах шаардлага гарч байсан учраас энэ хууль батлагдсан гэж харж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол тухайн үед бусад хуулиудыг нь харахаар нөгөө социализмын үед үйлчилж байсан хуулиуд шинэчлэгдээгүй байсан гэсэн үг шүү дээ. Тэгэхээр энэ хууль бол тухайн үедээ үүргээ биелүүлээд дуусчихсан хууль харагдаж байгаа байхгүй юу. Өнөөдөр бид нар төрийн өмчит компанийн төрийн болон орон нутгийн өмчит компанийн БЭТ томилох тухай асуудал яригдаж байгаа бол энийг тэр Төр болон орон нутгийн өмчийн тухай хуулиараа зохицуулалтаа оруулж ирэх ёстой. Тэрнээс биш ерөнхийлөн Онцгой байдлын тухай хуульд бол орох шаардлагагүй гэж харж байгаа юм.

Тэгэхээр яг энэ утгаараа өнөөдөр дагуулж бол оруулж ирээгүй байна. Гэхдээ энэ асуудлыг Засгийн газар өөрөө санаачилж оруулж ирэх ёстой. Өөрөөр хэлбэл хэрвээ энэ хууль хүчингүй боллоо гэхэд БЭТ томилох боломжгүй болох юм байна. БЭТ бол заавал ийм, ийм учраас хэрэгтэй юм гэдэг тэр үндэслэл шалтгаан шаардлага бүх юмаа судалгаагаа Засгийн газар гаргаж ирээд, тэгээд тэр Төр, орон нутгийн өмчийн тухай хуульдаа байна уу, одоо шинэчилсэн найруулгаар оруулж байгаа төрийн өмчит компанийн тухай хуульдаа байна уу. Оруулах энэ асуудлаа зохицуулах ёстой учраас би бол энэ хуулийг хүчингүй болгох тэр хуулийг дэмжиж байгаа.

Харин энэ хүрээндээ ажлын хэсэг дээрээс Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулаад, тэр хууль Улсын Их Хурлын тогтоолоор Засгийн газарт чиглэл, үүрэг өгөх байдлаар шийдвэрлэх нь зүйтэй гэж харж байгаа юм. Тэрнээс биш 1991 онд үүсэж байсан нөхцөл байдлыг бид нар өнөөдөр Онцгой байдал руугаа оруулж ирж шийдэж бас болохгүй болчихоод байна. Яагаад гэвэл энэ чинь өөрөө тухайн хуулийн зохицуулж байсан харилцаа нь өөр байгаад байгаа учраас. Тэгэхээр миний санал бол ийм байна. Тэгэхээр энэ хуулийг бол хүчингүй болохыг дэмжиж байна. Нэгэнт үүргээ гүйцэтгэсэн хууль гэж харж байна. Цаашдаа энэ хуульд зохицуулж байсан асуудлууд энэ бол өөрөө шилжилтийн үеэс үл хамаарсан буюу түрүүн жишээлбэл хэлж байна шүү дээ. Захирал нь АТГ-с ингээд гүйцэтгэх захиралгүй болчихсон. Тэгвэл Засгийн газар тэрийг яаж зохицуулах вэ гэдэг асуудал гарч ирж байна гэсэн үг. Тэгэхээр энэ бол өөрөө хуулийн этгээдийнхээ хувьд зохицуулагдаад явах ёстой асуудал байхгүй юу. Энэ жишээлбэл зөвхөн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьд зохицуулалтууд орж ирэх асуудал болохоос биш хувийн компаниуд дээр, жишээлбэл онц байдал зарлах ч гэдэг юм уу, онц дэглэмийн тухай асуудал байхгүй шүү дээ. Тэгэхээр миний санал бол ийм байна.

Л.Соронзонболд: Гишүүд үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг үндэслэн хуулийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж ажлын хэсгийн гишүүд гарч байж болно. Санал хураалт явуулъя.

1.БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 57,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Хамт өргөн мэдүүлсэн, Онц байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 47,6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. Санал хураалт явуулж дууслаа.

БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг

чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал танилцуулна. Хуулийн төслүүдийг хэлэлцэж дууслаа.

18.29 цаг.

Зарим дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүний хүсэлт, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн санал болон Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүний Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлөгдөж, Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны бүрэлдэхүүнд орж ажиллах тухай саналыг танилцуулъя.

Эдийн засгийн байнгын хорооны дарга Сэддорж Танаа

Улсын Их Хурлын гишүүн миний бие Эдийн засгийн байнгын хорооны дэргэдэх Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны бүрэлдэхүүнд багтсан бөгөөд тус бүрэлдэхүүнээс нэрээ хасуулж, Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны бүрэлдэхүүнд орох хүсэлтэй байна. Энэхүү хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж өгнө үү.

Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн.

Ардчилсан намын бүлгийн саналыг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын дарга Дашзэвгийн Амарбаясгалан танаа

Дэд хорооны гишүүнээр томилуулах тухай 2025 оны 10 сарын 7-нд ирсэн бичиг юм байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлд тус тус заасны дагуу Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Эдийн засгийн байнгын хорооны харьяанд байх Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүнийг томилуулах саналаа үүгээр хүргүүлж байна.

Бүлгийн дарга Цогтгэрэл.

Гишүүний саналтай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэгт заасныг үндэслэн зарим дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүний хүсэлт, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн саналыг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү.

1. Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүнийг Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны бүрэлдэхүүнд оруулах оруулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 61,9 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

Зарим дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Очирбат танилцуулна. Саналыг хэлэлцэж дууслаа.

18.32 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж эхэлье.

Тайлангийн танилцуулгыг Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Хүдэрчулуун хийнэ. 3 номерын микрофоныг нээе.

Н.Хүдэрчулуун: Эдийн засгийн байнгын хорооны хуралдаан даргалагч, Эдийн засгийн байнгын хорооны нийт гишүүддээ оройн мэндийг хүргэе.

Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны үйл ажиллагааны тайланг товч танилцуулъя.

2006 онд Улсын Их Хурлаар Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль 1 сарын 25-ны өдөр батлагдсанаар Монгол Улсад хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээл, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо гэсэн үндсэн 4 зохицуулалттайгаар Санхүүгийн зохицуулах хороо байгуулагдсан. Өнөөдөр 2026 онд Санхүүгийн зохицуулах хороо үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ой бас тохиож байна.

2020 онд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор энэ санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид болох үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт металл, үнэт чулууны, эсвэл тэдгээр хийсэн эдлэлийн арилжээ эрхлэгчийн зохицуулалтын салбарыг Санхүүгийн зохицуулах хороонд, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх агуулгаар Санхүүгийн зохицуулах хорооны хяналт зохицуулалтад өгсөн байдаг.

2021 онд Банкны тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Виртуал хөрөнгийн тухай хууль, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2021 оны хамтарсан тушаалаар энэ сендбокс зохицуулалтын орчин болон системийн нөлөө бүхий банкнуудыг олон нийтийн болгох үйл ажиллагаа явсан. Энэ хүрээнд Монгол Улсын системийн нөлөө бүхий банкнууд хувьцаат компанийн нэгэн адилаар Санхүүгийн зохицуулах хорооны хяналт зохицуулалтад хамрагддаг болсон.

2021 оны 12 дугаар сард Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль батлагдсан байдаг. Уг хуулиар Монгол Улсад үйл үйл ажиллагаа явуулж байгаа виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь Санхүүгийн зохицуулах хорооны

хяналт зохицуулалтад байна гэж тусгагдсаны дагуу 2020 оноос энэ виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг бүртгэж эхэлсэн байна.

2023 онд Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулиуд Улсын Их Хурлаар тус тус батлагдсанаар мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, мөн Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны хяналт зохицуулалт Санхүүгийн зохицуулах хороонд ирсэн.

Өнөөдөр 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт Санхүүгийн зохицуулах хорооны нийт зохицуулалттай салбар 11 салбар. Салбарын үйл ажиллагааг 190 албан хаагчтайгаар Санхүүгийн зохицуулах хороо энэ онд ажиллалаа.

Зохицуулалтын салбарууд 2020 онтой харьцуулахад 2 дахин нэмэгдсэнтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалттай этгээдийн тоо бол жил ирэх тусам өсөн нэмэгдсээр байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар 5930 нийт зохицуулалттай этгээд үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрийг салбар тус бүрээр харьцуулж харвал хөрөнгийн зах зээлийн нийт мэргэжлийн оролцогчид 634, даатгалын салбарт 354, ББСБ-д 575, 176 ХЗХ, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч 589, үл хөдлөх хөрөнгө зуучлалын нийт 289, үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч хуулийн этгээд 52, 504 хувь хүн үйл ажиллагаа эрхэлж байна.

Мөн сендбокс зохицуулалтын орчинд 5 бүтээгдэхүүний үйл ажиллагаа сендбокс зохицуулалтын орчинд байна. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч 12, нэмэх нь виртуал хөрөнгийн аудитын үйлчилгээ үзүүлэлт 6, нийт виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарт 18 зохицуулалттай этгээд үйл ажиллагаа явуулж байна. Даатгалын төлөөлөгч 1143, нийт энэ 11 салбарын 1591 салбар төлөөлөгчийн газар ажиллалчирсан байна.

Санхүүгийн салбарын гол тодорхойлогч олон улсын санхүүгийн салбаруудыг тухайн санхүүгийн салбарын үр нөлөө ямар түвшинд байгаа вэ гэдгийг илэрхийлэх нэг чухал үзүүлэлт бол тухайн санхүүгийн салбаруудын нийт ДНБ-д эзлэх харьцаа байдаг. 2025 оны жилийн эцсийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалт нь байдаг нийт 4 үндсэн салбар бол хөрөнгийн зах зээл, даатгал, ББСБ, ХЗХ-ны нийт салбарын ДНБ-д эзлэх хувь хэмжээ 26,8 хувьтай байна.

Хамгийн өндөр нь нийт хөрөнгийн зах зээл бол ДНБ-ний 15 хувьтай, даатгалын зах зээл 0,9 хувьтай, ББСБ 10,1 хувьтай, ХЗХ 0,4 хувьтай тэнцүү хэмжээтэй байна.

Санхүүгийн зохицуулах хороо эдгээр 11 салбарт нийт 29 хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Зөвшөөрлийн тухай хууль 2023 оны 1 сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой болон Санхүүгийн зохицуулах хороонд нийт 64 хэм хэмжээний актыг 36 болгон бууруулсан.

Мөн Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 124 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа нийт 36 хэм хэмжээний актыг 29 болгон бууруулахаар бас ажиллаж байна. Энэ Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсан тохиолдолд Санхүүгийн зохицуулах хороо дээр одоо 33 тусгай зөвшөөрөл байна. Эдгээр 33 зөвшөөрлийг 31 болгох. Энгийн 26 зөвшөөрөл байна. Эдгээрийг 16 болгох. 9 үйл ажиллагааг мэдэгдлээр гүйцэтгэгдэх үйл ажиллагаа болгохоор холбогдох хуулиуд дээр ажиллаж байна.

Зах зээл тус бүрийн ерөнхий мэдээллүүдийг бас товч танилцуулъя. Хөрөнгийн зах зээлийн гол тодорхойлогч үзүүлэлт болох зах зээлийн үнэлгээ 2025 оны жилийн эцсийн байдлаар 13,8 их наяд төгрөгт хүрлээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6,6 хувиар өссөн байна. Хөрөнгийн зах зээлийн нийт арилжаа, арилжааны дүн бол 1,3 их наяд төгрөгт байна. Үүнийг бүтцээр нь задлаад үзвэл компанийн бонд 24,6 хувь буюу 323,6 тэрбум. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас 372,1 тэрбум тус тус эзэлж байна. Энэ арилжаанд оролцсон бүтцийг аваад үзвэл дотоодын аж ахуйн нэгж нийт арилжааны 72,4 хувийг эзэлж байгаа ийм дүнтэй байна.

2025 онд шинээр нийт 12470 шинэ данс нээгдэж, Монгол Улсад нийт нээгдсэн дансны тоо өссөн дүнгээр 2,6 саяд хүрсэн байна. 2021 онд Монгол Улсад биржийн бус зах зээлийн эрх зүйн орчин бүрдэж, биржийн бус зах зээлийг бий болгосон байдаг. 2025 оны байдлаар 150 хувийн хэрэгслийг 125 үнэт цаас гаргагч нийт зах зээл дээрээс 1,6 орчим их наяд төгрөгийг биржийн бус зах зээлээс татан төвлөрүүлсэн байна.

2025 оны жилийн эцсийн байдлаар энэ уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны дүнг авч үзвэл нийт арилжааны тоо 619 арилжаанд 27,8 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг нийт үнийн дүн нь 7,3 их наяд төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

Хөрөнгийн зах зээл дээр 2025 онд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны бас онцлох ажлуудаас товч танилцуулъя.

Санхүүгийн зохицуулах хороо Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтраад топ 100 аж ахуйн нэгж гэдэг энэ хөтөлбөрийг зарласан. Өөрөөр хэлбэл Монгол Улсын топ 100 аж ахуйн нэгжид хамрагдаж байгаа аж ахуйн нэгжүүд нээлттэй болон хаалттай захаас бонд босгох, шинээр IPO хийх зэрэгт Санхүүгийн зохицуулах хорооноос мөрдөгддөг тодорхой хууль, дүрэм журмуудад өөрчлөлт оруулах замаар илүү түргэн шуурхай, барьцаагүйгээр татах боломжийг бүрдүүлсэн. Энэ хүрээнд Монголын тэргүүлэх компаниуд 1 болох Шунхлай компани 180 тэрбум төгрөгийн барьцаагүй “А” гэсэн үнэлгээтэй энэ бондыг амжилттай татан төвлөрүүлсэн байна. Мөн “Сүү” хувьцаат компани богино хугацаатай, барьцаагүй зээлийг мөн 5 тэрбум төгрөгийн ийм богино хугацаат санхүүжилтийг зах зээлээс амжилттай татсан.

Мөн нийгмийн болон тогтвортой байдлын энэ бондын зохицуулалтын орчныг бий болголоо. Энэ хүрээнд Хаан банк Монгол Улсад анх удаа жендер бонд буюу энэ нийгмийн болон тогтвортой байдлын энэ үйл ажиллагаанд зориулсан бондыг гаргасан. Өнөөдрийн байдлаар 307 эмэгтэй бизнес эрхлэгчийг яг энэ татан төвлөрүүлсэн хөрөнгөөрөө санхүүжүүлсэн .../минут дуусав/

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Хүдэрчулуун Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн бөгөөд дэд дарга, Цогтгэрэл ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батболд Даатгалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Алтантуул Хадгаламж зээлийн хоршооны газрын дарга, Батчимэг Зах зээлийн судалгаа хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Мөнх-Оргил Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Нинжин Үнэт цаасны газрын ахлах зөвлөх, Баянмөнх Хяналт шалгалт зохицуулалтын газрын ахлах зөвлөх.

Танилцуулгатай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Батнайрамдал гишүүнээр тасаллаа. Лувсанжамц гишүүн асуулт асууя.

Г.Лувсанжамц: Оройн мэнд хүргэе. Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаанд бол сэтгэл хангалуун байдаг. Бас ялангуяа сүүлийн 5 жилийн хугацаанд бол нэлээн өсөлттэй байсан салбар болов уу гэж боддог. Гэхдээ яах вэ, сая өнгөрсөн 1 жилийн хугацаанд бол жоохон өсөлт бол багассан ч гэсэн цаашдаа бас эрчимжээд явах болов уу гэсэн найдлага, хүлээлт бол байгаа. Өнөөдөр гаргаж байгаа тайлантай холбогдуулаад 5 жилийн үндсэн чиглэл буюу 2026-2030 он хүртэлх үндсэн чиглэл дээр та бүхний зорилт байгаа. 5.5.1 дээр санхүүгийн салбарын зах зээлийн үнэлгээ нийт хөрөнгийн ДНБ-д эзлэх хувь гэсэн. Тийм ээ. Тэгэхээр энэ 5 жилийн үндсэн чиглэл дээр болохлоор та бүхэн маань 2027, 2028 оны байдлаар 26,70 хувьд хүргэнэ гэсэн зорилт тавьсныгаа 2025 ондоо биелүүлчихсэн байна. Тэгэхээр 5 жилийн үндсэн чиглэл дээр тавьсан энэ зорилтоо та бүхэн маань шинэчилж гэж төлөвлөж байгаа юу. Арай илүү өндөр зорилт тавиад явах уу. Эсвэл энэ тоогоороо бариад явна ч байдаг юм уу. Мэдээж нөгөө жил болгоноор чинь эзлэх хувь нь бас өөр болох болов уу гэдгээ бодож байгаа болохлоор тийм өөрчлөлт яг хийх ажил төлөвлөж байгаа болов уу гэсэн эхний асуулт.

2 дахь нь цаг үеийн шинжтэй асуулт асууя. Банк бус санхүүгийн байгууллагууд дээр зээл авахад өр, орлогын харьцаа гэж байгаа. Тэрийг одоогийн байдлаар хэдэн хувьтай барьж байгаа вэ. Монголбанк бол 45 хувь болгож бууруулаад энэ чиглэлд нь барина гэсэн хандлагатай байна лээ. Санхүүгийн зохицуулах хорооноос ямар тоог тооцоолж байгаа вэ. Ялангуяа манай гадаадад үүсээд байгаа нөхцөл байдлын улмаас хэрвээ бид нар бичил зээлээ тэлээд явах юм бол хэрэглээ өсөөд ханш эсвэл инфляцад бас нөлөөлөх магадлалтай байгаа учраас энэ талаар төлөвлөгөөгөө танилцуулж өгнө үү.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 3 номерын микрофоныг нээе.

Н.Хүдэрчулуун: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны жилийн 1 гол зорилт бол санхүүгийн салбарын эрх зүйн шинэтгэлийг хийх гэдэг энэ төлөвлөгөөг тавьж байгаа. Өөрөөр хэлбэл Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээс хойш сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд санхүүгийн системийг олон тулгуурт санхүүгийн системийг бий болгоно гэдэг энэ гол зорилтыг тавьсаар ирсэн. Сүүлийн энэ 5 жилийг эс тооцвол Монгол Улсын нийт санхүүгийн зах зээлийн 95 хувь нь банкны систем, үлдсэн 5 хувь нь банк бус санхүүгийн салбар эзэлж ирсэн. Сүүлийн 5 жилийн хугацаанд энэ үр дүн дээр бас харьцангуй өөрчлөлт гарч байгаа боловч бид нарын төлөвлөж байснаас 2028 оны зорилтынхоо түвшинд бол одоо хүрсэн байж байгаа. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны стратеги төлөвлөгөө дунд хугацааны буюу энэ 5 жилийн бас стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Энэ хүрээндээ бид нар илүү олон тулгуурт санхүүгийн систем буюу энэ хөрөнгийн зах зээл, даатгалын салбарыг илүү нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөтэй ийм салбар болгож хөгжүүлж, санхүүгийн салбарын 1 гол тоглогч болгох ийм зорилт тавьж байгаа. Өөрөөр хэлбэл энэ хуулийн төслүүдийг бас баталж энэ эрх зүйн орчныг бүрдүүлснээр бид нар санхүүгийн системийн 1 гол тулгуурыг бас ийм босгох боломж бүрдэнэ гэж ингэж харж байгаа. Өөрөөр хэлбэл бид нарын хувьд санхүүгийн салбар илүү ДНБ-ий хөрөнгийн зах зээл нь бараг 30 орчим хувь, даатгалын салбар нь 30 орчим хувьд хүргэх энэ боломж потенциал Монгол Улсад бол байгаа гэж харж

байгаа. Энэ нь эрх зүйн шинэтгэлийг хийснээр даатгалын салбар өнөөдөр 1 хүрэхгүй хувьтай байгаа. Энэ 5 жилийн хугацаанд гэхэд 10 дахин өсөх энэ боломж байгаа гэдэг ийм судалгааг бол бид нар хийж байгаа. Тэгэхээр нөгөө талдаа даатгалын салбар хөгжсөнөөр эргээд хөрөнгийн зах зээлийн 1 гол урт хугацааны хөрөнгө оруулагчид болно.

Мөн Улсын Их Хурал дээр Хувийн нэмэлт тэтгэврийн сангийн тухай хууль явж байгаа. Энэ хуулийн хүрээнд бас тодорхой урт хугацааны хөрөнгө оруулалтын сангууд бас бий болно гэсэн ийм хүлээлттэй байж байна.

2 дахь асуудлын хувьд хэрэглээний зээлийн өсөлтийг хязгаарлах, өрийн дарамтыг бууруулах, бизнесийн зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, мөн цахим зээлийн давхардлыг арилгах чиглэлээр бас Санхүүгийн зохицуулах хороо 2004, 2005 онуудад бас тодорхой арга хэмжээнүүд аваад явж байгаа. Банк санхүүгийн байгууллагуудын хувьд нөгөө хэрэглээний зээлийн харьцааг үе шаттайгаар 70 хувиас бууруулаад, өнөөдрийн байдлаар 55/45 гэсэн өр, орлогын харьцааг тооцож байгаа. Мөн хэрэглээний зээл болох зээлийн гол бүтээгдэхүүн үйлчилгээний 1 болох автомашин барьцаалсан зээлүүд дээр анх удаа зээл үнэлгээний харьцааг ашигладаг болсон. Өөрөөр хэлбэл Монгол Улсад санхүүгийн банк бусаас өөр энэ харьцааг ашиглаж байгаа газар бол байхгүй гэсэн үг. Өнөөдрийн байдлаар .../минут дуусав/

Л.Соронзонболд: Лувсанжамц гишүүн тодруулж асууя.

Г.Лувсанжамц: Бярлалаа. Энэ хууль, эрх зүйн орчныг сайжруулах ажлуудыг хийгээд явж байгаа 2 хууль өргөн баригдчихсан, хэлэлцэх эсэх нь бас шийдэгдээд явж байгаа. Тэгээд ажлыг нь бол дэмжиж байгаа. Бас 1 асуудал байгаа нь болохоор бид нар нөгөө тогтолцооныхоо хувьд Монголбанкны өр, орлогын харьцаа, Санхүүгийн зохицуулах хороо буюу банк бус санхүүгийн байгууллагуудын, арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллагуудын өр орлогын харьцаа энэ мэдээлэл нь хоорондоо уялдаж байгаа юу. Тэгэхгүй бол банк дээр очоод зээл авчихдаг. Дахиад банк бус дээр очоод энэ харьцаагаараа дахиад зээл авчихдаг. Ийм ажил хийгдэж байгаа болов уу.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 3 номерын микрофоныг нээе.

Н.Хүдэрчулуун: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Би түрүүний хариулт дээр бас амжаагүй учраас нэмээд 2 тоо хэлье гэж бодож байна. Хэрэглээний зээлийг хумих, хязгаарлах бодлого хэрэгжүүлснээр энэ оны хувьд хэрэглээний зээл жилд дунджаар 37,7 хувийн өсөлттэй байсан бол одоогийн байдлаар 8,9 хувь болж энэ хурдыг бууруулсан байж байгаа. Нөгөө талдаа бизнесийн зээлийн дундаж өсөлт 39 хувьтай байдаг бол энэ 2025 онд 56,4 хувьтай болж өсөж байгаа. Тэгэхээр цаашид ч гэсэн бизнесийн зээл нь илүү өсөөд, хэрэглээний зээлийг хумих бодлогыг хэрэгжүүлнэ. Нөгөө талаараа Монгол Улсын мөнгөний бодлогыг барьж байгаа мөнгөний бодлогын энэ арга хэрэгслүүд, Санхүүгийн зохицуулах хорооноос гарч байгаа арга хэрэгслүүд нийцтэй явж ирсэн. Цаашдаа ч гэсэн яг энэ чиглэл хандлагаа бол хадгалаад явна.

Нөгөө талдаа банк дээр тавьж байгаа өр, орлогын харьцаа .../минут дуусав/

Л.Соронзонболд: Лувсанжамц гишүүн тодруулъя.

Г.Лувсанжамц: Тодорхой дэлгэрэнгүй хариулж байгаад баярлалаа. Монголбанкны дата, танай дата 2 тэгвэл хоорондоо уячихсан байгаа юм байна тийм ээ.

Л.Соронзонболд: 3 номер хариулья.

Н.Хүдэрчулуун: Энэ санхүүгийн бүх байгууллагууд зээлийн мэдээллийн санд нэгдсэн байдлаар мэдээллээ нийлүүлэх үүрэгтэй. Өөрөөр хэлбэл банк байна уу, банк бус санхүүгийн байгууллага, Монгол Улсад санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа бүх байгууллагууд Санхүүгийн зохицуулах хороо болон Монголбанкны бүртгэлтэй бүх байгууллагууд зээлийн мэдээллийн сан нь нэгдсэн мэдээллийн санд мэдээллээ бүртгүүлэх үүрэг хүлээж байгаа. Эндээс бүх арилжааны банкнууд болон банк бусууд лавлагаагаа аваад, энэ өр, орлогын харьцаа хэтэрч байгаа эсэх дээр нь өөрийнхөө шалгуурыг тавиад, зээлээ олгоод явж байгаа гэсэн үг.

Монголбанкны зээлийн мэдээллийн сан бодит цагийн горим буюу рийл тайм хэлбэрт жусон гэдэг энэ солонгосын энэ системд шилжиж байгаа. Бидэнд өгч байгаа мэдээллээр бол зээлийн мэдээллийн сан банк санхүүгийн байгууллагуудыг энэ оны 7 сар гэхэд бүрэн рийл тайм системд шилжүүлнэ гэдэг ийм мэдээллийг өгөөд байгаа. Баярлалаа.

Л.Соронзонболд: Батнайрамдал гишүүн асуулт асууя.

О.Батнайрамдал: Та бүхэндээ оройн мэнд хүргэе. Санхүүгийн зах зээл тухайн орны эдийн засгийн хөгжлийн үндсэн моторынх нь 1 байдаг. Яг энэ цаг мөчид бас Монгол Улсын Засгийн газраас Ерөнхий сайд өөрөө санаачлаад яваад байна л даа. Чөлөөлье аян гэж байгаа. Тэгэхээр ер нь Монгол Улсын эдийн засагт хамгийн чөдөр тушаа болж байгаа зүйлүүдийн 1 нь төр өөрөө л дөө. Тэгэхээр ер нь ялангуяа зохицуулалттай салбарууд, ялангуяа зөвшөөрөл олгодог, зөвшөөрлийн хүрээндээ хяналт шалгалт хийдэг салбарууд байгаа юм.

Тэгэхээр уг нь миний асуултууд Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Хяналтын зөвлөл рүү илүү чиглэмээр байгаа юм. Өнөөдөр хяналтын зөвлөлөөс хүн байна уу. Байхгүй байна. Хяналтын зөвлөлийн тайланг харахаар тийм нэг уулзалт зохион байгуулсан байна. Тэгсэн байна. Олон улсын хамтын ажиллагаа ингэсэн байна гээд. Уг нь эндээс миний хувьд юу хүсээд байна вэ гэхээрээ та нарын тайланг дэлгэрэнгүй харлаа л даа. Яах вэ, ингээд бүгдээрээ өсөлттэйгөө явж байна гээд л. Тэгэхээр яг энэ та нараас гарахгүй л дээ. Гэхдээ буцаад энэ зохицуулалттай зах зээл дээр та нарын баталж байгаа дүрэм журам, энэ нь буцаад тухайн салбарт ямар чөдөр тушаа болж байгаа вэ. Яг энэ дээр бол надад хувийн секторуудаас бас гомдлууд ирдэг юм л даа. Яалт ч үгүй би өөрөө санхүүгийн зах зээлд банкир байсан хүн. Мэргэжлийн яг асуудлууд над дээр ирдэг. Тэгэхээр энэ дээр нэг тийм дүгнэлт хийх ёстой гэж бодож байгаа юм. Нэгэнтээ Монгол Улсын Засгийн газраас Ерөнхий сайд өөрөө санаачлаад чөлөөлье гээд нэг ёсондоо төр өөрөө буцаад тухайн салбар эдийн засаг хөгжихөд ямар чөдөр тушаа нь болж байна гэдгээ тодорхойлж байгаа бол энэ санхүүгийн зах зээлийг тойрч гарч ерөөсөө болохгүй ээ. Яах вэ, бид нар өнөөдөр Засгийн газарт харьяалагддаггүй. Улсын Их Хуралд Санхүүгийн зохицуулах хороо шууд харьяалагддаг. Гэхдээ ингэлээ гээд тэр явж байгаа аянаас бол мултарч үлдэж болохгүй гэж би хувьдаа дүгнэж байгаа. Тийм учраас одоо шууд асуумаар байгаа юм. Тэгэхээр яг чөлөөлье гэдэг энэ агуулгын хүрээнд, жишээлбэл буцаад та бүхний гаргаж байгаа дүрэм журам дээр хэр хяналт тавигдсан байдаг юм. Өнөөдөр жишээлбэл Санхүүгийн зохицуулах хорооны даргын тушаалыг харахад

509 тушаал 2025 онд батлагдсанаас хамгийн өндөр нь банк бус дээр, дараагийнх нь бол Хяналт шалгалт зохицуулалтын газраас гаргасан байна. 66 тушаал гаргасан байна. Тэгэхээр яах вэ зохицуулалттай зах зээл. Гэхдээ хяналт шалгалт их байх тусмаа буцаад тэр нь аж ахуйн нэгжид илүү хүндрэл үүсгэж байх вий. Болохгүй бол лицензийг чинь цуцална шүү гэдэг айдас бас тэр чинээгээрээ явж байх вий гэж байгаа. Энэ дээр хийсэн дүгнэлт, судалгаа байна уу. Дүгнэлт, судалгаа байвал яг точный би асуумаар байгаа юм. Энэ бол яг та бүхний хамаарч байгаа бүх салбар дээр яригдана. Хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээл, тэрнээс биш та бүхний тайлан дээр бол бүгд л их сайхан болж байгаа дүр зураг харагдаад байна л даа. Тэгэхээр энэ дээр тайлбар авчхаад нэмэлт асуулт асууя.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 3 номерын микрофоныг нээе.

Н.Хүдэрчулуун: Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Санхүүгийн зохицуулах хороо энэ Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа чөлөөлье аяныг дэмжиж ажиллаж байгаа. Үүний би бас нэг тодорхой жишээг бас танд хэлье гэж бодож байна. Санхүүгийн систем өөрөө уламжлалт санхүүгийн системээс илүү дижитал ухаалаг санхүүгийн систем рүү хөгжиж байна. Өөрөөр хэлбэл бүх зохицуулалтууд нь тодорхой хууль, эрх зүйн зохицуулалтын хүрээнд явагдаж байдаг. Гэтэл энэ технологийн үсрэнгүй хөгжлийн улмаас шинэ технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээл дээр бий болдог. Өөрөөр хэлбэл ямар нэгэн хууль дүрэм, журмаар огт хязгаарлаагүй, хориглоогүй, дээрээс нь зөвшөөрөөгүй. Гэхдээ санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулах боломжит энэ бүтээгдэхүүн үйлчилгээний зохицуулалтыг Санхүүгийн зохицуулах хороо 2021 оноос хэрэгжүүлж эхэлж байгаа. Энэ сендбокс зохицуулалтын орчин нь анх 2016, 2017 онд Англид үүсээд, Монгол Улсад 2021 онд бас энэ зохицуулалтын орчныг бий болгоод явж байгаа. Өөрөөр хэлбэл төр ганцхан зохицуулалт хийдэг салбар биш, илүү зах зээл дээр шинэ тутамд хөгжиж байгаа бүтээгдэхүүн үйлчилгээг төрийн зүгээс дэмжих илүү аюулгүй зах зээл дээр нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор зохицуулалтын сендбокс гэдэг энэ орчныг бүрдүүлээд ажиллаж байгаа.

Монгол Улсын энэ зохицуулалтын сендбоксын орчны нөхцөл байдлыг олон улсын санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн бас Санхүүгийн зохицуулах хороо гишүүнээр ажилладаг. Энэ хүрээнд Ази-Номхон далайн бүсийн энэ Сендбоксын зөвлөлийг Монгол Улсыг бас ахлах саналыг тавиад, Монгол Улс энэ 2027 он хүртэл энэ саналуудыг ахлаад явж байгаа юм. Тэгэхээр бид нар аль болох зах зээл дээр илүү шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ орж ирэхэд энийг аюулгүй, зөв зохистой байдлаараа орж ирэх энэ боломжийг 1 талаас нь хангах үүднээсээ зохицуулалтын орчныг бас харьцангуй амжилттайгаар туршаад явж байна.

Нөгөө талдаа яг энэ төрлийн туршлагыг бас судлах олон улсын бас бусад орнуудаас сайн туршлагыг бас нутагшуулах, нэвтрүүлэх чиглэлээр бас хамтарч ажилла гэсэн цөөнгүй хүсэлтүүд ирдэг гэдгийг бас танд хэлье.

Санхүүгийн зохицуулах хороо дүрэм, журмуудыг цөөлөх, шаардлагатай тохиолдолд тодорхой мэдэгдлийн хүрээнд ч гэсэн үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлэх чиглэлээрээ энэ зөвшөөрлийн хуулийн дагуу ажиллаж байгаа. Өөрөөр хэлбэл 64 байсан нийт хууль, дүрэм журмыг цөөлөөд 36 болгосон байж байгаа. Мөн одоогийн өргөн баригдсан байж байгаа Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орвол тусгай зөвшөөрлийн тоог 33-31, энгийн зөвшөөрлийг 26-16, 9 үйл ажиллагааг зөвхөн мэдэгдээд үйл ажиллагаа эрхэлж болно гэдэг энэ зохицуулалтыг бас хийгээд ажиллаж байгаа.

Л.Соронзонболд: 3 номерын микрофон хариултыг гүйцээе.

Н.Хүдэрчулуун: Санхүүгийн зохицуулах хороо илүү газар дээрх хяналт шалгалт гэдгээс илүү эрсдэлд суурилсан, цаашлаад их өгөгдөлд суурилсан регтек, сабтекийг нэвтрүүлэх чиглэлээр ирэх 5 жилд ажиллана гэсэн төлөвлөгөө гараад ажиллаж байгаа. Өөрөөр хэлбэл бид бүхэн зах зээл дээр болж байгаа сөрөг сигналуудыг зайнаас оношлох боломжуудыг бүрдүүлэх, илүү смарт болно гэсэн ийм зорилт тавиад ажиллаж байгаа гэдгийг бас танд хэлье. Баярлалаа.

Л.Соронзонболд: Батнайрамдал гишүүн тодруулъя.

О.Батнайрамдал: Би хэдэн статистик хэлье л дээ. Хөрөнгийн зах зээл ДНБ-тэй харьцуулах юм бол 15 хувь, даатгалын зах зээл 0,9 хувь, банк бус 10 хувь. Эд нарыг жишээлбэл Казахстантай харьцуулъя л даа. Бид нар Казахстанас энэ чинь хэд дахин бага явж байгаа байхгүй юу. Тэгэхээр ерөөсөө 1 тийм сайн явж байгаа үзүүлэлт гэж би ерөөсөө хувьдаа бол огт дүгнэдэггүй. Монгол Улсад өнөөдөр жишээлбэл зээлийн хүү өндөр байгаагийн 1 шалтгаан хөрөнгийн зах зээл чинь хангалттай хөгжихгүй байгаадаа байгаад байгаа юм. Тэгэхээр энэ чөлөөлье аяны хүрээнд өөрөө тэр binding constraint гэж ярьж байгаа чөдөр тушаа нь өөрсдөө та бүхний гаргаж байгаа тэр дүрэм журмууд байх байх вий. Энэ дээр хийсэн анализ дүгнэлтүүд байдаг уу. Хяналтын зөвлөл энэ дээр ямар нэгэн шийдлүүд гаргасан зүйл байдаг уу гэж асууж байгаа юм. Тэгэхээр ер нь одоо Засгийн газар хийж байгаа бол хөрөнгийн зах зээл орхигдож ерөөсөө болохгүй юм. Тийм учраас энэ дээр яг асуугаад байна л даа. Хийгдэж байгаа яг тийм үнэлгээ, дүгнэлт байна уу. Хэрвээ байхгүй бол хийгдэх ёстой.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн хэддүгээр микрофон юм. 3.

Н.Хүдэрчулуун: Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын зөвлөл дээр бол яг энэ чиглэлийн дүгнэлт, мэдээлэл гарсан зүйл одоогоор бол байхгүй. Гэхдээ Хууль зүйн сайдын 3 сарын 12-ны бичгээр энэ хяналт шинжилгээ хийж байгаа процесстoo үнэлэлт дүгнэлт хий гэсэн ийм үүрэг, чиглэл өгөгдсөн байж байгаа. Энэ хүрээндээ бас ажлын хэсэг гараад ажиллаж байгаа гэдгийг бас танд хэлье.

Л.Соронзонболд: Батнайрамдал гишүүн тодруулъя.

О.Батнайрамдал: Тэгэхээр яах вэ, өсөөд явж байгааг би харж байгаа л даа. ДНБ-тэй харьцуулахад хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ өсөөд явж байгаа. Гэхдээ энэ өсөлт чинь буцаад эдийн засгийнхаа өсөлттэй харьцуулах юм бол бусад орны жишээтэй харьцуулах юм бол хангалттай биш байхгүй юу. Тэгэхээр та бүхэн салбарынхаа, тэгэхээр binding constraint-ыг олох хэрэгтэй. Яг өсөхгүй байгаа эсвэл хангалттай тэр өсөлтийг авч ирж чадахгүй байгаа үндсэн шалтгаан тэр чөдөр тушаа нь юу вэ. Тэгэхээр энэ дээр би асууя. Хамгийн хангалттай өсөхгүй байгаа 3 үндсэн шалтгааныг та яг юу гэж үздэг юм. Энэ дээр бас ямар арга хэмжээнүүд авсан юм.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 3 номерын микрофоныг нээе.

Н.Хүдэрчулуун: 2020 он энэ салбарууд нийтдээ ДНБ-ий энэ 4 салбар 13 хувьтай л тэнцэх хэмжээний ийм эдийн засаг байсан. Өнөөдрийн байдлаар 26 хувьд хүрсэн байна. Энэ нь 2 дахин өссөн. Нөгөө талдаа ДНБ ч гэсэн Монгол Улсын 2020 онтой харьцуулахад ДНБ-ий өсөлт энэ зах зээлүүд дээр гарч байгаа өсөлтүүд 2 дахин илүү хурдтай өссөн гэдгийг бас илтгэж байгаа үзүүлэлт. Мэдээж энэ өсөлтийг

илүү тогтвортой, урт хугацаанд илүү өргөн өсөлтийг хангах чиглэлээр бол Санхүүгийн зохицуулах хороо тодорхой ажлуудыг төлөвлөөд ажиллаж байна .../минут дуусав/

Л.Соронзонболд: 3 номерын микрофон хариултаа гүйцээе.

Н.Хүдэрчулуун: Мэдээж Казахстантай харьцуулахад гишүүний хэлж байгаа шиг яг Монгол Улсын энэ өсөлтийн хувь хэмжээ бол хангалттай биш байгаа нь үнэн. Гэхдээ бид нар нөгөө гаднын хөрөнгө оруулалтыг оруулж ирэх, нөгөө талдаа мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бэлдэх шаардлага зайлшгүй хэрэгтэй байхгаа. Тэгээд эд нарын мэргэжлийн хөрөнгө оруулалтыг бэлтгэх нэг үндсэн салбар бол даатгалын салбар гэж Санхүүгийн зохицуулах хороо харж байгаа юм. Өөрөөр хэлбэл даатгалын салбарын эрх зүйн шинэтгэлүүд хийгдэж байж эдгээр тэтгэврийн, хувийн сангийн, нэмэлт тэтгэврийн энэ хуулиуд батлагдаж байж урт хугацааны хөрөнгө оруулалт хийх энэ мэргэжлийн сангууд бий болоод, энэ өсөлт илүү эрчимтэй эдийн засаг дахь санхүүгийн салбарт эргэх энэ мөнгөний эргэлт илүү үр ашигтай эргэснээр илүү хурдан, илүү тогтвортой өсөх энэ боломж бүрдэнэ гэж харж байгаа. Энэ үүднээсээ Монгол Улсад тогтвортой санхүүгийн систем өөрөө эрүүл зөв бүрдэх .../минут дуусав/

Л.Соронзонболд: Миний хувьд 2 асуулт асууя гэж бодож байна. Өнөөдөр бол банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн жингэнэсэн дундаж хүү бол арилжааны банкнуудтай харьцуулахад маш өндөр байна. Бараг л ломбардтай адил хэмжээнд байна гэж ард иргэд их шүүмжилж байгаа. Энэ ингээд яагаад ийм байна гээд харахаар Санхүүгийн зохицуулах хорооноос сүүлийн жилүүдэд банк бус санхүүгийн байгууллагуудын дүрмийн санг жил болгон тодорхой төлөвлөгөөтэйгөөр нэмэх ийм шаардлагууд тавьж байгаа юм байна. Тэгэхээр дүрмийн сангаа нэмэхийн тулд нөгөө компани чинь ашигтай ажиллах ёстой байдаг. Ашигтай ажиллахын тулд яах вэ гэхээр зээлийн хүүгээ нэмнэ. Тэгэхээр бидний нөгөө зээлийн хүүгээ бууруулъя гээд байгаа бодлоготой та бүхний энэ гаргаад байгаа дүрмийн санг нэмэх бодлого чинь зөрчилдөөд байгаа юм биш үү. Энэ дээр нэг асуу хариул авъя.

2 дугаарт сая танай Санхүүгийн зохицуулах хорооны гүйцэтгэлийн аудитыг харахаар гүйцэтгэл бол ерөнхийдөө нэлээн сайн гарсан байна гэж байгаа юм. Төлөвлөгөөний гүйцэтгэл. Гэхдээ илүү үйл ажиллагаанд тулгуурласан гүйцэтгэлийн төлөвлөгөө тавьсан байна. Тийм учраас энэ гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө илүү хэмжих дээрээ үр дүнд суурилсан байхаар гаргах хэрэгтэй байна гэсэн ийм саналыг гаргасан байна. Тэгэхээр аудитын энэ саналын дагуу та бүхэн юу хийхээр төлөвлөж байна вэ. 3 номерын микрофоныг нээе.

Н.Хүдэрчулуун: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. ББСБ-ын дүрмийн санг үе шаттай нэмэгдүүлэх шийдвэр 2020 оноос эхлээд хэрэгжиж байгаа. Энэ өмнө ч гэсэн бас хэрэгжүүлсэн, хэрэгжиж байсан бодлогын арга хэмжээ. Өөрөөр хэлбэл Санхүүгийн зохицуулах хорооноос илүү эрсдэлээ даахуйц, эрсдэл бэхжиж мэргэжлийн институт болсноор зардлыг бууруулж, эргээд зээлийн хүүг бууруулах боломжтой гэдэг энэ судалгааг бас тухайн үед хийж байсан. Өөрөөр хэлбэл өргөжилтийн үр өгөөжөөр илүү зардал буураад, зээлийн хүү буурах боломжтой гэдэг энэ дүгнэлт хийгдээд энэ дүрмийн санг үе шаттай нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байсан. Энэ арга хэмжээ хэрэгжсэнээр 2021, 2022 онуудад бол зээлийн хүү бид нарын төлөвлөж байсан хувь хэмжээгээр буурсан үр дүнтэй байж байсан. Ковид цар тахлын нөлөөгөөр бас тодорхой шокийн нөлөөллүүдээс болоод

эдийн засагт бас тодорхойгүй нөхцөл байдлын улмаас энэ нөхцөл байдал бас алдагдсан. Эргээд энэ олон улсад болж байгаа геополитикийн нөхцөл байдал, бусад гадаад шокуудын нөлөөллөөс хамаараад энэ дээр бас зээлийн хүү төлөвлөсөн хувь хэмжээнээс буурахгүй болж ирсэн ийм тохиолдлууд байж байгаа.

Санхүүгийн зохицуулах хорооноос энэ 2024, 2025 онуудад хэрэглээний зээлийг хязгаарлах, бизнесийн зээлийг тэлэх, мөн зээлийн давхардлыг бууруулах, иргэдийн өрийн дарамтаас сэргийлэх бодлогыг авч хэрэгжүүлж байгаа юм. Мөн Монгол Улсын Их Хурлаас 79 болон 124 дүгээр тогтоолуудаар бас тодорхой үүрэг даалгаврууд өгөгдсөн. Энэ хүрээнд авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэрэгслүүд бас бид нарын харж байгаагаар бол бас байндаа хүрч байна. Хэрэглээний зээл бол дунд хугацаандаа буурах, багасах ийм төлөвтэй байна. Хурдыг бол ямар ч байсан өсөлтийн хурдыг сааруулж чадлаа. Цаашдаа бол ер нь буурах хандлагатай байна. Бизнесийн зээлд эзлэх хувь хэмжээ бол тэр хэрээрээ нэмэгдэх боломжтой гэсэн ийм дүгнэлтийг бол хийж байна.

Тэр аудитын хийгдсэн дүгнэлтийн хүрээнд мэдээж Монгол Улсын аудитаас хийж байгаа дүгнэлтийг Санхүүгийн зохицуулах хороо дээр ажлын хэсэг байгуулагдаад тэр чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөгөөнүүд бол бэлтгэгдээд явж байгаа гэдгийг бас танд хэлье.

Л.Соронзонболд: Гишүүд асуулт асууж дууслаа. Тайлантай холбогдуулж үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Батнайрамдал гишүүнээр тасаллаа. Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Эдгээр асуултыг асуугаад байгаа юм. Тэгэхээр ер нь эдийн засгийн өсөлт хүссэн, хүсээгүй, та нар нэг их олон шалгалт явуулсан, явуулаагүй санхүүгийн зах зээлээ тэлж байдаг. Тэгэхдээ бидний өнөөдөр санхүүгийн зах зээлийн тэлсэн энэ байдлыг бид нар олон улсын жишигтэй харьцуулахгүйгээр Монгол Улс хаана яваагаа тодорхойлж болохгүй байхгүй юу. Өнөөдөр ингээд өсөлт үзүүлээд байгаа чинь яг үнэндээ хэлэхэд их тийм мундаг журам, дүрэм баталсандаа биш. Энэ чинь эдийн засгийн өсөлтөө дагаж гарч ирж байгаа өсөлт шүү дээ. Тэгээд цаад утгаараа зээлийн хүү өнөөдөр хүртэл бас боомилгоч хүчин зүйл байсаар байгаа.

Даатгалын зах зээлийг аваад үзье. ДНБ-ий 0.9 хувь шүү дээ. Энэ бол ер нь хөгжиж байгаа орнуудын бараг хамгийн муу нь байх. Тэгэхээр энэ дээр би юу гэж дүгнэлт хэлэх гээд байна вэ гэхээрээ тэр том хөрөнгө оруулагч орж ирэхгүй болохоор ингээд байгаа юм гэдэг асуудал яриад байна л даа. Энэ тахиа анхдагч уу, өндөг анхдагч уу л гэдэгтэй ялгаагүй л дээ. Гэхдээ тэд нар орж ирэхгүй болохоор энэ хөрөнгийн зах зээл чинь тэлэхгүй байгаа юм гэж хэлж болохгүй байхгүй юу. Тэд нарыг дотоодын зах зээлдээ үүсээд бий болж байгаа тэд нарыг та нар хэр дэмжиж байгаа вэ гэдгийг чинь л асуугаад байгаа юм. Тэд нарыг томоохон хөрөнгө оруулалтын сангууд бий болоход боомилгоч хүчин зүйл нь бид нарын гаргаж байгаа, баталж байгаа дүрэм журам биш биз дээ гэдэг асуултыг тавиадад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр би хангалттай хариулт авсангүй. Уг нь Хяналтын зөвлөл энэ асуултад хариултыг бас өгч байх ёстой юм л даа. Өнөөдөр хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны 2025 оны тайланг харсан чинь 24 хуудас ийм уулзалтууд хийв гэсэн. Энд ерөөсөө хяналт хийгдээгүй байна шүү дээ. Тэгэхээр яах вэ, би та нараас өөрөө өөрийгөө хяна гэлтэй биш. Уг нь хяналтын зөвлөл 1 дүгээрт хийх ёстой.

2 дугаарт нэгэнтээ Монгол Улсын Засгийн газар гүйцэтгэх удирдлагатай, гүйцэтгэх засаглал хэрвээ төр өөрөө хязгаарлагч хүчин зүйл нь юм гээд алхам хийж байгаа бол төрийн зохицуулалтаа хөрөнгийн зах зээл бас яг энэ алхмыг хийх л ёстой байхгүй юу. Тэгэхээр яах вэ, та нар харьяаллаараа Улсын Их Хурал дээр харьяалагдаад байгаа учраас Засгийн газрын харьяалалд байхгүй учраас тэндээс хоцроод байна гэж би хараад байгаа юм. Тэгэхээр энэ бол параллель явах ёстой. Тэрнээс биш хөрөнгийн зах зээл ганцаархнаа чөлөөлөх аян эсвэл чөлөөлөлт хийгдэхгүй үлдэнэ гэж би бол хувьдаа итгэхгүй байна. Та нар ч үүнтэй санал нэгдэх байх гэж бодож байгаа. Тийм учраас энэ дээр ямар нэгэн арга хэмжээ миний хувьд бол заавал авагдах ёстой гэж бодож байна.

Санхүүгийн зах зээлийг ярихгүйгээр Монгол Улсын дараагийн 20 жилийн, 10 жилийн, 5 жилийн эдийн засгийн өсөлтийг ярих боломжгүй байхгүй юу. Өнөөдөр санхүүгийн зах зээлийг аваад үзэх юм бол 5 арилжааны банк хэт давамгайлчихсан. Энэ чинь өөрөө төрөлжихгүй болохоор хүү буурна гэж байхгүй шүү дээ. Энэ чинь өөрөө өрсөлдөөн сайжрахгүй болохоор хүү буурна гэж байхгүй шүү дээ. Тэгээд бусад олон улсын жишиг та нарын тайлан дотор ерөөсөө алга. Олон улсын жишиг оруул. Гаргаж ирж байгаа үзүүлэлт болгоноо Монгол Улстай харьцуулж болох 5 орны жишигтэй харахгүй болохоор та нар яг хөмөрсөн тогоон дотроо л хараад байгаа байхгүй юу. Үйл ажиллагааны тайлан гээд. Үйл ажиллагааны тайлан чинь хэр явж байгаа гэдгээр бид нар ядаж Ази-Номхон далайн орнууд дотроо бид нар харьцуулж харахгүйгээр харахгүй шүү дээ. Тэгэхээр ийм нэгэнтээ гоё тайлан хийгээд өнгөтөөр гаргаад ингээд ном болгож байгаа бол энийгээ гүйцэд хийх хэрэгтэй. 1 дүгээрт.

2 дугаарт бас энэ Эдийн засгийн байнгын хорооноос санаачлах ёстой юу. Ямар нэгэн тийм. чөлөөлье аяны хүрээнд ч гэсэн энэ дотор бас нэгэнтээ лиценз олгодог байгууллага учраас хийх л хэрэгтэй .../минут дуусав/

Л.Соронзонболд: Санхүүгийн зохицуулах хорооны тайлан танилцуулахдаа Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын зөвлөлөөс төлөөлөл цаашдаа оролцуулдаг байх дээр анхаарах хэрэгтэй юм байна.

Би түрүүн хэлсэн ББСБ-ын дүрмийн санг тодорхой хугацаанд нэмээд даалгавар аваад явахад үр дүн гарч байжээ. Гэхдээ өнөөдрийн бас цаг хугацаанд тэр өмнө нь гаргасан шийдвэр чинь бас хэрэгжихгүй байх боломжтой. Тийм учраас бас тэр бодлогоо эргэж харах ёстой байх гэж бодож байгаа. Яагаад тэгж байна вэ гэхээр зүгээр зээл олгодог үйл ажиллагаа явуулдаг ББСБ-ын дүрмийн сан 2,5 тэрбум төгрөг байж байгаад 5 тэрбум төгрөг болж байгаа юм. Итгэлцлийн үйл ажиллагаа явуулдаг ББСБ-ын дүрмийн сан 5-10 тэрбум төгрөг. Ингээд 2 дахин өсөж байгаа байхгүй юу. Тэгэнгүүт одоо жишээлбэл танай банк бус санхүүгийн байгууллагуудын чинь жингэнэсэн дундаж зээлийн хүү нь 36-50 хувь байлаа гэж бодоход нөгөө хүн чинь тэр дүрмийн санг нэмэхийн тулд 2 жил зарцуулах гээд байна шүү дээ. Тэгээд тэрийгээ хурдан хийхийн тулд яах вэ гэхээр ашгаараа хийхийн тулд хүүгээ нэмж л ашгаа нэмэхээс өөр аргагүй болж байгаа байхгүй юу. Тэгэхээр өөрөөр хэлбэл та бүхний өмнө гаргасан бодлого чинь тухайн үедээ зөв байсан байж магадгүй. Өнөөдрийн цаг хугацаанд эргээд харахаар зээлийн хүүг өсгөх ийм хүчин зүйл болоод байгаа юм биш биз дээ гэдгийг эргэж харах ёстой байх гэж бодож байна.

Ингээд Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны үйл ажиллагааны тайлантай холбогдуулж гишүүд үг хэлж дууслаа. Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж дууслаа. Ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа.

19.13 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Үндэсний статистикийн хорооны 2025 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж эхэлье.

Тайлангийн танилцуулгыг Үндэсний статистикийн хорооны дарга Батдаваа хийнэ. 4 номерын микрофоныг нээнэ үү.

Б.Батдаваа: Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Үндэсний статистикийн хорооны 2025 оны үйл ажиллагааны тайланг товч танилцуулъя.

Бид өнгөрсөн онд албан ёсны статистикийн 6 бүлгийн 859 статистик үзүүлэлтийг тогтмол давтамжтай боловсруулан мэдээлж, 2 тооллого, 9 түүвэр судалгааг зохион байгууллаа. Бид албан ёсны статистикийг өгөгдлийн шинжлэх ухаанд суурилан хөгжүүлэх, статистикийн хэрэглэгчээс ирж буй санал шүүмжлэлийн дагуу үйл ажиллагаагаа сайжруулах зорилгоор Статистикт дата интеграц буюу өгөгдлийн нэгтгэл, хиймэл оюун нэвтрүүлэх, статистикийн мэдээллийн чанар, найдвартай байдал, нууцлалыг хангах, чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгоход анхаарч ажиллалаа. Ингээд 2025 оны онцлох ажлуудаас товч танилцуулъя.

Бид өнгөрсөн онд төрийн 15 байгууллагын 30 суурь болон төрөлжсөн мэдээллийн санг ашиглан нэгдсэн мэдээллийн сан үүсгэх замаар хүн ам, орон сууцын 2025 оны завсрын тооллогыг зохион байгууллаа. Үүний үр дүнд 10 жил болон 5 жил тутам зохион байгуулдаг хүн ам, орон сууцын тооллого, 5 жил тутам зохион байгуулдаг аж ахуйн нэгжийн тооллогыг хумигдмал үзүүлэлтээр жил бүр зохион байгуулах системийг хөгжүүлж Монгол Улсын хүн ам, нийгэм, эдийн засгийн нэгдсэн өгөгдлийг төрийн болон хувийн хэвшлийн бодлогын шийдвэр гаргалтад ашиглах боломжийг нэмэгдүүллээ.

2 дугаарт статистикийн үйл ажиллагаанд хиймэл оюун, машин сургалтыг ашиглахад анхаарч ажиллалаа. Тухайлбал бид ЭЗХАХБ-ын дэргэдэх Парис 21 байгууллага болон Гүүгл компанийн Гүүгл сангийн дэмжлэгтэйгээр Монгол Улсад статистикийн системийн хиймэл оюуны бэлэн байдлыг хангах төслийг эхлүүллээ.

Мөн Google open buildings төслийн өгөгдөл ашиглан байшин орон сууцын тоог боловсруулах, мал тооллогод машин сургалт, хиймэл оюун ашиглах загварыг хөгжүүлж, туршиж эхэллээ.

3 дугаарт Үндэсний статистикийн хороо нь мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, олон улсын стандартыг 2024 онд үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн нь мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэхэд ахиц гарсан ажил байсан.

Тэгвэл 2025 онд бид энэхүү эрсдэлийн удирдлагын тогтолцооны стандартын магадлах аудитыг хийлгэлээ. Энэ нь мэдээллийн аюулгүй байдлыг статистикийн байгууллагын соёл, өдөр тутмын үйл ажиллагааны дадал болгон нутагшуулахад анхаарч буй ажил юм.

4 дүгээрт хэрэглэгчдэд статистик мэдээллийг голлон хүргэдэг статистикийн нэгдсэн мэдээллийн сан буюу 1212.mn цахим хуудсыг нээлттэй эх үүсвэрийн шийдлийг ашиглан дотоод нөөцөөрөө бүрэн шинэчиллээ. Үүний үр дүнд, Статистикийн мэдээлэл тархаалтын систем хөндлөнгийн хөгжүүлэгч байгууллагаас хараат бус болж, мэдээлэл авах хурд, найдвартай байдал нэмэгдсэн.

5 дугаарт Үндэсний статистикийн хороо, Харилцаа холбооны зохицуулах хороо болон Мобиком корпорац хамтран гар утасны өгөгдлийг албан ёсны статистикт ашиглах боломжийг турших хамтын ажиллагааг Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр эхлүүллээ. Энэ нь хүн амын шилжилт хөдөлгөөн, аялал жуулчлал, харилцаа холбоо салбарын статистикийг гар утасны өгөгдөл ашиглан боловсруулах боломжийг бий болгох юм. Энэхүү гар утасны өгөгдлийг ашиглан дотоод шилжилт хөдөлгөөн, аялал жуулчлалын статистикийн эхний үр дүн энэ 3 дугаар улиралд гарах болно.

6 дугаарт тооллого, судалгаа, захиргааны мэдээллийн задгай өгөгдөлд ажиллаж, дүн шинжилгээ хийх дата лабораторийг шинээр нэвтрүүллээ. Энэхүү өгөгдлийн лаборатори нь мэдээллийн аюулгүй байдлын стандартыг хангасан тусгай орчинд судалгаа шинжилгээ хийх боломжийг статистикийн байгууллагын ажилтнууд судлаачид болон шинжээчдэд олгож байгаагаараа онцлог юм.

7 дугаарт эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг тухай бүрд тусгах, ДНБ-ийг хэлхээ индекс ашиглан зэрэгцүүлэх үнээр тооцох аргачлалыг өнгөрсөн онд баталж ДНБ-ий 2019-өөс 2024 оны улирал, жилийн гүйцэтгэлийг хэлхээ индексийн аргаар тооцлоо. Түүнчлэн нөөц ашиглалтын хүснэгт, салбар хоорондын тэнцлийг 2024 оны гүйцэтгэлээр байгуулах судалгаа, хувиараа хөдөлмөр эрхлэлтийн судалгааг зохион байгуулж, нөөц ашиглалтын хүснэгт, салбар хоорондын тэнцэл байгуулах үндсэн мэдээллийг бүрдүүлж, эдийн засгийн салбаруудын хоорондын уялдааг харуулах мэдээллийг шинэчиллээ.

8 дугаарт Статистикийн байгууллагын гадаад дахь хамтын ажиллагааг бэхжүүлэх ажлын үр дүнд 2025 онд НҮБ-ын Ази-Номхон далайн орнуудын Статистикийн институцийн удирдах зөвлөлийн гишүүн, 2026 онд Олон улсын ертгийн зэрэгцүүлэлтийн хөтөлбөрийн удирдах зөвлөл, НҮБ-ын статистикийн комиссын гишүүнээр сонгогдлоо.

Өнгөрсөн онд бид статистик мэдээллийг 7 хоног, 15 хоног, сар, улирал, хагас жил, жилийн давтамжтай боловсруулж, сарын танилцуулга, сэдэвчилсэн судалгаа эмхэтгэл хэлбэрээр олон нийтэд хүргэлээ. Статистикийн мэдээлэл цуглуулалтад бид шууд 34 мянган аж ахуйн нэгж, байгууллага, 30.1 мянган өрхөөс тогтмол мэдээлэл цуглуулж, нэгтгэн боловсрууллаа. Үүнээс гадна дотоодын жуулчдын түүвэр судалгааг улсын хэмжээнд анх удаа олон улсын нийтлэг арга зүйд тулгуурлан зохион байгууллаа. Ажиллах хүчний судалгаа болон өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаанд өндөр давтамжтай чанарын хяналтын систем нэвтрүүлснээр судалгааны өгөгдлийг богино хугацаанд хянах, мэдээллийн чанарыг сайжруулах боломжийг бүрдүүллээ.

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын статистикийн систем нь мэдээллийн хамрах хүрээ нээлттэй байдлын үнэлгээгээр дэлхийд 11 дүгээр байрт, Зүүн Азид 2 дугаар байрт, Дэлхийн банкны гүйцэтгэлийн үнэлгээгээр Зүүн Ази, Өмнөд Ази, Номхон далайн орнуудаас 7 дугаар байранд, дэлхийд 47 дугаар байранд орж, 5 байраар урагшиллаа.

Бид статистик мэдээллийн чанарыг үнэлэх, мэдээллийн үйлчилгээг сайжруулах, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага, цаашдын чиг хандлагыг тодорхойлох зорилгоор хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг 2026 оны 1 дүгээр сард дахин зохион байгуулсан. Судалгаанд хамрагдсан мэдээлэл тогтмол хэрэглэдэг хэрэглэгчдийн 64 хувь нь статистик мэдээлэлд зайлшгүй чухал ач холбогдолтой гэж үздэг бөгөөд мэдээллийн чанарыг 63 хувь нь сайн болон маш сайн, 28 хувь нь дунд, 6,5 хувь нь муу гэж бичсэн байна.

Судалгаанд хамрагдсан хэрэглэгчдээс статистик мэдээллийг илүү нарийвчлалтай, хугацааны хоцрогдолгүй мэдээлэх, мэдээллийн чанарыг сайжруулах, статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn цахим хуудсыг сайжруулах зэрэг санал хүсэлт илэрхийлсэн. Харин олон улсын байгууллагуудын үнэлгээ нь мэдээллийн дэд бүтцийг сайжруулахад анхаарах шаардлагатайг илэрхийлж байна.

Бид 2026 онд дээрх үнэлгээнд суурилан дараах томоохон ажлуудад төвлөрч ажиллана.

1 дүгээрт өгөгдлийн засаглалыг бэхжүүлэх зорилгоор байгууллагын хэмжээний өгөгдлийн засаглалын жишиг тогтолцоо, бодлого, дүрмийг боловсруулж нэвтрүүлэн төрийн бусад байгууллагуудад хуулбарлан хэрэгжүүлэх эхлэлийг тавихаар зорьж байна. Ингэснээр төрийн байгууллагуудын мэдээллийн сангийн чанар сайжрах, өгөгдлийг эргэлтэд оруулахад ахиц гарах юм.

2 дугаарт Монгол Улсын нийгэм, эдийн засгийн дэлгэрэнгүй, нэгдмэл үзүүлэлтийг засаг захиргааны бүх нэгжийн түвшинд гарах тооллогын нэгдсэн системийг аж ахуйн нэгжийн тооллого буюу эдийн засгийн тооллогоор баяжуулж, тооллого судалгааны задгай өгөгдлийг ашиглах, өгөгдлийн лабораторийг эхний ээлжид төрийн байгууллагуудад ашиглуулж эхлэхээр төлөвлөж байна.

3 дугаарт статистикийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд уламжлалт бус эх үүсвэр болох хиймэл дагуулын зураг, дүрс танилт, гар утасны өгөгдөл болон цахим хуудасны мэдээлэл ашиглах ажлыг эрчимжүүлж, хиймэл оюун, машин сургалтын бэлэн байдлыг хангахад анхаарч ажиллана.

4 дүгээрт олон улсын статистикийн бодлого боловсруулах үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, шинэ стандарт, аргачлал боловсруулахад хувь нэмэр оруулах, үндэсний статистикийн системийг олон улсын сайн жишигтэй уялдуулан хөгжүүлэхэд анхаарна.

Эцэст нь бид статистикийн мэдээллийн хүртээмж, чанарыг олон улсын болон дотоодын хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээний үр дүнд үндэслэн сайжруулах, байгууллагын өгөгдлийн чадавх болон засаглалыг сайжруулахад анхаарч ажиллах болно.

Анхаарал хандуулсан Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд та бүхэнд баярлалаа.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийг танилцуулъя. Батдаваа Үндэсний статистикийн хорооны дарга, Лхамсүрэн Үндэсний статистикийн хорооны Дэд дарга, Лхагва Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын дарга, Тэгшжаргал Нэгдсэн статистикийн газрын дарга, Оюунжаргал Эдийн засгийн статистикийн газрын дарга, Даваажаргал Нийгмийн статистикийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ариунболд Өгөгдлийн бодлого, бүртгэл, статистикийн газрын дарга, Мандахзориг Өгөгдлийн бодлого статистикийн бүртгэлийн газрын Статистикийн бүртгэл тооллогын хэлтсийн дарга, Эрдэнэмөнх Мэдээллийн технологи, өгөгдлийн инженерчлэлийн газрын дарга, Мөнхбаяр Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга, Оюунгэрэл Тамгын газрын Захиргаа, хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Мягмарханд Эдийн засгийн статистикийн газрын Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэлийн статистикийн хэлтсийн дарга, Ундрал Нийгмийн статистикийн газрын Өрхөд суурилсан судалгааны хэлтсийн дарга.

Үндэсний статистикийн хорооны 2025 оны үйл ажиллагааны тайлангийн танилцуулгатай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Пунсалмаа гишүүнээр тасаллаа. Лувсанжамц гишүүн асуулт асууя.

Г.Лувсанжамц: Үндэсний статистикийн хорооны хамт олонд баярлалаа. Олон улсын индексээр ашиглаад хамгийн өндөр үнэлгээ авч байгаа төрийн байгууллага бараг Үндэсний статистикийн хороо байх. Бусад байгууллагууд маань ийм өндөр үнэлгээг авч байгаа бол мэдэхгүй юм байна. Open data watch-аар та хэд минь дэлхийд 11 дүгээрт орсон. Энэ маш өндөр амжилт гэж бодож байна. Цаашдаа ч гэсэн энийгээ хадгалж явахыг хүсэж байна.

Ганцхан асуулт байна. Та бүхний тайлангийн 19 дүгээр хуудасны баруун доод талд цахим хуудас ашиглалт гээд орон сууцын үнэ, түрээсийн үнийг зар мэдээллийн цахим хуудасны 3500 зар мэдээллээс цахим хуудас шүүрэх аргаар гаргадаг гэж байгаа. 1212.mn мэдээллийг нэлээн ашигладаг. Гэхдээ энэ дээр яг сар болгоноор түрээсийн үнэ нь бол одоогоор ороогүй байгаа гэж ойлгож байна. Энийг оруулах төлөвлөгөө байгаа болов уу. Тэгээд Улаанбаатар хотын орон сууцын үнийн хувьд метр квадратаар нь Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэг, гэхдээ Дархан, Эрдэнэт хот 2 бол арай ороогүй байх шиг байгаа юм. Энэ зүйлүүд дээр та бүхэн маань цаашдаа энэ цахим хуудаснууд дээр байгаа мэдээллийг ашиглаад бас ажиллаж болохоор зүйлээ орон нутаг руу өргөжүүлэх төлөвлөгөөтэй байгаа болов уу.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 4 номерын микрофоныг нээе.

Б.Батдаваа: Эрхэм гишүүн Лувсанжамцын асуултад хариулъя. Бид веб скрабын буюу цахим хуудас шүүж, орон сууцын үнийн индекс боловсруулах арга руу 2022 оноос шилжсэн байгаа. Урьд нь бол мэдээлэл цуглуулалтад бол дүүрэг болон орон нутгийн статистикийн хэлтсээр дамжуулаад, үл хөдлөх хөрөнгийн компаниудаас утсаар болон цаасаар мэдээлэх замаар бол явуулдаг байсан. Сардаа тухайн үед бол хамралт бол 100 гаруй аж ахуйн нэгжээс хамруулдаг байсан. 2022 оноос хойш бид веб скрабын буюу цахим хуудас шүүх арга руу нэвтэрснээр бол нийтдээ 8000 хүртэлх зараас шүүгээд, хэд хоног аргаар буюу тухайн орон сууцын хэдэн давхарт байдаг байршил, цонхны тоо, метр квадрат гээд энэ хүчин зүйлийг оруулсан үнийн индексийг тооцож байгаа. Одоогоор үнийн индекс маань бол зөвхөн Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэг дээр шинэ, хуучин орон сууц дээр бол тооцогдож байгаа.

Шалтгаан нь бид яагаад орон нутгийг одоо хүртэл оруулаагүй байгаа вэ гэхээрээ орон нутаг дээр явж байгаа зар маань нөгөө ажиглалтын тоо хэт бага байгаад байгаа. Өөрөөр хэлбэл энэ маань нөгөө зах зээлийн бодит мэдээллийг төлөөлөх буюу статистикийн чанарын шаардлага дээр нийцэхгүй байгаа учраас бид нар бас ингээд хүлээлтийн байдалтай байна. Магадгүй ирэх жилүүдэд энэ үл хөдлөхийн зах зээл тэлэх юм бол томоохон хот болох Дархан, Эрдэнэтээс бол тэлэх бололцоотой байх. Яг одоо бол зах зээлийн мэдээллийн ажиглалтын тоо бол чанарын шаардлагад бол хүрэхгүй байгаа.

Түрээсийн орон сууцын хувьд бол бид өнгөрсөн оны сүүлээс эхлээд туршилтын байдлаар тооцоод, одоо бид орон сууцын үнэтэйгээ хамтатгаад 1 өрөө байр, 2 өрөө байр, 3 өрөө байрны түрээсийг зарлаад явж байгаа. Бид нар энэ туршилтын тооцоогоо бас Арга зүйн байнгын зөвлөл гээд Үндэсний статистикийн хорооны хараат бус зөвлөлөөрөө оруулаад, үр дүнгийн, чанарын шаардлага хангаад ирэх юм бол албан ёсны статистик болоод 12126.mn дээрээ зарлаад явахаар төлөвлөөд ажиллаж байгаа.

Л.Соронзонболд: Лувсанжамц гишүүн тодруулъя.

Г.Лувсанжамц: Баярлалаа. Ийм дэвшилтэт технологи цахимжилт зүйлийг өгөгдлийг нь цуглуулаад, тэрийг нь ашиглаад гаргадаг олон улсын жишгийг нэн даруй хэрэгжүүлээд, нэвтрүүлээд явж байгаад нь бол баяртай байна. Ялангуяа ийм орон сууцын үнэ метр квадратаараа бас байршлаараа, хэдэн давхарт гэдгээр нь бас байгаа гэдэг энэ дата өгөгдөл бол яг хот төлөвлөлтийн салбарт бол маш хэрэгтэй мэдээлэл байдаг. Тэгэхээр Улаанбаатар хотын хэмжээнд бол төвийн 6 дүүргээрээ ядаж хаана, ямар бүтээн байгуулалт, дэд бүтцийн ажлыг хэрэгжүүлэх юм бол иргэдийн өмчийн үнэлгээ өсөх вэ ч юм уу тийм зүйлүүд нь гарах болов уу гэж бодож байна. Тэгээд энэ зүгээр санал шүү. Та хэд маань бас бодолцож үзээрэй гэж бодож байна.

Газрын үнэ болон газрын түрээс ч байдаг юм уу тийм зүйлийг яг иргэний өрхийн зорилгоор ашиглаж байгаа тийм дата мэдээллүүд байвал бас илүү их хэрэг болдог мэдээлэл болов уу гэж бодож байна. Тэгээд мэдээж нөгөө өгөгдөл маань хэр их байгаагаас хамаарах учраас тэрийг бас та бүхэн маань бодолцож үзээрэй гэж бодож байна. Тэгээд та бүхний ажилд амжилт хүсье.

Л.Соронзонболд: Санал хэллээ. Пунсалмаа гишүүн асуулт асууя.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу. Энэ өдрийн мэндийг хүргэе. Үндэсний статистикийн хорооны 2025 оны тайлан сонсож байна. 2 асуулт байна.

Бид нар энэ инфляцаа ер нь яаж тооцож байна танай Статистикийн газар. Манайх жилдээ 7-8 хувийн инфляцтай байгаад байгаа. Гэтэл юмны үнэ, бараа материал, байр орон сууцын үнэ хэрхэн өсөж байгаа билээ. Бүгд харж байгаа. Тэгээд энэ бол юун 7, 8 хувь битгий хэл хэд дахин үнэ, ханш өсөөд байгаа юм. Тэгэхээр та бүхэн өнөөдөр хэрэглээний үнийн индекс, инфляц, хэрэглээний сагс гээд та бүхэн тооцож байгаа байх. Одоо бид нарын монголчуудын хэрэглээний сагсанд ер нь ямар ямар бүтээгдэхүүнүүд байна. Яг өнөөдрийн түвшинд. 10 жилийн өмнө ямар байж вэ. Энэ харьцуулаад, тухайн 10 жилийн өмнө ямар үнийн дүнтэй багцаар юу юу авч болж байсан юм. Өнөөдөр тэр дүнгээр юу юу авч болж байна вэ. Энэ сагсны талаар та нар сайхан тайлбарлачихмаар байна.

2 дугаарт нь энэ ажилгүйдэл мөн адил 5,9 хувь гэж байгаа байхгүй юу. Ажилгүйдэл. Гэтэл ер нь айл болгонд ер нь хэдэн ажилгүй хүмүүс байгаад байна. Бид нар бүгдээрээ л улс төрчид мэдэж байгаа. Ер нь айлуудад ажилгүйдэл ямар байдаг вэ. Тэгээд халамж бас маш их өгч байгаа. Монгол Улс чинь бараг халамж улс болчихлоо гээд яриад байна шүү дээ. Тэгээд энэ их халамж өгч байна гэдэг чинь ажилгүйдэлтэй л холбоотой байхгүй юу. Тэгээд үгүйдээ л энэ хөдөлмөр оролцоогоороо буюу бид нар нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, хүн амын орлогын албан татварыг чинь яг албан байгууллагаар, компаниар байгууллагаар хэдэн хүн төлөөд байгаа юм. Энэ чинь ажилгүйдлийн тоотой чинь ер нь хэр зохицож байна вэ. Ингээд халамж ихсээд байдаг. Энэ эрүүл мэндийн даатгал, хүн амын орлогын албан татвар төлж байгаа хүмүүсийнх нь тоо бага байгаад байдаг. Гэтэл ажилгүйдлийн тоо нь ийм 5,9 хувь гэчихсэн харьцангуй ийм зөрүүтэй тоонууд илэрхийлэгдээд байх шиг байна. Тэгэхээр бид нар бол энэ статистик, инфляцаа ч маш зөв тодорхойлох хэрэгтэй байна. Энэ ажилгүйдлээ ч гэсэн маш зөв гаргаж ирэх хэрэгтэй байна. Ингэж байж дараа дараачийнхаа алхмуудыг бид нар хийх хэрэгтэй. Шийдлүүдийг зөв гаргах хэрэгтэй. Энэ 2 асуудлыг та бүгдээс ямар аргачлалаар тооцдог юм бэ гэдэг талаар асууя.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 4 номерын микрофон.

Б.Батдаваа: Эрхэм гишүүн Пунсалмаагийн асуултад хариулъя. Инфляцыг бид тооцохдоо бол ОУВС-ийн жишиг гарын авлагын дагуу бусад улсууд дээр яг тооцдог аргачлалын дагуу тооцдог байгаа. Нийтдээ бол хэрэглээний сагс гээд бид нар хамгийн сүүлд бол 2023 оны суурьтайгаар тооцоогоо шинэчилсэн байгаа. Тухайн үед буюу 2023 онд Монгол Улсын дундаж өрхийн ашиглаж байгаа нийт зарлагын бүрэлдэхүүнийг ашиглаад, гол төлөөлөх бүтээгдэхүүн нийтдээ 430 бүтээгдэхүүн байгаа. Энэ бол Монгол Улсад хамгийн ихээр үйлдвэрлэгдэж байгаа болон импортлогдож байгаа, худалдаалагдаж байгаа бараануудыг сонгож ашигладаг. Үндсэндээ 430 бүтээгдэхүүнүүдийг дурдах юм бол нийт хэрэглээний зардлын 26 орчим хувь нь бол хүнсний бүтээгдэхүүн байдаг. Энэ дотроо талхнаас эхлээд талх гэхэд 2 төрөл, мах, сүү гээд ер нь бол өргөн хэрэглээний ихэнх бараа бүтээгдэхүүнүүд ороод явдаг.

Инфляцын түвшин 3 дугаар сарын байдлаар бол жилийн өсөлт 7,4 хувьтай гарсан байгаа. Мэдээж иргэдээс их шүүмжлэл ирдэг. Инфляцын түвшин юмны үнэ маш их өсөж байхад яагаад 1 оронтой тоотой байна гээд. Энэ дээр бол 2 шалтгаан байгаа.

1 дүгээрт 7,4 маань бол өнгөрсөн жилийн үнийн түвшинтэй энэ жилийн үнийн түвшнийг харьцуулж байгаа үзүүлэлт байгаа. Хэрвээ бид нар 2024 оны 12 сарын үнийн түвшинтэй өнөөдрийн 3 сарын үнийн түвшнийг харьцуулах юм бол үнийн өсөлт 17 орчмын өсөлттэй байгаа. Үнийн өсөлт дотроо бас барааны бүлгээрээ харилцан адилгүй байгаа. Тухайлбал, хүнсний барааны бүлэг бол хамгийн их анхаарал татаж байгаа буюу хамгийн асуудал болж байгаа үнийн өсөлт байна. Яагаад вэ гэхээрээ 3 дугаар сарын байдлаар хүнсний барааны үнийн өсөлт 14,1 хувьтай. Энэ дотор та бүхэн мэдэж байгаа. Махны үнэ бол үхрийн мах гэхэд 30 гаруй хувиар өсчихсөн ийм нөхцөл байдалтай байгаа. Хүнсний барааны үнийг бид нар бас 2024 оны 12 сартай харьцуулах юм бол 20 гаруй хувиар өсчихсөн ийм нөхцөл байдалтай байгаа. Тэгэхээр инфляц маань өөрөө харьцуулж байгаа жилийн өсөлтөөсөө шалтгаалаад 1 дүгээрт ийм байна.

2 дугаарт барааны бүлэг дотроо харилцан адилгүй байгаад байгаа.

Ажилгүйдлийн түвшнийг бол бид нар ажиллах хүчний судалгаа гээд жилдээ 10 гаруй мянган өрхөөс судалгаа аваад, ажилгүйдлийн түвшнийг гаргадаг. Ажилгүйдлийн түвшний хувьд бол манайх 5,6 маань бол харьцангуй тогтвортой байгаа. Бид нарын хувьд яг гишүүний асуулт дээр нэмээд хэлэхэд бол гол анхаарах ёстой юм нь ажиллах хүчний оролцооны түвшин байгаад байгаа юм. Яг олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гарсан ойлголт, тодорхойлолтоороо хөдөлмөрийн зах зээл дээр идэвхтэй байгаа хүн дотроосоо ажил идэвхтэй хайж боловч ажил олдоогүй хүнийг бид нар ажилгүй хүмүүс гэж үздэг. Хөдөлмөрийн зах зээл дээр оролцохгүй хүмүүс маш их байгаа. Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн насны 100 хүн тутмын хамгийн сүүлийн байдлаар 62,3 хувь нь хөдөлмөрийн зах зээл дээр идэвхтэй, үлдсэн 38 нь бол идэвхгүй .../минут дуусав/

Л.Соронзонболд: Гүйцээж хариулъя. 4 номерын микрофоныг нээе.

Б.Батдаваа: Энэ үлдсэн 38 хувь маань бол нийт хөдөлмөрийн насны хүн амаараа харах юм бол тухайн хүн амын тооноосоо хамаараад 800 гаруй мянган хүн байдаг. Үүний хамгийн том шалтгаан бол мэдээж тэтгэврийн насны хүмүүс байна. 2 дугаарт хүүхдээ харж байгаа эцэг, эхчүүд, 3 дугаарт бол оюутнууд байдаг. Үүнээс гадна бас хөдөлмөрийн насны хөдөлмөрийн зах зээл дээр идэвхтэй оролцохгүй бас маш олон 100 орчим мянган хүн байдаг. Тэгэхээр бид нар бол ажилгүйдлийн түвшнээс гадна ажиллах хүчний оролцооны түвшнээ харах ёстой байгаа. Манай энэ 62,3 хувь маань Вьетнам, Казахстан, Хятад гэх мэт улсууд дээр 66 хувь болоод өсчихсөн байдаг. Өөрөөр хэлбэл энэ 4 хувийн зөрүү маань 80-100 мянган хүнийг бид нар нэмж хөдөлмөрийн зах зээл дээр оруулах бусад улстай харьцуулахад ийм боломж байна гэж харагдаж байгаа гэсэн үг.

Л.Соронзонболд: Пунсалмаа гишүүн тодруулъя.

Б.Пунсалмаа: Тэгэхээр бид нар чинь ажил хайж байгаа иргэдээ л ажилгүйдлийнхээ тоонд оруулчихаж байна шүү дээ. Тийм ээ. Тэгэхээр ер нь бол яг идэвхгүй, ажил хайгаагүй энэ хүмүүсээ 800 гаруй мянган хүн байна гэж байна шүү дээ. Эд нарыгаа бид нар статистикийн тоон дотроо оруулаад бас нэг функт болгоод давхар судлаад, хараад ажиллах нь бас хэрэгтэй байх. Энэ тал дээр та бүхэн энэ жил статистикийн мэдээллийн чанарыг сайжруулах төлөвлөлтдөө энийг бас оруулчихна байх гэж бодож байна. Энэ аргачлалдаа нэмж оруулбал бас зүгээр байна шүү. Тэгээд 430 орчим бүтээгдэхүүнийг энэ хэрэглээний багцад та бүхэн авч тооцдог юм байна. Тэгэхээр 10 жилийн өмнөхөөр энэ 430 орчим багц нь ямар ямар бүтээгдэхүүн байсан юм. Хэрхэн өөрчлөгдсөн бэ гэдэг талаар надад бичгээр ирүүлээрэй гэж хүсэж байна. Баярлалаа.

Л.Соронзонболд: Санал хэллээ. Батнайрамдал гишүүн асуулт асууя.

О.Батнайрамдал: Та бүхэнд оройн мэнд хүргэе. Үндэсний статистикийн хорооны даргын тайланд сая миний дуртай хэд хэдэн үг нэлээн олон давтамжтай гарлаа. Олон улсын харьцуулалт байна. Дээрээс нь хиймэл оюун гэдэг үг бараг 10-аад удаа гарчихлаа. Тэрүүнд их сайшаалтай хандаж байна.

1 дүгээрт статистикийн энэ дата буцаад өгөгдлийн чанар, ашиглалт, хүртээмж энэ заавал олон улстай харьцуулж байж бид нар хаана явна гэдгээ харах ёстой. Тэгээд сая дурдсанаар бол бид нар чинь дэлхийд хүртээмжтэй байдлаараа, нээлттэй хүртээмжтэй байдлаар бол эхний 11-д ордог юм байна шүү дээ. Анх удаагаа Монгол дэлхийд топ 15-д ордог жишээ бараг танайхаас харж байна.

Тэгэхээр энэ өөрөө их сайн хэрэг л дээ. Дээрээс нь одоо дата өгөгдөл урьд нь цахимжилт гэж ярьдаг байсан бол одоо цахимжилт гэдэг үг хуучирсан. Одоо хиймэл оюун. Хиймэл оюун өөрөө ашиглагдах зарчим нь чанартай дата байж байж хиймэл оюуныг тултал нь ашиглах боломжтой. Тэгэхээр таны тайлан дотор сая хиймэл оюун гэдэг үг бараг 10-аад удаа ашиглагдлаа. Тэгэхээр энэ дээр бас тодруулж асуумаар байна. Яг хиймэл оюун энэ өгөгдлийн лабораторидоо ашиглаад яг ямар үр дүн гарч байна. Яг бодитой үр дүн хиймэл оюуныг ашигласнаараа гарч ирж чадаж байна уу. Буцаад энэ хиймэл оюунаас гарсан тэр дүгнэлтийг Засгийн газар гүйцэтгэх удирдлага дээр засаглал дээр хэрэгжүүлэх хэр боломжтой ийм үр дүн гарч байгаа юм бол. Энийг тодруулж асуумаар байна. Ялангуяа ийм нээлттэй хүртээмжтэй дата дээрээ бид нар хиймэл оюун ашиглаж чадахгүй бол бусад зүйл дээр хиймэл оюун ашиглана гэдэг бол надад аягүй бүрхэг харагдаад байгаа юм.

2 дугаарт сая миний асуултыг бас Пунсалмаа гишүүн асуучихлаа. Их зөв асуулт. Бид нар хэрэглээний үнийн индексийн сагсаа бол хэдэн жилийн өмнө өөрчилсөн гэж үзэж байгаа. Илүү амьдралд ойртсон гэж үзэж байгаа. Хуучиндаа бол тэр чинь А80 буюу дээр үеийн машинууд ашигладаг байсан. Одоо ашиглагддаггүй түлш хүртэл орчихсон л явдаг байсан. Энэ өөрчлөгдсөн гэж ойлгож байгаа юм.

2 дугаарт яг үүнтэй холбоотой хэрэглээний үнийн индексээс гадна ер нь энэ ядуурлын түвшин байна. Ядуурлын түвшин өнөөдөр бид нар 27, 28 хувьтай гэж байгаа юм. Энэ яг сүүлийн 10 жилийн хугацаанд хэр өөрчлөгдсөн байдаг юм бол. Яах вэ, ядуурлын түвшнээсээ илүүтэйгээр аргачлалын хувьд олон улсын жишигтэйгээ хэр ойролцоо, адилхан байдаг юм бол. 1 дүгээрт.

2 дугаарт дундаж давхарга гээд одоо яг үнэндээ хэлэхэд маргаантай. Монгол Улсын нийт хүн амын яг хэдэн хүнд дундаж давхарга гэдэг асуулт одоог хүртэл маргаан дагуулсан хэвээр байдаг. Тэгэхээр энэ дээр танайх бас хэмждэг юм болов уу. Энэ дээр бас нэмэлт хариулт авчхаад тодруулъя.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 4 номерын микрофоныг нээе.

Б.Батдаваа: Эрхэм гишүүн Батнайрамдалын асуултад хариулъя. Бид нар ерөнхийдөө энэ өгөгдөл гээд хиймэл оюуны бэлэн байдлыг хангах гээд төслийг бол энэ OSD болон энэ Дэлхийн банк, Gooale сангийн дэмжлэгтэйгээр бол ноднингоос эхлүүлсэн байгаа. Ер нь олон улсдаа энэ хиймэл оюуныг цаашдаа бид нар хөгжүүлэх, ашиглахын тулд гол суурь дэд бүтэц бол таны хэлдгээр бол өгөгдөл байгаа. Өгөгдөл чанартай бүрдүүлэхийн тулд бид нар юун дээр анхаарах ёстой вэ гэхээрээ хамгийн эхний асуудал бол мета дата байгаа. Өөрөөр хэлбэл гарч байгаа өгөгдөл нь өөрөө яаж бүрддэг вэ, ямар аргаар цуглуулагддаг вэ, ямар стандартаар бүрддэг вэ гэдгийг жишиг болсон салбар болгоны мета датаг бид нар бүрдүүлэх ёстой байгаа. Энэ хүрээнд бол бид нар мета өгөгдлийн нэгдсэн системийг хөгжүүлээд, дагаад Цахим хөгжил, харилцаа, холбооны яамтай хамтраад энэ мета өгөгдлийн стандартыг батлуулах ажлыг хэрэгжүүлж байна. Ингээд ирэхээрээ бид төрд байгаа энэ мэдээллүүдээ нэгтгээд, хувь хүний болон аж ахуйн нэгжийн түвшинд нэгтгээд, эмзэг мэдээллүүдийг нь арилгаад, эргээд судлаачдадаа төрийн гол байгууллагуудаа яваандаа гол нууцлалын асуудлуудаа бид нар хамгаалж чадах юм бол хувийн хэвшилд ч гэсэн нээлттэй өгөгдөл хэлбэрээр ашиглуулах боломжтой байгаа. Эндээс бол хиймэл оюун хөгжих бололцоо гарна гэж үзэж байгаа.

Яг статистикийн бид нар өнөөдөр үйлдвэрлэл болон мэдээлэл нийтэд түгээх тэр хиймэл оюуны ашиглалт ямар байна вэ гэхээр 1 дүгээрт бол бид нар 2024 оны сүүлээс бол чатбот нэвтрүүлсэн байгаа. Энэ дээр сайжруулах ажлууд бол байнга явагдаж байна. Яагаад вэ гэхээр энэ асууж байгаа, хариулж байгаа байдал маань бол буруу тоогоор ерөөсөө илэрхийлж болохгүй. Энэ дээр сайжруулах ажлууд байна.

2 дугаарт бид нар хиймэл дагуулын зураг ашиглаад түрүүн хэлдэг Google open buildings байна. Мал тооллого гэхэд видео дүрс бичлэгээс тоог нь аваад шууд гаргах гээд илүү нөгөө хиймэл оюуны 1 хэсэг буюу машин сургалтын аргаар тоонуудаа ингээд боловсруулах ажлууд дээр нэлээн хөгжүүлэлтүүдийг оруулаад явж байна. Эхнээсээ бол үр дүнгүүд бол гараад явж байгаа. Гэхдээ бид нар бас шийдэх асуудлууд байна. Юу вэ гэхээр манай нөгөө зайнаас мэдрэх асуудал дээр цаг агаарын нөхцөл байдал маань өөрөө яг нөгөө газар дээр мэдээлэл цуглуулалт дээр бол хүндрэлүүд үүсгэдэг. Ажиллах орчны нөхцөл байдлууд хүмүүсийн чадавх гээд ийм асуудлууд байгаа.

Ер нь бид нарын гол баримталж байгаа бодлого бол илүү датаг чанартай болгох төрийн мэдээллийн сангуудыг хооронд нь холбох ажлууд дээр бол анхаарч байна. Энэ маань өөрөө хиймэл оюуныг цаашдаа хувийн хэвшил авч явахад бол илүү үр дүнтэй ажил болно гэж бодож байна. Хэрэглээний үнийн сагсны хувьд бол энэ маань өмнө нь 5 жил тутам шинэчлэх буюу 5 жил тутам судалгааны үр дүнгээр өрхүүдийн иргэдийн хэрэглээнд орж байгаа өөрчлөлтийг тусгаж явдаг байсан. Энийг бид нар ОУВС-ийн .../минут дуусав/

Л.Соронзонболд: Хариултыг гүйцээж хариулъя. 4 номерын микрофоныг нэе.

Б.Батдаваа: Зөвлөмжөөр 2022 оноос эхлээд 3 жил тутам буюу илүү ойртуулах шийдвэр гарсан. Яагаад вэ гэхээр нийгмийн, хүмүүсийн хэрэглээний чиг хандлага маш хурдтай өөрчлөгдөж байгаа учраас энэ өөрчлөлтийг барьж авах зорилготой. 1990-ээд оноос бол 100-аад нэр төрлийн бүтээгдэхүүн хэрэглээний сагсанд байдаг байсан бол энэ маань өргөжсөөр байгаад 430 нэр төрлийн бүтээгдэхүүн болоод явж байгаа юм.

Ядуурлын түвшний хувьд бол хэрэглээнд суурилсан аргаар бол одоо бид нар тооцож, албан ёсны статистикаа Дэлхийн банктэй хамтарч зарладаг байгаа. Хэрэглээнд суурилсан аргаар ингээд тооцоход бол манай 1 гол анхаарах ёстой юм нь юу вэ гэхээр бид нар өмнө нь 2016 он, 2014 он хүртэл бол эдийн засгийн өсөлтийн 1 хувь тутам дээр ядуурлын түвшин 1 хувиар буурч байсан бол сүүлийн жилүүдэд ядуурлын бууралтын хувь бол бас илүү хөшингө болсон байгаа. Энэ дээр бид нар анхаарах ёстой. Мөн ядуурлын аргачлал дээр бол зөвхөн мөнгөн хэмжээсээр бол .../минут дуусав/

Л.Соронзонболд: Батнайрамдал гишүүн тодруулъя.

О.Батнайрамдал: Тэгвэл хэрэглээний үнийн сагсаа 3 жил тутам шинэчлэх юм байна. Яах вэ, тэгэхдээ бас бодох л хэрэгтэй л дээ. Их аймаар сүртэй өөрчлөлт бол орохгүй шүү дээ. Гэхдээ бид нар жил болгон харьцуулалт байхын тулд тэр 3 жил тутам өөрчлөгдөөд байх юм бол өмнөх 3 жилтэй харьцуулахад энэ чинь 2 өөр зүйл харьцуулах болж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр бас бодох л зүйл гэж бодож байна. 1 дүгээрт.

2 дугаарт бас сая энэ тайлангаас харж байна л даа. Бид нар халамж маш өндөр гээд байдаг боловч яг үнэндээ хэлэхэд нийгмийн халамжийн зардал 2024 оны гүйцэтгэлээр 90 хувь нь хүүхдийн мөнгө шүү дээ. Ерөөсөө хүүхдийн мөнгө л гэсэн үг. Үлдсэн нь бид нар нийт төсвийнхөө дүнгээр аваад үзэх юм бол жоохон л юм байгаа юм л даа. Зүгээр тэр халамжийн мөнгө маань буцаад хэр оновчтой шаардлагатай тэр эмзэг бүлгийнх нь шаардлагатай хүмүүстэй очиж байна гэдэг л асуудал байна гэж би хувьдаа боддог юм. Тэгэхээр бас энэ дээр гарч байна л даа. Ядуурлыг бууруулахад нөлөөлж буй ахиу нөлөөгөөр бол .../минут дуусав/

Л.Соронзонболд: Үг хэллээ. Надад хэдэн асуулт байна.

Энэ инфляцыг тооцоход хэрэглээний сагсанд 430 гаруй барааг оруулаад байна шүү дээ. Гэтэл яг энэ 430 барааг чинь бүгдийг нь хэрэглэдэг айл гэж тодорхой хувь нь байна. 90 бүтээгдэхүүнийг хэрэглэдэг айл байна. 200-г хэрэглэдэг айл байна. Энэ талын судалгаанууд хийдэг үү.

2 дугаарт энэ инфляцын үнийг тооцохдоо и-баримт гээд маш том систем төрийн хэмжээнд ашиглагдаж байгаа. И-баримтын дата систем дээр ашиглагдаж байгаа үнийн мэдээллийг та бүхэн ашигладаг уу гэдэг ийм асуулт.

2 дугаарт хиймэл оюун ухаан ашиглаад олон ажил хийж байгаа нь бол сайн байна. Гэхдээ яг энэ хиймэл оюун ухаанаа ашиглаад бизнес эрхлэгчдэд зориулсан тодорхой хэмжээний төлөвлөгөө төсөөлөл боловсруулахад нь шаардлагатай мэдээлэл гаргах энэ чиглэлээр ямар ажлууд хийж байна вэ.

3 дугаарт миний бие саяхан ОУВС-ийн Дэлхийн банкны хаврын хуралд оролцсон. Тэр дээр бүх улсууд энэ байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй хамааралтайгаар эдийн засаг, нийгэмд ямар өөрчлөлтүүд орж байгаа талаар ийм статистик мэдээллүүдийг гаргадаг болсон байна. Манай Монгол Улс бас мэдээллээ гаргаж өгсөн байна. Гэхдээ бусад улсуудын хувьд тодорхой мэдээллүүдээр 8 үзүүлэлт байсан. 8 үзүүлэлтүүдээр нь ороод харахаар бүх мэдээлэл нь өөрчлөгдөж байгаа. Манай Монгол Улс болохоор 1 л мэдээлэл өгчихсөн юм шиг байгаа юм. Өөрөөр хэлбэл цаад талынх нь мэдээлэл нь тэгж дэлгэрэнгүй задардаггүй байна гэж би харсан. Тэгэхээр одоо энэ байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эдийн засагт үзүүлж байгаа, нийгэмд үзүүлж байгаа энэ холбоотой мэдээлэл, үүнтэй холбоотой төсөөллийг гаргах талаар ер нь та бүхэн ямар ажлууд зохион байгуулж байна вэ гэсэн ийм асуулт байна. 4 номерын микрофоныг нээе.

Б.Батдаваа: Эрхэм гишүүн Соронзонболдын асуултад хариулъя. Хэрэглээний индексийг тооцохдоо бол бид нар 430 бүтээгдэхүүн нь бол яг улсын дундаж өрхийн хэрэглээний бүтцээр гарч ирж байгаа ийм үзүүлэлт байгаа. Дээрээс нь бид нар жил болгон, улирал тутам өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааг явуулдаг байгаа. Энэ судалгаагаар бол бид нар өрхийн хэрэглээ болон орлогоо тэнцүү 5 болон 10 бүлгүүдэд хуваагаад эдгээр өрхүүдийн хэрэглээнд эзлэх хүнсний бүлэг, хүнсний бус бүлэг, дотор нь хүнсний бус байлаа гэхэд тээвэр, шатахуун, хувцас гээд энэ бүлгүүдийн эзлэх хувийг бол гаргадаг. Үүнтэй нь уялдуулаад бид нар тухайн бүлгүүдийн үнийн өсөлт хэрэглээний сагс дотроо хэр өсөлттэй байна гэдгээр бас тооцож, бүлэг тус бүр дээр энэ инфляц маань өөрөө инфляцын сагс маань өөрөө 13 бүлгийн бүтээгдэхүүнтэй байдаг. Энэ бүлгүүдээр энэ бодит орлого болон хэрэглээн дээр гарч байгаа өөрчлөлтийг бол тооцох боломжийг гаргаж өгч мэдээлдэг байгаа. Бид нарын мэдээлж байгаа энэ дүн маань бол дундаж утгыг мэдээлж байгаа. Давхар бол энэ бүлгүүдээр задлаад, шинжилгээ хийх боломжтой

байдаг. Тухайлбал, хамгийн бага орлоготой нийт 20 хувийн хэрэглээнд эзлэх хүнсний бүлгийн дүн бол өндөр буюу 20 гаруй хувь байхад хамгийн өндөр 10 хувийнх бол 12 орчим хувьтай байдаг. Тэгэхээр түрүүний хэлдэг хүнсний инфляц асар өндөр байгаад байгаа нь өөрөө илүү бага орлоготой өрхүүд дээрээ илүү хүндрэл, дарамтыг учруулж байгаа гэж ойлгож болж байгаа.

Бид нар И-баримт болон НӨАТУС-ын систем болон НӨАТ-ыг статистикт ашиглах чиглэлээр бол НӨАТ-ын системийг ашиглахад бол голлох эдийн засгийн салбаруудын статистик мэдээллүүдээ бол зочид буудал, зоогийн газар, тээврийн салбар гэх мэт гол салбаруудаа гаргаад явж байгаа. НӨАТУС-ын мэдээлэл дээр анх бид нар ийшээ шилжихэд гарч байсан хүндрэл юу вэ гэхээрээ нийтдээ энэ дээр бүртгэлтэй 2 сая гаруй бараа бүтээгдэхүүн маань анх 2014 онд орохдоо ангилал кодгүйгээр орчихсон тийм хүндрэл байдаг. Өөрөөр хэлбэл талх өөрөө дэлгүүр болгон дээр өөр өөр кодоор бүртгэгдчихсэн ийм байдалтай байдаг. Энийг бид нар Гааль, татварын санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй хамтраад ангиллыг машин сургуулилтын аргаар ангилгах арга руу шилжүүлээд 87 хувийн оновчлолтой явж байгаа. Эндээс бид нар чанарын шаардлага хангасан зарим бүтээгдэхүүнүүдийг шууд хэрэглээний үнийн индекс дээр оруулахаар судлаад ажиллаж байгаа. Тэгэхдээ энэ маань бас яг бодит бид нарын зах, худалдааны төв дээр ажиглаж байгаа ажиглалтуудаас нөгөө хөнгөлөлтийн үнэ гээд жоохон зөрүүтэй мэдээллүүд гараад байдаг ийм асуудал байдаг.

Байгаль орчны статистик мэдээллийн хувьд бол байгаль орчин, эдийн засгийн системийн данс гээд байдаг. Энэ дээр бол бид нар энэ талаар ус ашиглалт, байгалийн нөөц ашиглалт гээд ийм данснуудыг бол байгуулаад мэдээлээд явж байгаа. Энэ ажил дээр бол бид нар чиглэлийн яам буюу Байгаль орчны яамтай бол илүү хамтарч ажиллах шаардлагатай байгаа.

Л.Соронзонболд: Бизнес эрхлэгчдэд мэдээлэл хиймэл оюун ухаан ашиглаж, ашиглуулах тал дээр юу хийж байна гэсэн шүү дээ. 4 номерын микрофоныг нэе.

Б.Батдаваа: Бизнес эрхлэгчдэд мэдээлэл бид нар илүү ашиглуулах зорилгоор өмнө нь бол зөвхөн аж ахуйн нэгжүүдээс мэдээлэл түүвэр судалгааны аргаар бүрдүүлдэг байсан. Одоо бид нар эхний салбаруудаасаа эхлээд тухайн мэдээлэл өгсөн аж ахуйн нэгжүүддээ эргээд тухайн салбарт нь хэчнээн аж ахуйн нэгж бий болж байгаа юм. Нийт дундаж борлуулалт, борлуулалтын тархалт, ашгийн маржин, ажилчдын тоо гээд ийм мэдээллүүдийг эргэж олгодог тийм тайлангийн систем хөгжүүлчхээд байгаа. Бид нарын гол зорилго түрүүн бас нөгөө танилцуулга дээр дурдсан. Ер нь энэ нөгөө аж ахуйн нэгжийн тооллого гээд олон улсдаа бол эдийн засгийн тооллого гэж явдаг. Өөрөөр хэлбэл салбараар аж ахуйн нэгжийн түвшинд засаг захиргааны хамгийн бага нэгжийн түвшинд бол татвар бусад нийгмийн даатгал гээд аж ахуйн нэгжтэй холбоотой бүх өгөгдлүүдийг нэгтгээд тэгээд гаргаж боловсруулах ийм мэдээлэл байгаа юм. Энийг бид нар энэ удаагийн тооллого одоо яг аж ахуйн нэгжийн тооллого явж байна. Эргээд энийг бид нар аж ахуйн нэгжүүд дээр илүү хялбар байдлаар хүргэх дээр анхаарч ажиллана. Энийг хүргэх 1 шийдэл нь бол хиймэл оюунд суурилсан чатботыг илүү задгай өгөгдөл дээр ажиллах чадвартайгаар хөгжүүлэх гэж харж байгаа. Яагаад вэ гэхээр манай 1212-ын хэрэглэгчид маань яг их дээд сургууль, судалгаа хийдэг төрийн байгууллагуудын байнгын ашиглалт хэрэглэлүүд дээр бол илүү хялбар буюу давуу байдалтай байдаг. Анх удаа орж байгаа хэрэглэгч дээр мэдээлэл хайхад жоохон хүндрэлтэй байдаг. Энийг бол шийдэх гол гарц нь бол хиймэл оюунд суурилсан статистик

мэдээлэл олгох ийм чатбот репорт гаргах ийм систем гэж бид нар бол ойлгож байгаа.

Л.Соронзонболд: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Үндэсний статистикийн хорооны 2025 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж дууслаа. Ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүд ажлын хэсэгт баярлалаа.

19.51 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ